



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр, Баасан гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2 - 39
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	40 - 154
<hr/>	
1. <b>“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	42 - 53
2. <b>Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	53 - 65
3. <b>Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</b>	66 - 88
4. <b>Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүн 2023.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн/</b>	88 - 89
5. <b>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</b>	89 - 92
6. <b>Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төсөл болон Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	93 - 121
7. <b>Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</b>	122 - 150
8. <b>Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</b>	150 - 154

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
6 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 45 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяаа, Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, Б.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Г.Ганболд, Т.Доржханд, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Х.Нямбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, Б.Чойжилсүрэн, Б.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Д.Батлут, Э.Батшугар;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярсайхан, Ц.Мөнхцэцэг, Ц.Цэрэнпунцаг;

Тасалсан: Ц.Анандбазар;

Хоцорсон: Х.Баделхан – 9 минут, С.Батболд – 1 цаг 11 минут, Ж.Бат-Эрдэнэ – 2 цаг 25 минут, Х.Болорчулуун – 8 минут, Н.Ганибал – 33 минут, М.Оюунчимэг – 2 цаг 23 минут, Ц.Сэргэлэн – 1 цаг 07 минут, Ж.Эрдэнэбат – 30 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүдэд хандан парламентын засаглалтай, парламентат ёсыг төлөвшүүлж байгаа улс орнуудын хувьд жил бүрийн 6 дугаар сарын 30-ны өдөр онцгойлсон тэмдэглэлт өдөр байдгийг дурдан, “Олон улсын парламентын өдөр”-ийн мэндчилгээ дэвшүүлэв. /алга ташив/

**Нэг. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтсийн ахлах шинжээч Х.Оюунцэцэг, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, мөн газрын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Судалгаа шинжилгээний албаны дарга Ц.Шинэбаяр, Мөрдөн шалгах хэлтсийн Гуравдугаар албаны дарга Ч.Жаргалбаатар, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, Судалгаа шинжилгээний албаны ажилтан Л.Хангарьд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрийн тавьсан асуултад Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр, Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албаны дарга Ц.Шинэбаяр нар хариулж, тайлбар хийв.

*“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

### **Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг тус тус Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Б.Баттөмөр, С.Ганбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 6  
Бүгд: 39  
84.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.2 дахь хэсгийн 5.2.1 дэх заалтын “шинэ шатанд хүргэнэ” гэснийг “өргөжүүлнэ” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.3 дахь заалтын “олон улсын” гэснийг “гадаад” гэж өөрчилж, зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.5 дахь заалтын “мөнгө угаах,” гэснийг хасаж, зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.6.Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийн урсгал зардлыг өмнөх оны батлагдсан төсвөөс бууруулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37  
Татгалзсан: 3  
Бүгд: 40  
92.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтын “хугацаанаас өмнө” гэсний өмнө “шүүхийн магадлалаар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 38  
Татгалзсан: 2  
Бүгд: 40

95.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр олгох батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 38

Татгалзсан: 2

Бүгд: 40

95.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 11 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамьянхүү, Монголын Үндэсний бөхийн холбооны тэргүүн Ц.Магалжав, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Д.Мөнхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь нар танилцуулав.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 28 минутаас хуралдааныг даргалав.*

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, С.Ганбаатар, Б.Бейсен нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Монголын Үндэсний бөхийн холбооны тэргүүн Ц.Магалжав, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Д.Мөнхболд нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, С.Амарсайхан нар үг хэлэв.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 16  
Бүгд: 41  
61.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 12 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Х.Алтангэрэл, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Нарантуяа, мөн газрын Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газрын дарга С.Батхуяг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Ц.Идэрбат, Г.Тэмүүлэн, Н.Ганибал, С.Ганбаатар, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Нарантуяа, мөн газрын Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газрын дарга С.Батхуяг нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Н.Ганибал, Т.Энхтүвшин нар үг хэлэв.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19  
Татгалзсан: 20  
Бүгд: 39  
48.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 17  
Бүгд: 38  
55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 17  
Бүгд: 38  
55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 13 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

*Дөрөв.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүн 2023.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	18
Бүгд:	39

53.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 35 минут үргэлжилж, 13 цаг 20 минутад завсарлав.*

*Үдээс хойших хуралдаан 14 цаг 37 минутад эхлэв.*

*Тав.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Ө.Бодьгэрэл, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга З.Батболд, мөн хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх А.Нинжин нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн газрын референт Д.Нямбаяр нар байлцав.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс саналууд гарсантай холбогдуулан нарийвчлан ярилцах шаардлага гарсан тул хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах гэсэн горимын санал гаргав.



Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.8-д заасны дагуу горимын саналаар санал хураалт явуулав.*

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн П.Анужингийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.*

**Зургаа.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төсөл болон Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, мөн яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга Х.Тамир, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Боловсролын бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын шинжээч Ж.Нарантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй, Боловсрол судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор Ш.Ариунаа, Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш Э.Чойсүрэн, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга З.Цогтгэрэл, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, Р.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, О.Цогтгэрэл, С.Ганбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг үг хэлж, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.10-г заасны дагуу санал хураалтад оролцох боломжгүйг хуралдаан даргалагчид мэдэгдэв.

*Боловсролын ерөнхий хуультай хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаар боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
дэмжсэн санал:**

**Л.Мөнхбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Э.Батшугар, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ч.Ундрам, С.Чинзориг, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгаа, санхүүжилт, эдгээртэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	12
Бүгд:	40

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.1.Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэн бэлтгэхэд оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	15
Бүгд:	40

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 12  
Бүгд: 40  
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “дээд боловсролын” гэсний дараа “сургалтын байгууллагын” гэж, 4.1.3 дахь заалтын “төлбөр” гэсний дараа “судалгааны болон” гэж нэмж, 4.1.1 дэх заалтын “дипломын” гэснийг “дэд бакалаврын” гэж 4.1.2 дахь заалтын “магистр, докторын хөтөлбөрийн сургалтыг” гэснийг “магистрын болон докторын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг” гэж, 4.1.4 дэх заалтын “олгогдох” гэснийг “суралцагчид олгох” гэж өөрчилж, 4.1.5 4.1.6 дахь заалтыг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.7-4.1.10 дахь заалт нэмэх:

“4.1.7.“сургалтын төлбөрийн хөнгөлөлт” гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн сурлагын амжилт, төлбөрийн чадамжийг тооцож төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг;

4.1.8.“шаталсан сургалт” гэж боловсролын бусад түвшний хөтөлбөрийг зэрэгцсэн болон дараалсан байдлаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.9.“судалгааны грант” гэж Инновацын тухай хуулийн 3.1.7-д зааснаас гадна байгууллага, судлаачийн судалгааны ажилд зориулж иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллагаас урьдчилан нөхцөл, болзолтой буцалтгүй олгох мөнгөн, мөнгөн бус хөрөнгийг;

4.1.10.“судалгааны их сургууль” гэж судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг, бакалавр болон ахисан түвшний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллагыг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 13  
Бүгд: 40  
67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 5 дугаар зүйл нэмэх:

**“5 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаандаа баримтлах зарчим**

5.1.Дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

5.1.1.Эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;  
5.1.2.оюуны бүтээл, судалгааны ёс зүйг дээдлэх;

5.1.3.дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг дэмжсэн байх;

5.1.4.хамтын удирдлагатай, улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 14  
Бүгд: 40

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийн “БОЛОВСРОЛЫН” гэсний дараа “СУРГАЛТЫН” гэж нэмж /цаашид тохиолдол бүрд/, төслийн 5.1 дэх хэсгийн “гэсэн ангилалтай” гэснийг, мөн зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 5.5, 5.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.7-5.9 дэх хэсэг нэмэх:

“5.5.Энэ хуулийн 5.1, 6.7-д заасан дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг техникийн зохицуулалтад үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

5.6.Цэрэг, цагдаагийн мэргэжлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 3.1.19-д заасан төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага эрхэлнэ.

5.7.Энэ хуулийн 5.1, 6.7-д заасан дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалтыг Засгийн газар батална.

5.8.Консерватор нь ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, техникийн болон дээд боловсрол эзэмшүүлэх шаталсан сургалттай хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллага байна.

5.9.Технологийн коллеж нь бүрэн дунд боловсрол, техникийн болон дээд боловсролын шаталсан сургалттай, дэд бакалавр, бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллага байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 16  
Бүгд: 40

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 6.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 6.1, 6.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.7-6.11 дэх хэсэг нэмэх:

“6.1.Их сургууль нь дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

6.5.Их сургууль нь харьяалалтай коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, судалгааны лаборатори, төв, хүрээлэн, ахлах сургууль, дадлагын баазтай байж болно.

6.7.Их сургуулийг үйл ажиллагааны хүрээ, сургалт, судалгааны чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагч, төгсөгчийн тоо, холбогдох бусад үзүүлэлтэд үндэслэн судалгааны, сургалтын, мэргэжлийн гэж ангилна.

6.8.Их сургууль нь сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор байж болно.

6.9.Багш бэлтгэх их сургууль нь харьяалалдаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

6.10.Соёл, урлаг, цэргийн мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль нь бүрэн дунд сургуультай /6-12 дугаар анги/ байж болно.

6.11.Судалгааны их сургуулийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 13

Бүгд: 40

67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалтын” гэснийг “дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгааны” гэж, 7.4 дэх хэсгийн “боловсрол, сургалтын байгууллагатай” гэснийг “боловсролын сургууль, ахлах сургуультай” гэж өөрчилж, 7.2, 7.3, 7.5 дахь хэсгийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 13

Бүгд: 40

67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.2 дахь хэсгийг төслөөс хасах:

“8.1.Коллеж нь дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт-судалгаа, сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

8.3.Коллеж нь харьяалалдаа политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, ахлах сургуультай байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 14

Бүгд: 40

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “зөвшөөрөл” гэсний өмнөх “, тусгай” гэснийг хасаж, 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр харьяаллын сургуульд байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	13
Бүгд:	40

67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Эрдмийн зөвлөл,” гэсний дараа “Хөтөлбөрийн хороо,” гэж, 10.3 дахь хэсгийн “Эрдмийн” гэсний дараа “зөвлөл болон хөтөлбөрийн хороо,” гэж нэмж, төслийн 10.5 дахь хэсгийн “Төрийн өмчийн” гэснийг, мөн зүйлийн 10.4, 10.6, 10.7, 10.9, 10.11, 10.15 дахь хэсгийг төслөөс хасаж, 10.14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.16-10.18 дахь хэсэг нэмэх:

“10.14.Дээд боловсролын сургалтын байгууллага нь дотуур байртай байж болно. Дотуур байранд тавих шаардлагыг стандарт, техникийн зохицуулалтаар тогтооно.

10.16.Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлэх, сайжруулах дүгнэлт, санал гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хөтөлбөрийн хороотой байна.

10.17.Энэ хуулийн 10.5-д заасан их сургуулийн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлж болно.

10.18.Энэ хуулийн 9.2-т заасан дээд боловсролын сургалтын байгууллага нь цэрэг, цагдаагийн тогтолцоонд хамаарах анги, байгууллага, цэргийн байртай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	16
Бүгд:	40

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг 18 дугаар зүйл болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“18 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт**

18.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт бүрэн дунд боловсрол эзэмшсэн, элсэлтийн шаардлага хангасан хүнийг элсүүлнэ.

18.2. Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч тухайн мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэхэд энэ хуулийн 18.1 дэх хэсэг хамаарахгүй.

18.3. Боловсролын ерөнхий хуулийн 17.8, энэ хуулийн 18.8-д заасан үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.4. Дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэгчийн элсэлтийн шалгалтын босго оноог өмчийн хэлбэр харгалзахгүйгээр боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ижил хэмжээгээр тогтооно.

18.5. Элсэлтийн шалгалтын босго оноог шинэчлэхэд өмнөх босго оноог бууруулахгүйгээр тогтооно.

18.6. Дээд боловсролын сургалтын байгууллага мэргэжил эзэмшихэд шаардагдах мэдлэг, ур чадварыг харгалзан элсэлтийн нэмэлт шалгалт зохион байгуулж болно.

18.7. Ахисан түвшний сургалтад элсэгч, суралцагчид тавих шаардлага, элсэлтийн шалгалтыг сургуулийн дотоод журмаар зохицуулна.

18.8. Элсэлтийн шалгалтын зохион байгуулалт, үнэлгээний арга зүйг олон улсын чиг хандлагад нийцүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	28
Татгалзсан:	12
Бүгд:	40
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.	

13. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн гарчгийн “Чанарын баталгаажуулалт” гэсний өмнө “Дээд боловсролын” гэж нэмж, 12.1 дэх хэсгийн “үйл ажиллагааны” гэснийг, мөн зүйлийн 12.5, 12.6, 12.9, 12.12 дахь хэсгийг төслөөс хасаж, төслийн 12.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 12.13-12.18 дахь хэсэг нэмэх:

“12.8. Дээд боловсролын сургалтын байгууллага, Боловсролын ерөнхий хуулийн 12.4, энэ хуулийн 12.16-д заасан хөтөлбөр, тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг 5 жил тутамд магадлан итгэмжилнэ.

12.13. Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг энэ хуулийн 12.18-д заасан цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран хоёр жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ.

12.14. Энэ хуулийн 12.13-т заасан хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.15. Анагаах ухааны мэргэжлийн чиглэлийн сургалтын хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

12.16.Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансааны үзүүлэлт тухайн байгууллагын суралцагчид хуульд заасан дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох үндэслэл болно.

12.17.Дээд боловсролын цахим мэдээллийн сан нь Боловсролын ерөнхий хуулийн 48.3-т зааснаас гадна магадлан итгэмжлэл, эрдэм шинжилгээний бүтээл, санхүүжилт, иргэний гадаад улсад эзэмшсэн боловсрол, үнэлгээ, хөдөлмөр эрхлэлт зэрэг мэдээллээс бүрдэнэ.

12.18.Энэ хуулийн 12.8-д заасан хугацаагаар 3 удаа магадлан итгэмжлэл хийлгэсэн дээд боловсролын сургалтын байгууллага цаашид 10 жил тутам магадлан итгэмжлэл хийлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 14

Бүгд: 39

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “эрдэм шинжилгээ” гэснийг “судалгааны ажилд оролцох, бусад сургуулийн суралцагч, багштай хамтран” гэж өөрчилж, төслийн 13.1.6 дахь заалтын “баялаг болгон хувиргах” гэснийг, мөн зүйлийн 13.1.4, 13.1.7 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 13.1.10, 13.1.11 дэх заалт нэмэх:

“13.1.10.улиралд судлах багц цагийг сонгож, суралцах хугацааг төлөвлөх;

13.1.11.ижил түвшний бусад сургуулийн хичээл болон багшийг сонгон суралцах, багц цагийг дүйцүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 13

Бүгд: 39

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.1.4 дэх заалт нэмэх:

“14.1.4.хууль тогтоомжид заасан сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 14

Бүгд: 40

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “Суралцагчийн сургалтын үнэлгээ” гэсэн 15 дугаар зүйлийг 21 дүгээр зүйл болгон шилжүүлж доор дурдсанаар өөрчлөн найруулах:



## “21 дүгээр зүйл.Суралцагчийн үнэлгээ, төгсөлт

21.1.Суралцагчийн үнэлгээ нь суралцахуйн үр дүнг бататгах, бие даан суралцах үйл ажиллагаа, бүтээлч хандлагыг дэмжих, авьяас, ур чадварыг хөгжүүлж урамшуулахад чиглэнэ.

21.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын онцлогоос хамааран суралцагчийн судалгааны ажлын үр дүн, суралцаж буй мэргэжлийн чиглэлээр олон улсын тэмцээн, уралдаанд гарсан амжилтыг багц цагт тооцож болно.

21.3.Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцахуйн үр дүнг үнэлэх үйл ажиллагааг энэ хуулийн 15.4-т заасан журмаар Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогчийн төлөөлөл хамтран хэрэгжүүлнэ.

21.5.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид диплом олгох, хүчингүй болгох, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчийн дипломыг хүлээн зөвшөөрөх, бүртгэх, баталгаажуулахтай холбогдсон харилцааг Боловсролын ерөнхий хуулийн 30.1.31-д заасан журмаар зохицуулна.

21.6.Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод журмаар, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	14
Бүгд:	40

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “хичээлийг” гэснийг “хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, “багш заана” гэснийг “байна” гэж өөрчилж, 16.3 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 16.2, 16.5 дахь хэсэг нэмэх:

“16.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна.

16.5.Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн хөгжлийг хангах журмыг баталж, хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	16
Бүгд:	40

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.2.3 дахь заалт нэмэх:

“17.2.3.судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	27
Татгалзсан:	13
Бүгд:	40

67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан 18.2 дахь хэсэг нэмж, мөн зүйлийн 18.1.4 дэх заалтыг 18.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тухайн ажиллаж байгаа байгууллагаас дараах дэмжлэгийг үзүүлж болно:

18.2.1.орон нутаг дахь төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багш, ажилтанд орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг 5 жил тутамд нэг удаа олгох;

18.2.2.дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багшид Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16.1.2-т заасан тэтгэмж олгох.

18.3.Энэ хуулийн 18.2.1, 18.2.2-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбогдсон бусад харилцааг тухайн сургалтын байгууллагын дотоод журмаар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	16
Бүгд:	40

60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “Сургалтын зохион байгуулалт” гэсэн 21 дүгээр зүйлийг 19 дүгээр зүйл болгож, төслийн 21.2. дахь хэсгийн “Магистр, докторын сургалтын” гэснийг “Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт,” гэж өөрчилж, мөн зүйлийн 21.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 21.5-21.8 дахь хэсэг нэмэх:

“21.3.Дээд боловсролын сургалтын байгууллагын хичээлийн жил нь улиралд хуваагдах бөгөөд 2-4 улиралтай байж болно. Суралцах хугацааг элсэлтийн шалгалттай уялдуулан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөөр тогтооно.

21.5.Суралцагч элссэн мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт суралцах хугацаанд бусад мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт давхар суралцаж хос мэргэжил эзэмшиж болно.

21.6.Дээд боловсролын сургалтын байгууллага нь ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

21.7.Дээд боловсролын сургалтын байгууллага нь төгсөгчийн мэргэжлийн хөгжлийг хангах, насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

21.8.Дээд боловсролын сургалтын байгууллага нь бие даан, эсхүл хамтран цахим сургалтын системийг бүрдүүлэн сургалт зохион байгуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 14

Бүгд: 40

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “Сургалтын хөтөлбөр” гэсэн 19 дүгээр зүйлд “Сургалтын хөтөлбөрийн агуулга” гэсэн 20 дугаар зүйлийг нэгтгэн “Сургалтын хөтөлбөр, агуулга” гэсэн 20 дугаар зүйл болгож, төслийн 19.1 дэх хэсгийг төслөөс хасаж, төслийн 20.2 дахь хэсгийн “Сургалтын хөтөлбөрийн агуулга нь” гэснийг “Дэд бакалавр, бакалаврын сургалтын хөтөлбөрт” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 19.9-19.16 дахь хэсэг нэмж, төслийн 20.3, 20.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.9.Сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.10.Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн хүсэлтээр энэ хуулийн 19.2-т заасан журмын дагуу бакалавр-магистрын 150-иас, магистр-докторын 90-ээс доошгүй багц цаг бүхий нэгдмэл агуулгатай хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

19.11.Энэ хуулийн 19.10-т заасан нэгдмэл хөтөлбөрөөр суралцсан төгсөгчид тухайн түвшин бүрийн боловсролын баримт бичгийг олгоно.

19.12.Бакалаврын хөтөлбөрт суралцаж 90 багц цаг судалсан боловч цаашид суралцах боломжгүй болсон суралцагчид дэд бакалаврын зэрэг олгоход тавих шаардлагыг хангасан тохиолдолд тухайн боловсролын баримт бичгийг дүйцүүлэн олгож болно.

19.13.Боловсролын ерөнхий хуулийн 3.1.4-т заасан багц цаг нь дээд боловсрол эзэмшихэд тавих шаардлага, сургалтын төлөвлөгөө, төлбөр, багшийн ажлын ачаалал зэргийг тогтоох үндэслэл болно.

19.14.Боловсролын ерөнхий хуулийн 30.1.10-д заасан дээд боловсролын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн индексийн жагсаалтыг 5 жил тутам шинэчлэн батална.

19.15.Сургалтын хөтөлбөрийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, төгсөгчийн төлөөллөөс бүрдсэн энэ хуулийн 10.2-т заасан хөтөлбөрийн хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

19.16.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцахад хөтөлбөрийн агуулга, багц цаг дүйцүүлэн тооцож болно.

20.3.Дээд боловсролын түвшин нь багц цагаар хэмжигдэх дэд бакалаврын, бакалаврын, магистрын, докторын зэрэгтэй байна.

20.4.Багц цагийн хэмжээ нь дэд бакалаврын зэрэгт 90 багц цагаас доошгүй, бакалаврын зэрэгт 120 багц цагаас доошгүй, магистрын зэрэгт 30 багц цагаас доошгүй, докторын зэрэгт 60 багц цагаас доошгүй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд “ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ИННОВАЦИ” гэсэн ТАВДУГААР БҮЛЭГ нэмж, төслийн 22 дугаар зүйлийг тус бүлэгт хамааруулан, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 22.8 дахь хэсэг нэмэх:

“22.8.Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15

Бүгд: 40

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 23 дугаар зүйл нэмэх:

### “23 дугаар зүйл.Судалгааны ёс зүй

“23.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, суралцагчийн эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглахтай холбогдох үйл ажиллагааг Шинжлэх ухаан, технологийн сан хариуцна.

23.2.Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23.3.Дээд боловсролын судалгааны ёс зүйг Боловсролын ерөнхий хуулийн 27.4-д заасан судалгааны ёс зүйн дэд хороо хариуцна.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан дэд хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.4.1.судалгааны ажилд оюуны өмч, зохиогчийн эрхийг зөрчихгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаар дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх журам, заавар, зөвлөмж боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

23.4.2.судлаачийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан хэлэлцэх, хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 14  
Бүгд: 40  
65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар бүлгийг 6 дугаар бүлэг болгож, төслийн 23.1 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд” гэснийг хасаж, 23.1.4 дэх заалтын “зэрэг” гэсний дараа “, цол” гэж нэмж, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 23.1, 23.3, 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.1.Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.

23.3.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага нь хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй байж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан нэгжийг Засгийн газар байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 13  
Бүгд: 40  
67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“24 дүгээр зүйл. Дээд боловсролын зөвлөл**

24.1.Дээд боловсролын салбарт Боловсролын ерөнхий хуулийн 27.4-д заасан мэргэжлийн зөвлөл нь Дээд боловсролын зөвлөл байна.

24.2.Дээд боловсролын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгааны үйл ажиллагаа, үр дүнг хэлэлцэх, санал зөвлөмж гаргах, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага байна.

24.3.Зөвлөл нь төрийн, дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага болон үйлдвэр, аж ахуйн нэгж, оюутны төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байна.

24.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Боловсролын ерөнхий хуулийн 27.6-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 14  
Бүгд: 40  
65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.4-25.7, 25.9 дэх хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлийн 25.10-25.13 дахь хэсэг нэмж, 25.2, 25.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.2.Удирдах зөвлөл нь эцсийн өмчлөгч буюу үүсгэн байгуулагч, тухайн сургуулийн багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.

25.3.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл найм, багшийн төлөөлөл гурав, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл гурав, суралцагчийн төлөөлөл нэг байна.

25.10.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн энэ хуулийн 25.3-т заасан төлөөллийн оролцоог хангасан байна.

25.11.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага дундын удирдах зөвлөл байгуулж болно. Энэ тохиолдолд энэ хуулийн 25.3-д заасан төлөөллийг оролцуулсан байна.

25.12.Энэ хуулийн 25.11-д заасан Удирдах зөвлөл байгуулах тохиолдолд зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

25.13.Энэ хуулийн 25.1-д заасан Удирдах зөвлөлийн даргыг сонгох, гишүүнээр ажиллах, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болгох, дарга, гишүүнийг эргүүлэн татахтай холбогдох харилцааг зохицуулах нийтлэг дүрмийг боловсролын асуудлаар эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Л.Энх-Амгалан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 16  
Бүгд: 40  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын “журмын дагуу” гэсний дараа “төрөөс хараат бусаар” гэж нэмж, 26.1.10 дахь заалт, 26.3, 26.4 дэх хэсгийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 27 дугаар зүйл нэмэх:

**“27 дугаар зүйл.Эрдмийн зөвлөл**

27.1.Эрдмийн зөвлөл нь 21-ээс доошгүй гишүүнээс бүрдэх бөгөөд гишүүнээр эрдмийн зэрэг, цолтой багшийг үндсэн орон тооны нийт багш нарын төлөөллөөс сонгоно.

27.2.Эрдмийн зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.2.1.сургалт, судалгааны чиглэлийг тогтоох, хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, дүгнэлт гаргах;

27.2.2.дэд профессор, профессор, хүндэт цол олгох;

27.2.3.судалгааны төсөл болон ахисан түвшний сургалт судалгааны үр дүнг хэлэлцэх, дүгнэх;

27.3.Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох бусад харилцааг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

27.4.Эрдмийн зөвлөл нь сургалт, эрдэм шинжилгээний бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15

Бүгд: 40

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 27.4 дэх хэсгийн “цагдаа, аюулгүй байдлын” гэснийг “цагдаагийн” гэж, “хууль тогтоомжид” гэснийг “хуульд” гэж өөрчилж, мөн хэсгийн “тус тус” гэснийг хасаж, мөн зүйлийн 27.2, 27.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 27.7 дахь хэсэг нэмэх:

“27.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага нь дээд сургууль, коллежид захирал /цаашид “захирал” гэх/, их сургуульд ректор /цаашид “ректор” гэх/ байна.

27.7.Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 14  
Бүгд: 40  
65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28.1.9 дэх заалтын “бусад харилцааг” гэсний дараа “сургуулийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40  
62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, 29.1.1 дэх заалтын “төрөөс болон удирдах зөвлөлөөс” гэснийг “эрх бүхий этгээдийн” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 29.2 дахь хэсэг нэмэх:

“29.2.Дээд боловсролын сургалтын байгууллага доор дурдсан хамтын ажиллагааг бэхжүүлэх үүрэгтэй:

29.2.1.олон улсад өрсөлдөх чадвартай багшлах хүний нөөцийг бэлтгэх, дэмжих;

29.2.2.онцгой авьяастай суралцагчийг дэмжих, авьяасыг хөгжүүлэх хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх;

29.2.3.дээд боловсролын сургалтын байгууллага хооронд харилцан тохиролцсон бусад хэлбэр.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 16  
Бүгд: 40  
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30.1 дэх хэсгийн “байгууллагын санхүүжилт нь” гэсний дараа “Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, 30.1.2 дахь заалтын “олон улсын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “сангуудаас татах” гэснийг “сангаас олгох” гэж өөрчилж, мөн заалтын “албан ёсны зээл” гэснийг хасаж, 30.1.4 дэх заалтын “их, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж, “компаниас орох” гэснийг “компанийн үйл ажиллагаанаас орсон” гэж өөрчилж, 30.1.7 дахь заалтын “олсон орлого” гэсний дараа “, гэрээт ажил, үйлчилгээ, түрээс, аж ахуйн үйл ажиллагаанаас орсон орлого” гэж нэмж, 30.1.5, 30.1.6, 30.1.8 дахь заалт, 30.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 30.1.10-30.1.15 дахь заалт, 30.6-30.10 дахь хэсэг нэмж, төслийн 30.2, 30.3 дахь хэсгийг нэгтгэн 30.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.10.хүүгийн орлого;  
30.1.11.байгууллагын болон судалгааны грант;  
30.1.12.өрсөлдөөнт төсөл;



30.1.13.их сургуулийн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс олгосон орлого;

30.1.14.хөрөнгө оруулалтын зээл;

30.1.15.орон нутгийн төсвийн дэмжлэг.

30.2.Дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс дараах дэмжлэг үзүүлнэ:

30.2.1.тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагчид олгох сургалт, судалгааны тэтгэлэг;

30.2.2.улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдол бүхий Засгийн газрын захиалгат судалгаа шинжилгээ, дэвшилтэт технологи дамжуулалт болон инновацын үйл ажиллагааны зардал;

30.2.3.төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардал;

30.4.Энэ хуулийн 30.1.1-30.1.15-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогыг захиран зарцуулах журмыг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл батална.”

30.6.Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.7.Энэ хуулийн 5.8-д заасан дээд боловсролын сургалтын байгууллага нь хуулиар зөвшөөрсөн нийтлэг санхүүжилтийн эх үүсвэрээс гадна үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэл, онцлогоос хамаарч улсын төсвийн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэртэй байж болох бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.

30.8.Аймаг, нийслэлийн удирдлага дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид хуульд заасан санхүүгийн дэмжлэг олгож болох бөгөөд санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээ, олгох нөхцөл, журмыг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтоож, тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

30.9.Энэ хуулийн 30.2-т заасан зардлыг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлнэ.

30.10.Энэ хуулийн 30.2-т заасан зардлыг санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Л.Энх-Амгалан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 31.2, 31.3 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 31.1.5 дахь заалт нэмэх:

“31.1.5.дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 14  
Бүгд: 40  
65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 14  
Бүгд: 40  
65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг агуулгын хувьд эрэмбэлэн, үг, найруулгыг жигдлэх, хууль зүйн техникийн болон бусад засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 17  
Бүгд: 40  
57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төсөл болон Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.*

***Долоо.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр,

Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, мөн яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга Х.Тамир, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Боловсролын бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын шинжээч Ж.Нарантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй, Боловсрол судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор Ш.Ариунаа, Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш Э.Чойсүрэн, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга З.Цогтгэрэл, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, Р.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт А.Хонгорзул, Н.Монголмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 16 цаг 32 минутаас хуралдааныг даргалав.*

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, М.Оюунчимэг, Ж.Чинбүрэн, Ц.Туваан нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, мөн яамны Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа нар хариулж, тайлбар хийв.

*Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны**  
**дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Э.Батшугар, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ч.Ундрам, С.Чинзориг, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “ахисан түвшний чадамжийг” гэснийг “чадамжийг” гэж, 3.1.9 дэх заалтын “богино хугацааны сургалтыг” гэснийг “сургалтыг” гэж, 3.1.11 дэх заалтын “өмнө эзэмшсэн мэдлэг” гэснийг

“эзэмшсэн мэдлэг, ур чадвар” гэж, “мэдлэг, ур чадварыг” гэснийг “чадамжийг” гэж өөрчилж, 3.1.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.12.“дадлагажуулагч” гэж суралцагчийг үйлдвэрлэлийн орчинд дагалдуулан сургах, ур чадвар эзэмшүүлэх үүрэг бүхий арга зүйн сургалтад хамрагдсан ажилтныг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго нь нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий иргэн бэлтгэж, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3 дахь заалт, 5.1.4 дэх заалтын “нийгмийн” гэснийг тус тус төслөөс хасаж, доор дурдсан агуулгатай 5.1.5, 5.1.6 дахь заалт нэмэх:

“5.1.5.хөгжлийн бодлогод нийцсэн байх;

5.1.6.хөдөлмөр эрхлэлт, ур чадварын хөгжлийг дэмжсэн байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 13

Бүгд: 38

65.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн “6.3,” гэснийг төслөөс хасаж, 6.2 дахь хэсгийн “бие даан ажил” гэснийг “хувиараа” гэж /цаашид тохиолдол бүрд/, 6.5 дахь хэсгийн “хэмжих ба багц цагийг дараагийн түвшний боловсролд тооцож дүйцүүлнэ” гэснийг “тооцох бөгөөд дараагийн боловсролын түвшинд дүйцүүлнэ” гэж, 6.6 дахь хэсгийн “багц цаг” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсролын багц цаг” гэж, 6.8 дахь хэсгийн “ажил олгогчийн” гэснийг “түншлэлийн” гэж өөрчилж, 6.14 дэх хэсгийн “тусгай” гэснийг хасах гэсэн ажлын хэсгийн гаргасан 4 дэх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг санал хэлэв.

**Г.Занданшатар:** 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “тавигдах” гэснийг “тавих нийтлэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 13

Бүгд: 39

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Үнэлгээ, баталгаажуулалт” гэснийг “Чанарын баталгаажуулалт” гэж, 8.2 дахь хэсгийн “Хүний өмнөх мэдлэг, ур чадвар, чадамжийг” гэснийг “Эзэмшсэн мэдлэг, ур чадварыг” гэж өөрчилж, 8.1 дэх хэсгийн “суралцагч” гэсний өмнө “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7 дахь хэсгийг нэмэх.

“8.3.Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.4.Магадлан итгэмжлэлийг Боловсролын ерөнхий хуулийн 17.12-т заасан байгууллага мөн хуулийн 30.1.12-т заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

8.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг таван жил тутам магадлан итгэмжилнэ.

8.6.Боловсролын ерөнхий хуулийн 29.1.8-д заасан мэргэжлийн болон техникийн боловсролыг эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага Боловсролын ерөнхий хуулийн 40.7-д заасны дагуу дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.” гэсэн ажлын хэсгийн гаргасан 6 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

**Г.Занданшатар:** 7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “түвшинтэй” гэснийг “ангилалтай” гэж, 9.14 дэх хэсгийн “дадлагын баазад” гэснийг “чадамжийн төв, дадлагын баазад” гэж, 9.15 дахь хэсгийн “төв, бааз, аж ахуй” гэснийг “чадамжийн төв, дадлагын бааз, туслах аж ахуй” гэж өөрчилж, 9.12, 9.13 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсан агуулгатай 9.12 дахь хэсэг болгон өөрчлөн найруулж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 9.17 дахь хэсэг нэмэх:

“9.12.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага харьяалалтай чадамжийн төв, салбар дундын дадлагын бааз, гарааны компани, бизнес инкубатор төв, туслах аж ахуйтай байж болно.

9.17.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага дотуур байртай байж болно. Дотуур байранд тавих шаардлагыг стандарт, техникийн зохицуулалтаар тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 12  
Бүгд: 39

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “чанартай” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 30.1.31-д заасан журмын дагуу гэж, 10.1.3 дахь заалтын “байгууллагаар дамжуулан” гэснийг “энэ хуулийн 9.12-т заасан байгууллагаар дамжуулан” гэж, 10.1.8 дахь заалтын “гэрээ хэлэлцээр байгуулах” гэснийг “хамтран ажиллах” гэж, 10.1.9 дэх заалтын “туслах /дэмжлэг үзүүлэх/” гэснийг “дэмжлэг үзүүлэх” гэж өөрчилж, 10.1.3 дахь заалтын “судалгаа хийх” гэсний дараа “зөвлөн туслах” гэж, 10.1.10 дахь заалтын “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн” гэсний дараа “байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй” гэж /цаашид тохиолдол бүрд/ нэмж, 10.1.4 дэх заалтыг төслөөс хасаж, 10.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 10.1.12 дахь заалтыг нэмэх:

“10.1.5.эзэмшсэн мэдлэг, ур чадварын үнэлгээг түншлэгч талтай хамтран зохион байгуулах;

10.1.12.түншлэлийг хэрэгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 15  
Бүгд: 39

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “63.1, 63.2, 63.3 дахь заалтад” гэснийг “63 дугаар зүйлд заасныг” гэж өөрчилж, төслөөс 11.6 дахь хэсгийн “хяналт тавьж,” гэснийг хасах гэсэн ажлын хэсгийн гаргасан 9 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

**Г.Занданшатар:** 10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.5, 12.6 дахь хэсгийг төслөөс хасаж доор дурдсан агуулгатай 12.9 дэх хэсэг нэмэх:

“12.9.Дээд боловсролын тухай хуулийн 5.8-д заасан шаталсан сургалттай хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллагын элсэгчид энэ хуулийн 12.1, 12.2 дахь хэсэг хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 12  
Бүгд: 39

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хөтөлбөрийг эзэмшсэн иргэнд гэснийг “байгууллагыг төгсөгчид” гэж, 13.2 дахь хэсгийн “Иргэний албан бус боловсрол, амьдралын орчинд суралцаж эзэмшсэн чадамжийг” гэснийг

“эзэмшсэн мэдлэг, ур чадварыг” гэж, мөн хэсгийн “13.1.1, 13.1.2” гэснийг “13.1” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26  
Татгалзсан: 13  
Бүгд: 39  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “5” гэсний “3” гэж, 14.3 дахь хэсгийн “дээд түвшний чадамжтай” гэснийг “өндөр ур чадвартай” гэж, 14.2, 14.3 дахь хэсгийн “багшлах эрхтэй” гэснийг “багшлах эрхийн гэрчилгээтэй” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 14.4 дэх хэсэг нэмэх:

“14.4.Багшийн мэдлэг, ур чадварын үнэлгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, сургалтын байгууллагатай хамтран дөрвөн жил тутам зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 12  
Бүгд: 39  
69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.1.3 дахь заалт нэмэх:

“16.1.3.мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, арга зүйч, номын санч, эмч, хоол зүйч, тогооч, сэтгэл зүйч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэнд эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа боловсролын сургалтын байгууллагаас олгох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 15  
Бүгд: 39  
61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын “хангагдсан” гэсний дараа “байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй” гэж, 17.2.1 дэх заалтын “сургалтын байгууллагын” гэсний өмнө “үйлдвэрлэлийн болон” гэж нэмж, 17.1.6 дахь заалтын “11.4” гэснийг “11.3” гэж, 17.2.5 дахь заалтын “явцад” гэснийг “үед” гэж өөрчилж, 17.2.1 дэх заалтын “байгууллагын” гэснийг, 17.2.3 дахь заалтыг төслөөс тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.3, 17.4 дэх хэсэг нэмэх:

“17.3.Суралцагч элссэн хөтөлбөрөөр суралцах хугацаандаа тухайн чиглэлийн мэргэжлийн бусад хөтөлбөрт суралцаж, хос мэргэжил эзэмшиж болно.

17.4.Суралцагч энэ хуулийн 17.3-т заасан ижил чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрт хамрагдах тохиолдолд сургалтын төлбөр төлөх бөгөөд тэтгэлгийг давхардуулан олгохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 14  
Бүгд: 39

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтын “боловсруулахад оролцох” гэсний дараа “санал болгох” гэж, 19.3.6 дахь заалтын “дадлага сургалтыг” гэсний дараа “байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй” гэж нэмж, 19.3.7 дахь заалтын “дадлагажуулагч багшаар” гэснийг “дадлагажуулагчаар” гэж өөрчилж, 19.3.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг нэмэх:

“19.3.13.дагалдан суралцагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу цалин хөлс олгох.

19.4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.6, 15.1.9-д заасан зардал, дэмжлэг, хандивыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцуулж болно.

19.5.Аж ахуйн нэгж, байгууллага нь эдийн засгийн үйл ажиллагааны салбар, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос хамааран мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих санд энэ хуулийн 22.1-д заасан Зөвлөлийн тогтоосон хувь хэмжээгээр санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

19.6.Хосмог сургалт зохион байгуулсан тохиолдолд ажил олгогчоос болон ажилтнаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөрийн тухай хуулийн 63.3-т заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25  
Татгалзсан: 15  
Бүгд: 40

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 20.2.4 дэх заалт нэмэх:

“20.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын мэдээллийн санг Боловсролын ерөнхий хуулийн 48.9-д заасан журмын дагуу бүрдүүлж ажиллуулна.

20.2.1.хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын эрэлт, нийлүүлэлт, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлт, мөшгөх судалгаа, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны мэдээлэл;



20.2.4.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын, чадамжийн болон үнэлгээний мэдээлэл.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 12  
Бүгд: 40  
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-т заасан удирдлагын тогтолцооноос бүрдэнэ.” гэсэн ажлын хэсгийн гаргасан 17 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

-Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төслийн 22 дугаар зүйлийн “Үндэсний зөвлөл” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл” гэж, 22.1 дэх хэсгийн “Үндэсний зөвлөл” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл /цаашид “зөвлөх” гэх/” гэж, 22.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн хэсгийн “бүрдэнэ” гэснийг “бүрдсэн нийт 15 гишүүнтэй байна” гэж, 22.3, 22.5 дахь хэсгийн “Засгийн газар” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 27.4-д заасан Үндэсний зөвлөл” гэж, 22.6 дахь хэсгийн “Засгийн газарт” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан Үндэсний зөвлөлд” гэж өөрчилж, төслийн 22.9.5 дахь заалтын “засгийн” гэсний дараа “эрэлттэй болон” гэж нэмж, 22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Зөвлөлийн даргыг гишүүдийн олонхын саналаар томилогдсон этгээд хэрэгжүүлнэ.” гэсэн ажлын хэсгийн гаргасан 18 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Ж.Сүхбаатар нар үг хэлэв.

-Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалтын “их сургууль, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, 23.1.4, 24.1.7 дахь заалтын “тусгай” гэснийг 23.1.8 дахь заалтын “энгийн” гэснийг, мөн зүйлийн 23.1.9 дэх заалтыг хасаж, доор дурдсан агуулгатай 23.1.10 дахь заалт нэмэх:

“23.1.10.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах.” гэсэн ажлын хэсгийн гаргасан 19 дэх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

-Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “хүрээнд” гэсний дараа “Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 24.1.7, 24.1.8 дахь заалт, 24.2 дахь хэсгийг нэмэх:

“24.1.7.багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг түншлэгч талуудтай хамтран зохион байгуулах;

24.1.8.багш, ажилтны мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, сунгах;

24.2.Энэ хуулийн 24.1.7-д заасан чиг үүргийг Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” гэсэн ажлын хэсгийн гаргасан 20 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа үг хэлэв.

**Г.Занданшатар:** 21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн “25.2.1-25.2.10” дахь заалтын дугаарлалтыг “25.1.1-25.1.10” гэж өөрчилж, мөн зүйлийн 25.2.9 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 14

Бүгд: 40

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төслийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчилж, төсөлд 26.5.3, 26.5.4, 26.5.5, 26.5.6 дахь заалт, 26.7 дахь хэсгийг нэмэх:

“26.4.Удирдах зөвлөл нь нийт арван нэгэн гишүүнтэй байх бөгөөд төрийн захиргааны төв байгууллагаас гурав, нутгийн захиргааны байгууллагаас гурав, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх нэг, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх гурав, суралцагчийн нэг төлөөллөөс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

26.5.3.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хуваарилалтыг батлах, үр дүн, чанар, гүйцэтгэлд хяналт тавих;

26.5.4.төсвийн хязгаарт нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг тогтоох;

26.5.5.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг энэ хуулийн 23.1.10-т заасан журмын дагуу сонгон шалгаруулж, томилох, хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөх;

26.5.6.боловсролын сургалтын байгууллагын захиралтай байгуулсан гэрээг дүгнэх;

26.7.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.” гэсэн ажлын хэсгийн гаргасан 22 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

**Г.Занданшатар:** 23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.2.1 дэх заалтын “бакалавр” гэснийг “магистр” гэж, 27.2.2 дахь заалтын “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага” гэснийг “боловсролын сургалтын байгууллага” гэж, “10-аас” гэснийг “таваас” гэж, “сургалтын менежер, арга зүйч, тэнхимийн эрхлэгчээр 4-өөс” гэснийг “удирдах албан тушаалд гурваас” гэж өөрчилж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 27.5.12, 27.5.13, 27.5.14 дэх заалт нэмэх:

“27.5.12.гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос багш, ажилтныг урамшуулах, нийгмийн баталгааг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

27.5.13.Боловсролын ерөнхий хуулийн 12.9-д заасны дагуу багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах;

27.5.14.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т заасны дагуу батлагдсан төсвийн 0.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 19  
Татгалзсан: 22  
Бүгд: 41  
46.3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 17  
Бүгд: 41  
58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө” гэж, 29.4.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 29.3.3, 29.3.4 дэх заалт нэмэх:

“29.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогын тодорхой хувь;

29.3.4.энэ хуулийн 19.4-т заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө.” гэсэн ажлын хэсгийн гаргасан 25 дахь саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа үг хэлэв.

**Г.Занданшатар:** 26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 17  
Бүгд: 41  
58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 18  
Бүгд: 41  
56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.*

***Найм.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, мөн яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга Х.Тамир, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Боловсролын бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын шинжээч Ж.Нарантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй, Боловсрол судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор Ш.Ариунаа, Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш Э.Чойсүрэн, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга З.Цогтгэрэл, Монголын хувийн

хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, Р.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт А.Хонгорзул, Н.Монголмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

*Боловсролын ерөнхий хуультай хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо**  
**дэмжсэн санал:**

**Г.Занданшатар:** 1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтын “нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэснийг, мөн зүйлийн 17.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 17.1.5 дахь заалтын “сургуулийн” гэснийг “сургууль, дотуур байрын” гэж өөрчилж, 17.1.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих” гэсний өмнө “хамран сургах тойргийн хүүхэд бүрийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах, бүртгэх ажлыг зохион байгуулах” гэж, “сургалтын” гэсний дараа “үйл ажиллагааны” гэж, 17.1.5 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.1.10, 17.1.11 дэх заалт, 17.7, 17.8 дахь хэсгийг нэмж, 17.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

17.1.8.боловсролын чанар, үр дүнг суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нутгийн удирдах болон захиргааны байгууллагад тухайн хичээлийн жилд тайлагнах;

17.1.10.энэ хуулийн 18.8-д заасан байгууллагад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

17.1.11.Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлэх;

17.7.Боловсролын ерөнхий хуулийн 10.2 дахь хэсэг, энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан үүргээ биелүүлээгүй суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны

болон сэтгэл зүйчийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж болно. Шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд заасан үйлчилгээнд холбон зуучилж болно.

17.8.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээнд сургалтын төлбөр төлөх, хураамж авах харилцаанд багш, суралцагчийг оролцуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	17
Бүгд:	41

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “сургалтыг” гэснийг “сургалтыг бага, дунд, ахлах” гэж, 22.6 дахь хэсгийн “суралцах, хөдөлмөрийн зах зээлд шилжихэд” гэснийг “суралцахад” гэж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг хасаж, 22.3, 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 22.7, 22.8, 22.9 дэх хэсэг нэмэх:

“22.3.Ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч холимог бүлгээр хичээллэж болно.

22.5.Суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн орчинд дасан зохицох дэмжлэг үзүүлэх, сургалтын агуулгыг нөхөх зорилгоор энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт үйл ажиллагаа, нэмэлт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

22.7.Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 30.1.15-д заасан журмыг баримтлан зайн болон цахим сургалтыг зохион байгуулна.

22.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлж болох бөгөөд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	20
Бүгд:	41

51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийг “Цэцэрлэг” гэж, 19.1 дэх хэсгийн “хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/” гэснийг “Цэцэрлэг” гэж, 19.2 дахь хэсгийг 21.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.Сургалт, үйл ажиллагааг бага, дунд, ахлах болон бэлтгэл, холимог бүлгээр зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	18
Бүгд:	40

55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Ерөнхий боловсролын сургуульд судлах үндсэн гадаад хэл нь энэ хуулийн 10.1-д заасан сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд туссан хэл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 21

Бүгд: 40

47.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 21

Бүгд: 40

47.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Ерөнхий боловсролын сургуульд судлах үндсэн гадаад хэл нь энэ хуулийн 10.1-д заасан сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд туссан хэл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 17

Бүгд: 38

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** 5.Төслийн 30 дугаар зүйлийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 14  
Бүгд: 38  
63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 17 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

**Бусад.** Монгол Улсын Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн санаачилгаар анх удаа Монгол Улсад зохион байгуулж байгаа Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын олон улсын уулзалтад Герман, Франц, Индонез, Лихтенштейн, Өмнөд Африк, Австрали, Мозамбик зэрэг улсуудын төлөөлөл, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /OSCE/ болон олон улсын бусад байгууллагын төлөөлөгчид, Баянхонгор аймгийн 8 жилийн сургуулийн 1988 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын урилгаар Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын алба хаагчид, мөн Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын сургуулийн 1991, 1993 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 5 цаг 59 минут үргэлжилж, 73 гишүүнээс 47 гишүүн хүрэлцэн ирж, 64.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 01 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД



## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 45 минут.

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрдсэн байна.

2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Найман асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хоёрдугаарт, Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Гуравдугаарт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Дөрөвдүгээрт, “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах асуудлаарх хянан шалгах Түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тавдугаарт, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Зургаадугаарт, Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Долоодугаарт, Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төсөл болон Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Наймдугаарт, Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэх асуудалдаа орно.

Хэлэлцэх асуудалдаа орохын өмнө танхимд Улсын Их Хурлын гишүүддээ Олон улсын парламентын өдрийн мэндчилгээг өргөн дэвшүүлье. /алга ташив/

Жил бүрийн жил бүрийн 6 дугаар сарын 30-ны өдөр парламентын засаглалтай, парламентат ёсыг төлөвшүүлж байгаа улс орнуудын хувьд түүхэн чухал ач холбогдолтой өдөр байдаг.

Одоогоос 134 жилийн өмнө буюу 1889 онд Олон улсын парламентын холбоо үүсгэн байгуулагдсан.

Энэ өдрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейгаас 2018 онд Олон улсын парламентын өдөр болгон тэмдэглэж байхаар шийдвэрлэсэн.

Энэ өдрийг Нэгдсэн Үндэстний Байгууллага ийнхүү онцлохын учир нь дэлхий даяар хүмүүсийг улс төрийн институцэд итгэх итгэл аажмаар суларч, ардчилал өөрөө популистууд болон явцуу сонирхол бүхий тодорхой хэсэг, бүлгийн зүгээс үзүүлж байгаа ийм сорилт бэрхшээлүүдтэй тулгарч байгаа энэ эгзэгтэй цаг үед олон улсын парламентын өдрийг тэмдэглэж байх нь зүйтэй гэж үзэж, үүнийг онцгой ач холбогдолтой гэж үзэж цохон тэмдэглээд энэ өдрийг 2018 оноос Олон улсын парламентын өдөр болгон тэмдэглэх болсон.

Тэгээд ардчиллыг бэхжүүлэхийн тулд ардчиллын гол байгууламж нь болсон парламент хүчирхэг, ил тод, хариуцлагатай, төлөөллийг хангасан байх нь зүй ёсны шаардлага болж байна.

Олон улсын парламентын өдрөөр дэлхийн парламентууд ард түмнийг төлөөлөх чиг үүргээ илүү сайжруулах, нийгмийн хөгжил, цаг үеийнхээ шаардлагыг мэдэрч хөл нийлүүлэн алхах зэрэг үндсэн зорилгуудынхаа хүрээнд хүрсэн ахиц дэвшлүүдээ үнэлж дүгнэж байна.

Тодруулбал, парламентууд өөрийн үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгөх, шинэ технологи, инновац нэвтрүүлэх зэрэг ач холбогдол өгөхийг уриалдаг.

Ийм ч учраас Монгол Улсын Их Хурал парламентынхаа төлөөллийн чадавхыг нэвтрүүлэхийн төлөө, сонгуулийг төлөөллийн чадамжийг хангахын төлөө энэ өөрчлөлт реформуудыг хэрэгжүүлсэн хаврын чуулган болж өндөрлөх гэж байна.

Энэ хүрээнд **D-Parliament**, цахим парламент гэсэн инновац шинэчлэлүүдийг хэрэгжүүлж байна.

Олон улсын парламентын холбоо жил бүр энэ өдрийг тодорхой сэдвийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлдэг болсон.

Сүүлийн хоёр жилийн хувьд **“Эх дэлхийн төлөө парламент”, “Парламентын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог хангах нь”** гэсэн уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна.

Энэ жил Монгол Улсын Их Хурлаас парламентын өдрийг угтаж **“Бодлого, залуусын хяналт”** төрийн бус байгууллагатай хамтран **“Парламентын ардчиллыг бэхжүүлэхэд сэтгүүлчдийн оролцоо”** хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

**“Мини парламент”, “Өсвөрийн парламент”**, парламентын мэтгэлцээний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Энэ эрч хүчээрээ бид Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаагаа амилуулж, амьдралд бодитой хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт, парламентын төлөөллийн чадавхыг сайжруулах, парламентын хяналт шалгалтыг сайжруулах, хуулийн гол амин сүнс нь болсон ард түмний

төлөөллийн байгууллага зөвхөн хууль тогтоох төдийгүй хяналт шалгалтын үүргээ иж бүрэн цогцоор нь хэрэгжүүлдэг байх ийм олон өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Ийм ч учраас бид авлигатай тэмцэх чуулган болгоно гэж зарласан нь

бүх дэлхий даяараа нийгмийн хэм хэмжээгээ шинэчлэн тодорхойлж, авлигатай тэмцэх тогтолцоог шинээр харах ийм шинэ хэм хэмжээ соёл тогтоож байгаа гэдгийг онцлон тэмдэглэмээр байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орёе.

### Нэг. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай”

#### Улсын Их Хурлын тогтоолын төсөл

*/Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Улсын

Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсөний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заасныг баримтлан нэг санал хураасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн тогтоолын төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 2 санал хураасныг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг

алдагдуулахгүйгээр үг, хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Байнгын хорооноос гаргасан 3 зарчмын зөрүүтэй санал байгаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Б.Баттөмөр гишүүнээр. Баагаагийн Баттөмөр гишүүнээр тасаллаа.

Эрхэм гишүүн Баагаагийн Баттөмөр асуулт асууна.

**Б.Баттөмөр:** Монгол Улс Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрөө баталж байна. Энэ бол авлигын эсрэг тэмцэж байгаа бас нэг ажлын нэг гэж үзэж байна.

Энд олон асуудлыг хөндөж тавьсан байна. Энэ асуудлуудын дагуу олон хууль тогтоомжид өөрчлөлт орох ийм нөхцөл байдал үүсэж байна.

Ялангуяа энд сонгууль тойрсон асуудал, сонгуулийн үеэр санал худалдаж авдаг, сонгуулийн бус үеэр өөртөө татах гээд их олон асуудлуудын эрх зүйн

орчныг боловсронгуй болгоно гэж үзсэн байна.

Өнөөдөр Улсын Их Хурлаар Улс төрийн намуудын тухай хуулийг хэлэлцэж батлах түвшинд явж байгаа.

Энэ дээр намын санхүүжилттэй холбоотой асуудлыг ил болгох асуудал их чухал асуудал байсан. Энэ хөтөлбөрт ороод явж байгаа.

Мөн энд бас нэг орсон асуудал бол энэ төрийн албаны албан хаагчдыг ёс зүйг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг хүчтэй болгох, авлигыг бууруулах үндсэн ажлын нэг болно гэж үзэж байгаа юм байна.

Ер нь соён гэгээрүүлэх ажил гэдэг төрөөс ард иргэдийнхээ дунд байнга хийж байх ёстой л ажил л даа.

Энэ нийгмийн хөгжил, энэ болж байгаа үйл явдалтай холбогдуулаад иргэдийн мэдээлэл олж авах, иргэд тодорхой мэдээлэлтэй болох, дүгнэлт хийх чадамж буураад байгаа.

Тийм учраас соён гэгээрүүлэх ажил зүйтэй гэж үзэж байгаа.

Ер нь төрийн байгууллагаас гарч байгаа шийдвэрүүд ил тод байх ёстой. Бүгд ил тод байдаг. Гаргаж байгаа шийдвэр, бодлого ил тод байх ёстой. Цахим болох ёстой. Энэ бол одоо бас энэ хөтөлбөрт ороод явж байгаа нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Дараагийн асуудал юу гэхээр авлигал гарч болох газрууд, авлигалын эрсдэлийг тооцох асуудал. Энэ үнэхээр онцгой ач холбогдолтой.

Нийтээр нь авлигал байна гээд яваад байх биш, хаана авлигал байна

гэдгийг эрсдэлийг тооцдог чадамжийг төр бий болгодог. Авлигатай тэмцэх газарт бий болгох энэ шаардлага зайлшгүй гэж үзэж байгаа юм.

Авлигатай тэмцэх газар, шүүх, прокурорын байгууллагуудын бие даасан байдлуудыг хангах, тэр санхүүжилттэй холбоотой асуудлыг нь шийдэх, ажилтнуудын нийгмийн асуудал, нөлөөллийг бууруулах олон асуудлууд энд байгаа нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Ер нь авлигатай тэмцэнэ гэдэг дан ганц Авлигатай тэмцэх газрын ажил биш. Бүх хүмүүсийн, бүх субъектүүдийн, бүх төрийн байгууллагуудын ажил.

Авлигатай тэмцэнэ гэдэг маш хүнд ажил. Энэ эрхийг нь Авлигатай тэмцэх газарт өгч үүнийг шийдэх ёстой.

Тэгээд нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах хууль батлагдана. Үүнийг яаралтай батлах ёстой.

Их сүржин орж ирээд энэ Шүгэл үлээгчийн тухай хууль сүүлийн үед чимээгүй болчихлоо. Үүнийг баталж гаргах шаардлагатай гэж үзэж байна.

Тэгээд хоёр асуулт байна.

Нэгдүгээрт нь, Дэлхийн Банкнаас гаргасан судалгаагаар жил бүр 2.6 их наяд доллар буюу дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгө авлигалд зарцуулж байна гэсэн судалгаа гаргасан юм байна. Дэлхийн банк.

Тэгэхээр энэ дээр манайх ер нь энэ авлигалын ийм төсөөллийн судалгаанууд байдаг юм уу? Нэг дэх асуулт. Энэ дээр хариулж өгөөч.

Хоёр дахь асуудал, Авлигатай тэмцэх газар орон нутагт тийм салбар байдаггүй. Тэр олон нийтийн иргэний хяналтын зөвлөл билүү. Тэр маань Авлигатай тэмцэх газрынхаа үүргийг гүйцэтгэж чадаж байна уу?

Эдийн засгийн гол үйл ажиллагаа явагдаж байгаа Өмнөговь, Дорноговь, Эрдэнэт гээд олон салбаруудад энэ зөвлөл салбар энэ тэрээ байгуулах ажилд ямар бодлого байгаа вэ?

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хороон дарга асуултад хариулна.

**Б.Энхбаяр:** Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг өнөөдөр эцсийн хэлэлцүүлгийг нь парламент хийнэ.

Улсын Их Хурлын дарга энэ удаагийн чуулганыг авлигын эсрэг чуулган болно гэж чуулганы нээлт дээр хэлж байсан.

Та бүхэн анзаарах юм бол бүхэлдээ эхлэхээсээ эхлээд өнөөдөр ирэх долоо хоногт дуусах хүртлээ авлигатай тэмцэх бодлогын хүрээнд олон хууль тогтоомжуудыг батлан гаргаж байна.

Хаврын чуулган Хөгжлийн банкны сонголыг хийж эхэлсэн. Хаврын чуулган.

Өнөөдөр нийгмийн даатгалын, боловсролын, тэтгэвэр, тэтгэмжийн олон суурь шинжтэй реформуудыг хэлэлцэж баталж байна.

Улс төрийн хувьд хамгийн буглаа, язгуур үндэс нь болсон Улс төрийн намын хууль, намыг шилэн болгох, санхүүжилтийг шилэн болгохоос л энэ авлигын үндэс, ёзоорыг цэвэрлэх,

тунгалаг болгох ийм ажлууд дээр санаачилга гаргаж байна.

Сонгуулийг хамгийн бага зардалтай болгох, хамгийн нээлттэй, өрсөлдөөнтэй болгох чиглэлд сонгуулийн хууль тогтоомж батлагдсан.

Бүхэлдээ харах юм бол Авлигын эсрэг хууль. Одоо бид Нийтийн ашиг сонирхлын хуульд мөн өөрчлөлт оруулж байна.

Өөрөөр хэлбэл та улс төрөө сонгох уу, бизнесээ сонгох уу. Олон нийтийн эрх ашгийн төлөө үйлчлэх тэр замаа нэг мөр сонгох уу, эсвэл ашиг, орлого олох тэр үйл ажиллагаагаа сонгох уу гэдэг энэ сонголтыг хийхэд чиглэгдсэн цогц өөрчлөлтүүдийг Улсын Их Хурал хийж баталж байна.

Улсын Их Хурлын дарга улс төрийн манлайллыг үзүүлж Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төслийг оруулж ир гэдэг зүйлийг хаврын чуулганы эхэнд Хууль зүйн байнгын хороо, Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын байгууллагуудад үүрэг өгөгдсөн юм. Энэ дагуу боловсруулж орж ирсэн төсөл өнөөдөр батлагдаж байгаа. Энэ бол цогц баримт бичиг.

Одоо ингээд үргэлжлүүлээд нүүрсний сонголыг хийх хүрээнд захирамж гарсан. Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг дүгнэлтээ танилцуулна.

Сайд нар гадаад томилоттой байгаа учраас энэ асуудал түр хойшилж байгаа. Ирэх долоо хоногт ажлын хэсэг дүгнэлтээ Улсын Их Хурлын даргад танилцуулна.

Нүүрсний сонголт хийгдэнэ. Хийгдэнэ.

КОВИД-ын үеийн төсвийн зарцуулалтыг хянан шалгах хяналтын сонсгол Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн санаачилгыг хүлээж авч шийдвэрлэсэн байгаа.

Хэрвээ Улсын Их Хурлын удирдлага олонхын бүлгийн гишүүд дэмжихгүй бол 10 гишүүнтэй цөөнхийн бүлэг энэ асуудлыг шийдүүлж чадахгүй.

Олонх байгаа парламентын хүчин өөрөө энэ асуудлыг бас дэмжиж, зорилго нэгтэй байгаа учраас хяналтын сонсголуудыг хийхээр болж байгаа.

Тэгэхээр бүхэлдээ би Улсын Их Хурлын энэ удаагийн хаврын чуулган Улсын Их Хурлын даргын чуулганы нээлт дээр хэлж байсанчлан авлигын эсрэг чуулган, парламентын манлайллыг илэрхийлсэн. Зүгээр ам яриагаар биш бодит бодлого, бодит реформ, бодит шийдлээр хариулт өгсөн ийм чуулган болж байна гэж хэлмээр байна.

**Г.Занданшатар:** 84. Авлигатай тэмцэх газрын Судалгаа, шинжилгээний албаны дарга, эрхэлсэн комиссар Цэдэн-Ишийн Шинэбаяр хариулна. 84.

**Ц.Шинэбаяр:** Дэлхийн улс орнуудын хувьд **Авлигын төсөөллийн индекс** гээд их олон янзын судалгаануудад хамрагддаг л даа.

Манай хувьд сүүлийн хэдэн жил хойшоо ухарсан. Энэ нь Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын авлигатай тэмцэх үйл ажиллагаанаас хамаарахаас гадна өөр их олон хүчин зүйлүүд хамаардаг.

Тийм учраас үндэсний хөтөлбөрт бид төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, төрийн өмчит компаниуд, орон нутгийн

өмчит компаниудын асуудал, хувийн хэвшил дэх авлигын нөхцөл байдал гээд олон зүйлүүдийг хамруулж тусгаж өгсөн.

Дотоодын олон судалгаанууд бий. Шүүхтэй холбоотой, хууль сахиулах байгууллагуудтай холбоотой, хэвлэлийн эрх чөлөөний асуудал байна. Гэх мэт.

Тийм учраас энэ болгон энэ хөтөлбөрт тусаж өгсөн.

Олон нийтийн иргэний нийгмийн оролцооны асуудал байна. Иргэдийн оролцоо, тэр байтугай хүүхдийн хүмүүжлийн асуудал хүртэл энд тусгагдаж байгаа. Тийм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя. Эцсийн хэлэлцүүлэг.

**Б.Баттөмөр:** Асуултад хариулт авч чадахгүй байна.

Судалгаа хийх ёстой. Бид ингээд нэг тийм хөтөлбөр яах вэ батлаад л явж байна л даа. Дэлхийн хэмжээнд 2.6 их наяд төгрөгийг авлигалд алдаж байна. Дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувь болж байна гэж тодорхой Дэлхийн банк гаргачихсан байна шүү дээ.

Тэгээд бидэнд ямар судалгаа байна гэсэн. Тэгээд л авлигал энэ тэртэй тэмцэх парламент болно энэ тэр гээд л нэг жижүүрийн юм яриад л урдаас ингээд байж болохгүй шүү дээ. Тооцоотой юм ярих ёстой шүү дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Авлигалтай тэмцэх газар доороо хөл алга. Энэ хөлтэй болох чиглэлээр юу байх ёстой юм бэ? Ийм л хоёр тодорхой асуулт асуусан юм л даа. Тэгээд хариулт авч чадахгүй байна.

Тэгээд хариулт бэлэн бус байгаа юм уу, эсвэл хариулахгүй байгаа юм уу? Энд хариулт байвал өгөөч л гээд байгаа юм л даа.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Хууль зүйн байнгын хорооны дарга хариулъя. Аймаг болгонд.

**Б.Энхбаяр:** Авлигатай тэмцэх газрыг орон нутагт энэ мэдээлэл авах, авлигын гэмт хэргийн талаарх мэдээлэл авах, хөрөнгө санхүүгийн асуудлыг нь шийдээд 7, 8 жил болж байгаа.

Тодорхой мэдээлэл авдаг сүлжээтэй. Бүх орон нутгаас санхүүжилтийн асуудлыг нь шийдээд 7, 8 жил болж байгаа.

Яг орон нутагт цагдаагийн байгууллага шиг бүтэц, зохион байгуулалттай болох, хүн хүчтэй болох асуудал Мөрдөх албаны хууль тогтолцооны хүрээнд иж бүрнээр яригдах учиртай. Энэ Засгийн газраас орж ирж шийдэгдэх учиртай.

Авлигатай тэмцэх газрын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх хүрээнд Улсын Их Хурал тогтмол анхаарч хөрөнгө санхүүгийнхээ хүний нөөцийнх нь хувьд дэмжлэг үзүүлж ирсэн. Энэ хүрээнд ч гэсэн шийдэж байгаа гэдгийг танд хэлье.

**Г.Занданшатар:** 84.

**Ц.Шинэбаяр:** Хохирлын хэмжээний хувьд Б.Баттөмөр гишүүний хэлсэн тэр хоёр аравны их наяд дэлхийн хэмжээнд гэдэг тоо яг тийм судалгааны хүрээнд үүнийг ашигладаггүй тоо. Энэ бол зүгээр ийм нийтлэлийн түвшинд бичигдээд дэлхий нийт зүгээр эш татагдаад явчихдаг.

Монгол Улсын хувьд бид авлигын улмаас хүчирсэн хохирлын хэмжээг гэмт хэрэг дээр хүчирсэн хохирлоор тооцох боломжтой. Шууд мөнгөн дүн.

Жишээлбэл, 2021 онд 1 их наяд, 2020 онд 12 их наяд, 2019 онд 12 их наяд хэмжээний шууд хохирол учраад. Ингээд үүнээс нэлээн хэмжээнийхийг нь мөрдөн байцаалтын шатад битүүмжлэх буюу нөхөн төлүүлсэн байгаа.

**Г.Занданшатар:** Тийм. Бодитой мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа болон илрүүлсэн, хураан авсан хөрөнгийн хэмжээнүүдийг хэлж байгаа.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 3 санал байгаа.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Дэгийн тухай хуулийн 42.2-г заасны дагуу хураагдсан санал байх шиг байна.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Тогтоолын төслийн 2 дахь заалтыг доор дурдсанаар урьдчилан найруулах:

“2.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Хөгжлийн

бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг тус тус Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-г даалгасугай.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Жигжидийн Батжаргал, Баагаагийн Баттөмөр, Сайнхүүгийн Ганбаатар 3 гишүүнээр тасаллаа.

Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** 10 сарын 01-ний дотор Ерөнхий сайдад төсвөө танилцуул гэж үүрэг өгдөг нь болох юм уу? Энэ чинь төсөв боловсрогдоод Их Хуралд өргөн баригдчихсан байх цаг хугацаа шүү дээ.

Тийм учраас тухайн жилийн гэдэг юм уу, ирэх жилийн төсөв дотроо Авлигатай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө мөнгөө бүтэн тусгаад өргөн барьдаг байх энэ л чиглэлээр нь үүрэг өгөх ёстой.

Тэгэхгүй салгаж өргөн бариулчхаад тэгээд яаж төсөв дотроо хэдүүлээ багтаах билээ, үүнийг чинь.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Энэ хөтөлбөрийн ач холбогдол үнэхээр ач холбогдолтой. Улам боловсронгуй болох шаардлагатай. Би энэ хөтөлбөрийг бүрэн гүйцэд сайн болчихсон гэж хэлэхгүй. Тэгэхдээ өнөөдөр энэ хөтөлбөртэй болж байгаа нь маш их ач холбогдолтой.



Ер нь энэ хөтөлбөр авлигын эсрэг тэмцэж хөгжлийн төлөө хийж байгаа алхам гэж үзэх ёстой байгаа юм. Төрийн бүх байгууллагууд Авлигатай тэмцэх газартай хамтарч ажиллах ёстой. Өнөөдөр манай Авлигатай тэмцэх газар хүнд нөхцөлд сайн ажиллаж байгаа. Үүнийг би өнөөдөр хэлье гэж бодож байна.

Тийм учраас цаашдаа улам сайн ажиллахад бид анхаарч ажиллах ёстой. Авлигад зарцуулж байгаа мөнгө далд эдийн засагтай холбоотой. Би судлаач хүний хувьд үүнийг 100 хувь баталж чадна.

Нийт авлигад зарцуулж байгаа мөнгөний 70-аас 75 хувь нь далд эдийн засгаас ордог. Үлдэж байгаа 20-иос 25 хувь нь тэр татвар төлсний дараах мөнгөнөөсөө авлигад өгдөг. Өөрөөр хэлбэл татвар төлсний дараах тэр ашгаасаа авлигад зарцуулах мөнгө харьцангуй бага байдаг юм байна.

Ийм учраас авлигатай тэмцэхэд далд эдийн засаг, хөгжлийнхөө асуудалд бид их анхаарах ёстой юм гэдгийг би хэлэх гэж байгаа юм.

Энэ орон нутагт өөрийн салбар алга гэдгийг би хэлээд байгаа юм биш л дээ. Үүнийг **OECD** /Organisation for Economic Co-operation and Development/ хэлээд байгаа юм.

Танай орон нутаг дахь иргэний хяналтын зөвлөл чинь үүргээ тэр бүр гүйцэтгэж чадахгүй байна. Далд эдийн засагт маш их хэмжээний авлигалын асуудал чинь энэ орон нутагт байна гээд. Ялангуяа нүүрс тойрсон Өмнөговьд байж байгаа асуудлууд байна. Гэх мэтээр.

Дорноговь дахь уул уурхайн салбарыг тойрсон. Энд чинь авлигал их

байна гэсэн юмыг **OECD** хэлээд дүгнэлтдээ биччихсэн байгаа юм шүү дээ. Үүнийг би асуугаад байгаа юм л даа.

Тэгээд ер нь 2.6 их наяд доллар өдөрт дэлхийн 1.5 доллароос бага цалинтай 1.5 тэрбум хүнийг нэг жил хооллох хэмжээний мөнгө энэ авлигад чинь явчхаж байна гэсэн тооцоог гаргаж байгаа шүү дээ.

Тийм учраас тооцоо судалгааг Монгол Улсын хэмжээндээ ямар боломжууд байна, алдагдсан ямар боломжуудууд байна үүнийг их сайн судлах ёстой юм байна.

**OECD**-гийн зөвлөмжид дээд түвшний авлигал чинь Монголд газар авчихсан байна. Дунд түвшний, бага түвшний авлигал чинь харьцангуй багасаж байна гэсэн ийм судалгаа гаргачихсан байгаа юм л даа.

Тэр **OECD**-гийн дүгнэлтэд хэлсэн бас нэг ноцтой асуудал бол танай томилгооны чинь асуудал авлигалыг өөгшүүлж байна. Монгол Улс яагаад хөгжихгүй байна гэвэл хүндээ байна шүү дээ гэж. Үүнийг бодох л ёстой асуудал.

Тийм учраас эдгээр зүйлүүдээр судалгаа, тооцоонуудыг хийх ёстой.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын гаргасан судалгаагаар авлигалын улмаас алдсан мөнгө нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан ёсны тусламжаас 10 дахин их байна гээд бас тооцоо гарчихсан байгаа шүү дээ.

Тийм учраас би энд өнөөдөр юу гэж хэлэх гээд байгаа юм гэхээр зэрэг Авлигатай тэмцэх газар, холбогдох газрууд судалгаануудыг хийх ёстой. Эрсдэлийг маш сайн тооцох ёстой.

Хятадын авлигатай тэмцэж байгаа туршлага байна. Гүржийн туршлага байна. Хятадын удирдагчийн нөгөө бар, ялаа гээд хөтөлбөр байж байгаа шүү дээ. Сургамжтай. Олон улсууд авч хэрэгжүүлж байгаа. Тэгээд ийм ийм юмыг л хэлж байгаа юм л даа.

Тэгээд та бүгд энэ дээр анхаарч ажиллана биз гэдгийг хэлье.

**Г.Занданшатар:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Энэ Улсын Их Хурал авлигалтай тэмцэж байгаа. Чадлынхаа чинээгээр л үзэж байгаа.

Нүүрсний асуудлыг энэ Улсын Их Хурал дээр анх шүгэл үлээсэн. Гишүүд.

Нүүрсний асуудлыг харин дарж алга болгож байгаа нь Авлигатай тэмцэх газар байна гэж би хардаж эхэлж байгаа.

Тэгээд би энэ төсөвтэй холбогдуулж асууя. Би дэмжиж байгаа энэ хөтөлбөрийг.

Та нар энэ төслийн 3 дугаар зүйл дээр авлигатай тэмцэх иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын хэвлэл, мэдээллийн бодит оролцоо, үр дүнтэй хяналтыг бэхжүүлэх гэдэг 3 дугаар зорилтын хүрээнд зарцуулах хөрөнгө 140 сая төгрөг. Маш бага.

Энэ Авлигатай тэмцэх газрыг өөрөө бэхжүүлэхдээ орон тоог нэмэгдүүлэх гэдэг дээр 2.6 тэрбум төгрөг. Авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий төвийг байгуулна гэдэг дээр 3.4 тэрбум төгрөг. Авлигатай тэмцэх газрын салбарыг орон нутагт байгуулах гэдэг дээр 2.5 тэрбум төгрөг. Мэдээллийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулахдаа 340 тэрбум төгрөг.

Иргэдийг оролцуулах, орон нутгийн төрийн бус байгууллагууд болон оролцоог хангах тал дээр 140 сая төгрөг.

Энэ дүр эсгэсэн авлигатай тэмцэх гээд байна уу гэдэг асуудлыг анхаарч үзээсэй.

Тэгээд би хэлэх гээд байгаа зүйл гэвэл Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар санаачилж, дэвшүүлж байгаа **e-petition, D-Parliament** гэж ард түмэнтэй парламент яаж ойрхон байх вэ, шийдвэрээ яаж ойрхон байх вэ, асуудлуудаа яаж тэднээр шийдүүлэх вэ, асууя гэдэг ийм зорилго, зорилт тавиад хууль нь батлагдаад явж байгаа.

Авлига гэдэг бол төр хийдэг. Ямар нэгэн иргэн яг авлигалын асуудал гэхээс илүү шийдвэр гаргагчийн асуудал.

Тэгэхээр төр өөрөө татвар төлөгчдийн мөнгөөр авлигатай тэмцэх гэж байгаа энэ явцдаа ард иргэдийг, төрийн бус байгууллагуудыг үүгээр дагнасан, мэргэшсэн төрийн бус байгууллагуудыг оролцуулах тал дээр онцгой анхаарах байх гэдэгт би гүнээ итгэж байна.

Би асуулт асуух цаг дээр асуулт авч амжсангүй. Тэгээд би дэмжиж үг хэлэх зүйл дээрээ та нар минь анхаараасай, бодоосой гэдэг зүйлийг илэрхийлж хэлж байгаа юм. Төсвийн анализ ийм байна.

Хоёрдугаарт, нүүрсний асуудал дээр гэж байгаа. Ард иргэдэд мэдээлэл ойрхон биш байгаа.

Ш.Адъяаа гишүүн санаачлаад, Г.Ганболд гишүүн даргалаад парламент дээр түр хороо байгуулагдаад бүтэн жил ажилласан.

Яг одоо бид үр дүн гаргаад л болохгүй хүмүүсийг тодорхой болгох гэхэд Х.Буянтүмэн гэдэг эрхэлсэн комиссараас бичиг ирсэн.

Б.Ганхуяг, Н.Удаанжаргал нарыг хариугүй барих гэж байна. Яг одоо үр дүн гаргах гэж байна. Жаргах замд битгий садаа болооч ээ гэж бичиг ирсэн.

Мөрдөн шалгах ажиллагаа дуусаагүй байхад нэр бүхий хэргийн оролцогчдыг хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах гээд ухаантай царайтай баахан юм бичсэн.

Би хүндэлж байна Та нарыг. Та нар нууц ажил хийдэг байх. Тэгэхдээ та нарын авлига л ард түмнийг махалж, зовоож, шаналгаж байгаа. Ард иргэдийн яг энэ авлигатай тэмцэж байгаа төлөөллийн байгууллагатай хамтрахгүй бол та нар бүхнээс илүү, би л ганцхан чадна гээд сая сая тонн нүүрс гарсан шүү дээ.

Мянга мянган тонн хүнд даацын машин хилээр гарч байхад тагнуул, хууль хүчний байгууллага, Авлигатай тэмцэх газар таг байсан. Би өмнөх хүмүүсээс чинь юмыг та нар дээр тохох гээд байгаа юм биш ээ.

Олон нийт, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах тал дээр төсөв дээр уучлаарай гэдэг үг байна гэж би ойлгож байна.

Үүнийгээ анхаарч, маш сайн анхаарч, эднийхээ оролцоог хангаж ажиллах байх. Мөнх тэнгэр минь та нарыг ивээг.

**Г.Занданшатар:** Санал хураалт явуулна.

Ж.Батжаргал гишүүн ээ. Санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг гэж байгаа шүү дээ. Тусгаж байхыг. Тэгээд 10 сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг тус тус гэгчихсэн байгаа.

Тус тус гэдэг үгийг найруулгаар эцсийн хэлэлцүүлэг дээр хасчихмаар. Хоёр газар даалгавал тус тус гэнэ үү гэхээс биш өмнөх хоёр заалтаа тус тус гэсэн нэг ийм найруулгын анхаармаар юм байх шиг байна.

Төсвийн төсөлд тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг гэх юм уу, байхыг гэх юм уу гэдэг. Үүнийгээ найруулга дээр анхаарна биз.

Зарчмын хувьд энэ санаанууд орсон байна гэж үзэж байна. Ингээд санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

39 гишүүнд оролцож, 33 гишүүн дэмжиж, 84.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 5.2 дахь хэсгийн 5.2.1 дэх заалтын “шинэ шатанд хүргэнэ” гэснийг “өргөжүүлнэ” гэж, зорилт 5.4 дэх хэсгийн 5.4.3 дахь заалтын “олон улсын” гэснийг “гадаад” гэж өөрчилж, зорилт 6.1 дэх хэсгийн 6.1.5 дахь заалтын “мөнгө угаах,” гэснийг хасаж, зорилт 5.1 дэх хэсгийн 5.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.6.Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийн урсгал зардлыг өмнөх оны батлагдсан төсвөөс бууруулахыг хориглох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.”

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

37 гишүүн дэмжиж, 92.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Тогтоолын төслийн хавсралтын зорилт 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтын “хугацаанаас өмнө” гэсний өмнө “шүүхийн магадлалаар” гэж нэмэх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

Шүүхийн магадлалаар суллахыг хориглоно гэхээр болчхож байгаа юм байна.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр олгох батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

95.0 хувийн саналаар санал дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Хууль зүйн байнгын хороо, Хууль зүйн байнгын хорооны дарга нарт богино хугацаанд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн эцсийн хэлэлцүүлгийг зохион байгуулж өнөөдөр батлуулж байна. Талархал илэрхийлье.

Энэ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2016 онд анх батлуулсан.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт 11 зорилго дэвшүүлсэн.

Ялангуяа энэ дотор улс төрийн намын санхүүжилт, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, улс төрийн хүрээнд авлигатай тэмцэх манлайлал ил тод байдлыг сайжруулна.

Олон нийтийн итгэлийг хүлээсэн, авлигаас ангид, ёс зүйт нийтийн албыг бэхжүүлэх зорилгыг ойрын хугацаанд хэрэгжүүлнэ.

Авлигатай тэмцэх ажил зөвхөн төрийн хийх ажил биш. Бүх нийтийн үйл хэрэг юм гэж тодорхойлсон.

Тийм ч учраас авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо үр дүнтэй хяналтыг бэхжүүлэхэд онцлон анхаарах ёстой.

Ер нь дэлхий даяараа нийгмийн хэм хэмжээ, өөрчлөгдөж шинэчлэгдэж байна. Авлигын эсрэг соёл шинээр бий болж байна. Нийгмийн сүлжээ, технологийн дэвшил шинэ боломжийг олгож байна.

Ийм учраас “шударга ёс”, “тэгш боломж” гэдэг үг уриа, тунхагийн шинэ чанартай байхаа больж, үүнийг бодитой хэрэгжүүлэх шаардлагыг иргэний нийгмийн байгууллага, сэтгүүл зүй, нийгмийн сүлжээ шахаж шаардаж ажилладаг болсон ийм шинэ орчин, шинэ соёл бий болсон.

Үүнийг “авлигатай тэмцэх гурван хэмжээт шинэ хандлага” гэж дэлхий даяар нэрлэж байгаа.

Тэгээд энэ шинэ соёлд тааруулж энэ өөрчлөлт хийгдэж байгаа гэдгийг бид гүнээ ухамсарлах хэрэгтэй байгаа юм. Нийгмийн шаардлага, хүсэл эрмэлзлийг төрийн байгууллага, төрийн

төлөөлөгчдийн байгууллага дагаж ажиллах ёстой. Ард түмнийхээ хүсэл зорилгод нийцүүлж ажиллах ёстой.

Ийм учраас энд байгаа тэр “гурван хэмжээт өөрчлөлт” гэдэг ерөөсөө авлигатай тэмцэх ажил босоо тогтолцооноос хэвтээ тогтолцоонд шилжиж байна. Вертикал төрийн босоо тогтолцооноос хэвтээ хариуцлагын тогтолцоо. Энд иргэний нийгмийн байгууллагууд, сэтгүүл зүй, мэргэжлийн хяналт, төрийн хяналтын байгууллагууд хэвтээ хяналтын тогтолцоонд шилжиж байгааг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрөөр баталгаажуулж байгаагаараа энэ ач холбогдолтой болж байгаа юм.

Төр өөрөө хийгээд л, өөрөө хянаад л, өөрөө тэмцээд байдаг ажил биш. Энэ бол бүх нийтийн хамтын хүчин чармайлтаар хэрэгжих ажил.

Төр бодлого гаргаж хэрэгжүүлэхийг эрмэлзэж байгаагаа түүний үндэслэл нөхцөл, үр дагавраа сайтар олон нийтэд зөв ойлгуулдаг, соён гэгээрүүлдэг. Хамгийн гол нь ил тод байж энэ зорилгыг үр дүнтэй хэрэгжүүлж чадна.

Сая манай олон гишүүд хэллээ. Манай Хууль зүйн байнгын хорооноос гэхэд 4 хууль батлан гаргалаа.

Бүх хуульд энэ авлигатай тэмцэх үзэл санааг суулгаж байгаа. Сонгуулийн хуулийг яаж авлигагүй, шударга, олон нийтийн хяналттай, оролцоотой болгох вэ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сая батлан гаргалаа. Хаврын чуулганаар.

Нийтийн сонсголын хэм хэмжээг шинээр тогтоож, мөрдөн шалгах нийтийн

сонсголыг анх удаа зохион байгууллаа. Хууль зүйн байнгын хорооны дарга, хамт олон санаачлаад.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг сая бид хийлээ.

Тендерийн хуулийг шинэчлэн баталлаа. Бүх хуульд ер нь авлигатай тэмцэх үзэл санаа сууж байгаа.

Ийм учраас Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганыг нээж үг хэлэхдээ бид авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчныг сайжруулсан чуулган болно гэж зарласан.

Энэ зорилтоо бид өнөөдөр нэг алхмаар урагшлуулж хэрэгжүүлж энэ олон нийтийн шүүмж, хөндлөнгийн судалгааны байгууллагуудын үр дүнд нийцүүлж төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байх нөхцөлийг хангаж, энэ өөрчлөлт, шинэчлэлтүүдийг хийж, өнөөдөр Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталлаа.

Үүнийгээ одоо хэрэгжүүлэх ажил бидний өмнө. Энэ зорилтын Нэгдүгээрт, заасан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрөө хэрэгжүүлэх манлайлал, хүчин чармайлт, хамтын хүчин зүтгэл чухал шаардлагатай.

Энэ соёлыг төлөвшүүлэхийг бүгдээрээ уриалж, манлайлж ажиллах хэрэгтэй. Авлигыг тэвчих, ашиг сонирхлын зөрчлийг тэвчих тэр нийгмийн шаардлага бодитой болчихсон байна гэдгийг л хаа хаанаа гүнээ ухамсарлаж ажиллаж, энэ хөтөлбөрөө үр дүнтэй хэрэгжүүлбэл зохино.

Ингээд гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Амжилт хүсье.

Дараагийн асуудалд орно.

---

**Хоёр. Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**  
*/Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

---

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан танилцуулна.

**С.Амарсайхан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Үндэсний их баяр наадмын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан дагаж мөрдөж байна.

Гэвч Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зарим зохицуулалт нь бусад хуулийн зохицуулалттай зөрчилдөх, хийдэл үүсэх зэрэг нь хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.

Тухайлбал, Үндэсний их баяр наадмын тухай хууль болон Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр 7 дугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15 гэж нийтээр тэмдэглэх буюу нийтээр амрах өдрүүдийг заасан.

Харин Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6-д Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр 7 дугаар сарын 11, 12, 13, 14, 15 гэж 7 дугаар сарын 10-ны өдрийг орхигдуулсан нь зөрчлийг үүсгэж, хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэлтэй байна гэж дүгнэж байна.

Түүнчлэн Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д улсын аварга, арслан цолтой бөх 9 даван түрүүлсэн тохиолдолд олгох цолны зохицуулалтыг орхигдуулсан нь хийдлийг үүсгэж байна.

Мөн хуульд допинг хэрэглэхийг хориглох. Хэрэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын механизмыг суулгаж өгсөн боловч энэ нь зөвхөн улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд хамааралтай бөгөөд аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах баяр наадамд барилдсан бөхөөс допингийн шинжилгээг авах зайлшгүй шаардлагатай зөрчилдөж байна.

Үүнээс гадна тэгш ойн баяр наадмын бөхийн барилдаанд 128-аас дээш 256 бөх барилдах боломжийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд хязгаарласан нь тухайн барилдаанд аймаг, сумын цолтой бөх болон залуу бөхчүүдийг барилдуулах нөхцөл, боломжийг хязгаарласан асуудал болжээ.

Түүнчлэн 1921 оноос эхлэн уламжлал болгон зохион байгуулж ирсэн

Цэргийн баяр наадмыг зохион байгуулах, түүнд цол олгохтой холбоотой зохицуулалтыг Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмж тусгах шаардлага үүсээд байна.

Иймд хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дараах үзэл баримтлал, агуулгаар боловсруулаад байна. Үүнд:

Нэг.Хууль хоорондын зөрчил, давхардал, хийдлийг арилгах.

Хоёр.Улсын баяр наадамд амжилт гаргасан бөхөд олгох цолыг тодорхой болгох зохицуулалтыг нарийвчлан тусгах.

Гурав.Аймгийн тэгш ба ойн баяр наадамд 256 хүртэлх тооны бөх барилдаж болох эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Дөрөв.Аймгийн баяр наадамд үзүүрлэсэн, шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээ авах шаардлагыг тусгах.

Тав.Монгол Улсад уламжлан ирсэн цэргийн наадамд цол олгох эрх зүйн орчныг аймгийн баяр наадамд цол олгохтой адилтгах зохицуулалтыг тусгах зэрэг болно.

Хуулийн төсөл батлагдсанаар хууль хоорондын зөрчил арилж, уялдаа холбоо сайжрахын зэрэгцээ, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, улсын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанаас гадна аймгийн баяр наадам, түүнтэй адилхан баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд барилдаж амжилт гаргасан

бөхөөс тамирчны нэгэн адил шинжилгээ авах эрх зүйн орчин бүрдэх болно.

Иймд хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** С.Амарсайхан Шадар сайдад баярлалаа.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Ж.Батсуурь:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч дээрх хуулийн төслүүдэд аймгийн баяр наадмын тэгш ойд 256 бөх барилдах, улсын баяр наадамд амжилт гаргасан бөхөд олгох цолыг тодорхой болгох, наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхчүүдийн эрэмбийг Монголын

үндэсний бөхийн холбооны дүрмээр зохицуулах, аймгийн баяр наадамд үзүүлэсэн, шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээ авах, мөн хариуцлагын механизмыг улсын баяр наадамтай адилхан авч үзэх, Үндэсний их баяр наадмын тухай, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль хоорондын зөрчлийг арилгах, хуулийг нэг мөр хэрэглэх эрх зүйн орчныг бий болгох зэрэг зохицуулалтыг тусгаж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Дээрх хуулийн төсөл дэх иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын D-Parliament.mn цахим системд байрлуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Үндэсний баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал,

дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ж.Батсуурь гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулья.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Нармандахын Жамьянхүү, Монголын Үндэсний бөхийн холбооны тэргүүн Цэдэндашдоржийн Магалжав, Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал Дэлгэрнямдоржийн Мөнхболд нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? С.Ганбаатар гишүүнээр тасаллаа.

Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Баяр наадмын тухай хуульд улсын баяр наадмын өмнө нэг нэмэлт, өөрчлөлт орж ирэх юм.

Ноднин нэмэлт, өөрчлөлт ороод энэ жилээс мөрдөгдөж байгаа байх. Ноднин орсон нэмэлт, өөрчлөлтөөр улсын баяр наадам, аймаг, сумын наадмуудыг нэгэн зэрэг тэмдэглэх хууль



батлагдсан. 10, 11-ний өдрүүдэд хийж байх. Улс орон даяар нэгэн зэрэг.

Тэгээд П.Сайнзориг дарга ээ, энэ хуулийн хэрэгжилт хангагдахгүй. Тухайн үед бид хуулийн хэлэлцүүлгийн үед үүнийг юу гэж ойлгох вэ гэхээр онцгой тохиолдолд буюу байгалийн гамшиг, ган зуд, үер усны тохиолдлоос бусад тохиолдолд нэгэн зэрэг тэмдэглэж байя гэдэг ийм л хуулийг хэлсэн шүү дээ.

Гэтэл аймаг, сумын наадмууд чинь янз бүрийн байдлаар, ой гээд л. Биднийг хууль хэлэлцэж байх үед өнөөдөр ч гэсэн зарим аймаг, сумдын наадам болж байх жишээтэй.

Тэгээд энэ чинь хууль батлаад тэгээд баталсан хуулиа хэрэгжүүлэхгүй юм бол хууль батлахын хэрэг байна уу? Баталсан хуулийг нэг мөр улс орон даяар хэрэгжүүлэх үүрэгтэй биз дээ. Тэгээд хуулийн хэрэгжилтэд Хууль зүйн яам яаж хяналт тавьж байгаа юм бэ?

Дур дураараа, 100 жилтэй, тэдэн жилтэй гээд. Энэ онцгой тохиолдолд чинь бид тэгш ойг ерөөсөө хамруулаагүй шүү дээ. Гэтэл аймаг болгон, сум болгон энэ хуулийн хэрэгжилт хангагдахгүй хуучнаараа яваад байх юм.

Тэгэхээр баяр наадмын ноднингийн оруулсан хуулийн нэмэлт, өөрчлөлт чинь ерөөсөө огт хэрэгжихгүй байна шүү дээ. Уг нь бүх орон нутгуудаар бөхчүүдийг, уяачдыг тэнээд орон нутгийн наадмуудыг будилаантуулаад байдаг байдлыг зогсоох гэж орон нутгуудыг нэг өдөр наадмыг хийлгэдэг байх зарчмаар энэ хуулийг хийсэн шүү дээ. Энэ дээр Та бүхэн хариулж өгөөч.

Хоёрт, энэ бөхчүүдийн асуудал. Аймгийн түрүү бөхчүүдийг допингийн шинжилгээ авах болж байгаа юм байна.

Ер нь допингтой бөхчүүд дээр цаашдаа ер нь хэрэглүүлэхгүй байх тал дээр бөхийн холбоо ямар арга хэмжээ авч байгаа юм бэ? Жил болгон л нэг допингийн асуудал гарах юм.

Тэгээд наадам нь наадам биш болох юм. Ерөөсөө таслан зогсоож чадахгүй асуудал. Энэ одоо ер нь цаашдаа байсаар байх ёстой юу? Ингээд л наадмыг нэг бөөн хэрүүл уруултай болгодог. Ерөөсөө наадмаа ч хийж чадахаа больсон байна шүү дээ.

Морь нь бөөн хэрүүл уруултай. Энэ жил баяр наадмын морийг яаж хэмжих гэж байгаа юм. Уралдааныг. Нөгөө сэrvээгээрээ хэмжиж байгаа юу, үгүй юу? Үүнийг нь яаж ил тод, нээлттэй болгох гэж байгаа юм? Энэ дээр Та бүхэн хариулт өгөөч ээ. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хэн хариулах вэ?

П.Сайнзориг дарга хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

**П.Сайнзориг:** Улсын Их Хурлын дэд дарга зөвшөөрвөл допингтой холбоотой асуудал дээр нь Ц.Магалжав тэргүүнээр би хариултыг өгүүлье.

Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Хууль түрүү жил шинэчлэн батлагдсан. 2003 онд анх баяр наадамтай холбоотой арга хэмжээг хуульчилсан. Энэ хууль маань тодорхой цаг үедээ хэрэгжиж яваад, зохион байгуулалтын асуудал нь заримдаа нэгэнт хуульчилсан

учраас хуулиас шалтгаалж байгаа зүйлүүд байна гээд түрүү жил Засгийн газраа хуулийг шинэчилсэн найруулгыг өргөн барьж Улсын Их Хурал маань баталж өгсөн.

Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан баяр наадмуудыг өөр өдрүүдэд, улс, аймаг, сумын баяруудад тэмдэглэж болох бөгөөд улс, аймгийн баяр наадмын хугацааг Засгийн газар, сумын баяр наадмын хугацааг аймгийн Засаг дарга тогтоохоор хуульчилсан.

Үүнтэй холбоотойгоор 8 сарын 10-ны дотор эдгээр баяр наадмуудыг үндсэндээ цаад хугацааг нь тэмдэглэж дуусгах ёстой шүү гэдэг зүйлийг хуулиар уг нь зохицуулж өгсөн байгаа.

Энэ хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Шадар сайдын ажлын алба, Шадар сайдаас аймгуудын орон нутаг руу тодорхой баяр наадмуудыг нэгэн зэрэг тэмдэглэх чиглэлийг хүргүүлж ажиллаж байна.

Тэгэхдээ эргээд бас үүсэж байгаа зарим нөхцөл байдлууд байгаа. Тэгээд бид хэд цаашдаа илүү их энэ хуулийн хэрэгжилтийг хангах тал дээрээ анхаарч ажиллая гэдэг зүйлийг танд хэлье.

Хоёрдугаарт, мэдээж энэ допингтой холбоотой асуудлыг Ц.Магалжав тэргүүнд илүү тодруулж хариулна.

Ер нь бид допингийн эсрэг олон улсын гэрээ конвенцод нэгдэж орсон. Энэ гэрээ конвенцын дагуу дотоодынхоо дүрэм, журмыг сайжруулсан байгаа. Өнөөдөр хэрэглэж байгаа дүрэм, журам маань зөвхөн энэ үндэсний бөхтэй холбоотой шийтгэл оногдуулдаг дүрэм, журам биш байгаа юм. Нийт мэргэжлийн спорт буюу олимпын төрлийн

спортуудын тэмцээн уралдаан дээр яг энэ допингтой холбоотой асуудлыг зохицуулж байгаа ийм журам байгаа.

Үүнтэй холбоотой мэдээж цаашдаа таслан зогсоохын тулд л бид тамирчдаа соён гэгээрүүлж, ойлгуулах, үнэхээр хэрэглэсэн нөхдүүд дээр нь арга хэмжээг нь дүрэмд заасны дагуу авахаас өөр аргагүй нөхцөл байдалтай байгаа.

Морины асуудал дээр баяр наадмын тухай хуулиар тодорхой зохицуулсан шилжилтийн үеийн зохицуулалттай.

Ер нь шүдэлгээ болон энэ сэрвээний өндөртэй холбоотой асуудлыг наадмын өдрүүдэд ил тодоор нээлттэй байдлаар олон нийтэд хүргэнэ.

Ер нь уралдаж гарах болон ирсэн, барианд орсон айрагдсан морьдуудыг шүдлэгээг олон нийтэд нээлттэйгээр харуулах хуулийн зохицуулалт бэлэн байж байгаа.

Ер нь 2025 оноос баяр наадмын тухай хуулийн 21.4 дээр байгаа адуун сүргийг бүртгэлжүүлэх асуудал байгаа. Үүнийг 2025 оны 6 дугаар сарын 01-ний дотор Хүнс, хөдөө аж ахуйн яам маань зохион байгуулах ёстой. Энэ асуудал жигдрээд ирэх юм бол цаашдаа маргаан гарахгүй байх.

Ер нь бид цэвэр цусны адуунуудыг эдийн засгийн эргэлтэд зөв оруулах үүднээс Бооцоот морин уралдааны хуулийг Засгийн газраас өргөн барьчихсан байгаа.

Тэгэхээр эдгээр хуулиудтай уялдуулаад уяачдын дунд үүсээд байгаа нөхцөл байдлуудыг цаашдаа зөвөөр зохицуулах боломж бүрдэх байх гэж харж байна.

**Л.Мөнхбаатар:** Нэмж хариулъя. Монголын Үндэсний бөхийн холбооны тэргүүн Ц.Магалжав нэмж хариулъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

**Ц.Магалжав:** Монголын Үндэсний бөхийн холбоо допингийн асуудалд анхаарлаа хандуулж байгаа.

Бусад спортын холбоод ч гэсэн энэ допингийн хор хөнөөлийн эсрэг ажиллаж байгаа. Үүний нэг нь наадмаас наадмын хооронд 100 орчим бөхөөс шинжилгээг авч ажиллая гээд ажиллаж байгаа.

Монголын допингийн эсрэг үндэсний байгууллагатай Үндэсний бөхийн холбоо сургалт таниулгыг жилд хоёр удаа явуулж ажиллаж байгаа.

Хамгийн гол бусад хүчний байгууллагуудтай хамтарч ажиллах зүйл нь энэ хориотой эм, бэлдмэлийг оруулж ирж байгаа этгээдүүд байгаа юм. Энэ нэг сүлжээ үүсгээд залуучуудыг хуураад байдаг зүйл байгаа.

Тэгэхээр үүнтэй бид ирэх жилээс, энэ намраас холбогдох байгууллагуудтай хамтраад ажиллая гэж байгаа.

Үндэсний бөхийн холбоо бөхчүүдэд допингийн хариуцлага, шийтгэл ноогдуулахдаа Засгийн газраар батлагдсан Үндэсний допингийн эсрэг дүрэмд заасны дагуу л хариуцлага, шийтгэлийг ноогдуулж байгаа юм. Энэ бол ганцхан Үндэсний бөхийн холбоо биш бусад спортын холбоод энэ дүрмийн дагуу хариуцлага, шийтгэлийг ноогдуулж байгаа.

Өөрөөр хэлбэл тухайн тамирчин хориотой эм, бэлдмэл, ямар төрлийн эм, бэлдмэл хэрэглэсэн, давтан уу, анх удаа

юу гээд энэ заалтууд нь тэр дүрэмд тодорхой байгаа.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

**Ц.Сандаг-Очир:** Энэ цэнгэлдэхийг ер нь нэг нүүлгэх, шилжүүлэх, жоохон хүртээмжтэй, 20, 30, 40 мянган үзэгчидтэй нэг ийм цэнгэлдэх болгочих. Тэндээ баяр наадамчид наадмаа үздэг байх энэ талын юмны төсөв, төлөвлөгөө ер нь байдаг юм уу?

Жил болгон л 5, 10 мянга хүрэхгүй энэ цэнгэлдэхдээ л шаваад л. Зогсоол нь ч хүрэлцэхгүй, үзэгчид нь ч хүртээмжгүй. Тэрийгээ дагаад билет юм нь дамлагдаад зарагддаг.

Тийм учраас энэ тал дээр Хууль зүйн яам ер нь ямар бодол байр суурьтай байна вэ? Цаашдаа баяр наадмаа, цэнгэлдэх хүрээлэнгээ томсгочих ийм бололцоо боломж байна уу, үгүй юу гэдгийг нэгд асууя.

Хоёрт, хууль зөрчөөд сумын наадмууд тогтоосон хугацаанд хийхгүй байгаа тохиолдолд зэрэг цолыг нь бөхчүүд нь сур, моринд нь өгөх, өгөхгүй байх энэ зэргийн зохицуулалт байгаа билүү байхгүй билүү?

Ер нь хийвэл яах юм? Ямар хариуцлага хүлээх юм?

**Г.Занданшатар:** Пүрэвжавын Сайнзориг. Төрийн нарийн бичгийн дарга хариулъя.

**П.Сайнзориг:** Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Ер нь баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх газар, барилга, байгууламжтай холбоотой асуудал шууд

манай яаманд хамаатай биш учраас би бүрэн дүүрэн хариултыг өгч чадахгүй байна.

Тэгэхдээ танд надад байгаа мэдээллийг өгөхөд ерөнхийдөө хоёр байршил дээр стадионыг шинээр барих ийм шийдвэр гарсныг сая нийслэлээс энэ асуудлаа цэгцлээд “Хүй долоон худаг” хавьцаа ерөнхийдөө “Монгол наадам” цогцолбороо дагаад энэ асуудлыг шийдвэрлэнэ гэсэн ерөнхий тийм шийдвэр гарсан гэж би хувьдаа ойлгож байгаа.

Ер нь төр, хувийн хэвшлийн түншлэлийнхээ хүрээнд Засгийн газраас өргөн барьсан Бооцоот морин уралдааны хуультайгаа уялдуулаад бид наадмын өдрүүдэд тэр цэвэр цусны адуу уралддаг морин тойруулгыг баяр наадмын зориулалтаар ашиглах бололцоо байж болох юм гэдэг зүйлийг хуулийн төсөл боловсруулж байхдаа бид ярилцаж байсан. Энэ бүрэн шийдэгдэх.../минут дуусав/

**Г.Занданшатар:** П.Сайнзориг гүйцээгээд хариулчих. Бүтэн хариул. 81. П.Сайнзориг.

**П.Сайнзориг:** Тэр баяр наадмуудыг өөр өөр өдөр өдрүүдэд тэмдэглэж байгаа асуудал дээр Монгол Улсын Засгийн газар, тэр дундаа Шадар сайд нэлээн анхаарч байгаа. Албан шаардлага чиглэлүүдийг хүргүүлж байгаа.

Тэгэхдээ бид хуулийг сурталчлах, орон нутгуудаа зөв ойлгуулах асуудлыг сайтар хийе.

Тэгээд цаашдаа ер нь үүнийг бөхийн холбоо нөгөө бөхчүүдийн эрэмбийг тогтоохдоо ч юм уу, олгосон тэр цол энэ тэрийг нь олгох уу, үгүй юу

гэдэг асуудал Монголын Үндэсний бөхийн холбооны шийдэх асуудал байгаа юм.

Тэгэхээр орон нутгууд маань ч гэсэн энэ дээр анхааралтай хандаж, хуулийн хүрээнд баяр наадмаа зохион байгуулах асуудал нь чухал байгаа юм. Тэгээд бид цаашдаа энэ асуудлыг илүү анхаарч ажиллая.

**Г.Занданшатар:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

**С.Ганбаатар:** Засгийн газраас Шадар сайд С.Амарсайханы оруулж ирж байгаа энэ хууль маш чухал сайн хууль орж ирсэн байна.

Наадмын тухай хууль бол зүгээр нэг амралтын тухай биш шүү дээ. Энэ чинь. Өвөг дээдэстээ үнэнч байх, мөнх тэнгэртээ үнэнч байх. Хамгийн гол нь өв уламжлал, ухаарал, эр зориг, тэмцэх чанар, тайвшрал, эрэмбэ, дэгээ бид ойлгох гэж энэ наадмыг хийдэг. Энэ чухал зүйл байна.

Хэдэн тодруулах асуултууд байна. Хүмүүс их хүч хөдөлмөр гаргадаг. Ганцхан бөх биш ээ. Сурын харваа, морь, шагай, жороо морь, олон энэ өв соёлоо тээж явж байгаа улсуудыг бид хүндлэх ёстой. Сэвтэж байгаа, бас бэрхшээлүүд байгаа. Үүнийг төрөөс зохицуулах ёстой.

Тэгээд энэ орж ирж байгаа асуудалтай холбогдуулж би хоёр асуулт асууя.

9.9-д Бүх цэргийн баяр наадмыг жилд нэг удаа Засгийн газрын шийдвэрээр явуулна. Батлан хамгаалах яамны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн “цэргийн харцага”, үзүүрлэсэн бөхөд “цэргийн заан”, түрүүлсэн бөхөд “цэргийн арслан” цол олгоно гэж байна.

Цэргийн арслан түрүүлчхээд дараа жил нь дахиад түрүүлбэл “аймгийн арслан”, “хурц арслан” гээд ингээд цол чимэг өгөөд явдаг. Энэ асуудал байгаа юу? Энэ чинь хүний маш их хөдөлмөр, тэмцэл. Нэгдүгээр миний асуулт. Цэргийн арслангийн эрэмбэ, дэв хоёр, гурав түрүүлбэл яах вэ?

Хоёрдугаар асуулт. Аймаг, цэргийн цолтой бөхчүүд наадамд барилдахад хэн нь эхэлж ам авах вэ? Тийм. Цэргийн арслан авах уу? Аймгийн арслан авах уу? Цэргийн заан авах уу? Аймгийн заан авах уу?

Мэдээж энэ эдийн засгийн асуудал биш байж болно. Энэ цалин хөлстэй холбоотой асуудал биш байж болно. Гэхдээ Монголоо хайрладаггүй, монголоо ойлгодоггүй, өвөг дээдэстээ таалагдаагүй тийм хүмүүс эдийн засгийн тухай ямар ч ойлголтоггүй байна гэсэн үг.

Энэ бол цаад утгаараа бидний барьж авч чадахгүй, биет биш, эдийн засгийн ойлголтоор ойлгож чаддаггүй, хэмжиж чаддаггүй том ойлголт, давуу тал юм.

Ингээд миний хоёр асуултад та бүхэн хариулж өгнө үү.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ?  
80. Ц.Магалжав. Цэрэндашдоржийн Магалжав. Үндэсний бөхийн холбооны тэргүүн.

**Ц.Магалжав:** Цэргийн наадмын тухай товчхон тайлбарыг нь өгье.

Ардын хувьсгал 1921 онд ялаад 2021-2025 оны улсын баяр наадам “**Бүх цэргийн баяр наадам**” гэдэг нэршлээр зохион байгуулагдаад ирсэн түүхтэй зүйл юм.

1992 онд цэргийн наадмыг бүх цэргийн хар сүлдийг цэнгүүлэн тахиад цэргийн наадмыг хийж ирсэн юм.

Цэргийн наадамд барилдсан бөхчүүдэд олгож байгаа цол нь аймгийн наадамд барилдаж амжилт гаргасан бөхтэй дүйцэх хэмжээний ийм цол байгаа юм.

Тэгэхээр таны асуусан асуултад хариулахад эрэмбийн хувьд аймгийн арслан цолтой, аймгийн цолтойгоо яг адилхан байна.

Дахиад хоёр, гурав түрүүлээд явах юм бол чимэг нь нэмэгдээд “**хурц**”, мөн “**бадрангуй**” гэсэн чимэг нэмэгдээд явдаг заалт байгаа. Эрэмбэ нь яг Үндэсний бөхийн холбооны дүрмээр зохицуулагдаад аймгийн цолтойгоо дүйцээд явах юм. Энэ нь амжилтаараа байгаа юм. Амжилт нь аймаг, цэргийн наадамд хэд шөвгөрсөн, хэд түрүүлж, үзүүрлэсэн. Адилхан эрэмбэтэй бол он дарааллаараа явдаг дүрмийн зохицуулалттай байгаа юм.

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга гүйцэж хариулъя.

**Н.Энхболд:** С.Ганбаатар гишүүн их чухал асуулт асуулаа.

Яг үүнийг тодотгоод авах хэрэгтэй байсан юм. Түрүүн бид ярьсан. Байнгын хороон дээр хэлэлцэх гээд ярьсан.

Зүгээр энэ саналтай холбогдуулаад Байнгын хороон дээр анхны хэлэлцүүлэг хийхдээ нэг зүйлийг бид анхаармаар юм билээ. Одоо жишээ нь, энэ хуулийн 3 дугаар зүйл, 9.8 дугаар заалт гэж байгаа. Улсын баяр наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрсөн бөхийн

эрэмбийг Үндсэн бөхийн холбооны дүрмээр зохицуулна гээд.

Тэгэхээр энэ зөвхөн улсын наадамд түрүүлж, үзүүрлэж, шөвгөрснийг ингээд заачихаар сая Ц.Магалжав тэргүүний хэлж байгаа шиг бусад аймаг, сум, цэргийн наадамд түрүүлсэн, цол авсан бөхчүүдийн эрэмбийг тогтоох асуудал нь үлдчихээд байгаа юм.

Тэгэхээр бид Байнгын хороогоор хэлэлцэх үедээ энэ “улсын наадамд” гэдгийг нь “түрүүлж, үзүүлж, шөвгөрсөн” гэдгийг нь орхиод ер нь бөхийн цолны эрэмбийг Үндэсний бөхийн холбооныхоо дүрмээр зохицуулна гээд оруулчихад ямар ч маргаангүйгээр цол нь ч тэр. Тийм ээ. Эрэмбэ нь ч тэр, наадмынх нь шатлал ч тэр маргаангүй зохицуулчихаар юм билээ. Үүнийг бид бодох ёстой юм билээ.

Хоёрдугаарт, Засгийн газраас өргөн мэдүүлчихсэн хойноо нэг зүйл Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ярих үед хөндөгдсөн нь юу вэ гэхээр “даян аварга” цолтой бөх түрүүлбэл “дархан аварга” цолыг нь олгоно гэсэн юм нь яг орхигдчихсон юм шиг санагдсан.

Зүгээр одоо бид ерөөсөө угаасаа тэгээд л ирсэн юм. “Арслан” түрүүлбэл “аварга” болно. “Аварга” түрүүлбэл “даян” болно гээд явдаг юмаа угаасаа тэгж ирсэн гэж ярьж явах нь болохгүй болчихсон санагдаад байгаа юм.

Яагаад гэхээр Ерөнхийлөгч ямар нэгэн хуулийн заалтыг юм уу, эсхүл албан ёсны зохицуулалт үндэслэж байж тэр цолуудыг олгох учраас одоо бид Байнгын хороон дээр нэг нь зарчмын зөрүүтэй санал гаргаад ч юм уу эд нарыг нь тодруулаад тодруулаад өгчихвөл

нэгмөсөн олон дахин гар хүрэхгүй.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

**С.Ганбаатар:** Энэ маш чухал асуудал. Зүгээр нэг баяр цэнгээн төдий биш ээ. Энэ уламжлал, ёс зүй, хамгийн гол нь монгол хүн байх ухаан үүгээр л дамжиж ирж байгаа.

Тэгээд миний ах аймгийн заан цолтой. Үргэлж би түүгээр цадаж, баярлаж, бахархаж явдаг. Одоо хүн болгон.

Аймгийн цол чухал. Тэгэхдээ цэргийн цол бол бүх цэргийнх шүү дээ. Энэ чинь улсын чанартай болоод явчхаж байгаа.

Тэгэхээр энэ нь яг ижилхэн аймгийн, цэргийн хоёр ижилхэн түвшинд байвал эрэмбийг нь төрөөс зохицуулалт хийх нь зөв байх. Цэргийнх нь арай түрүүнд нь байдаг юм уу ийм зохицуулалт хийх нь зөв болов уу гэсэн зүйлийг протоколд би тэмдэглүүлж үлдээе.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүд ээ, зочид танилцуулъя.

Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэгийн санаачилгаар анх удаа манай улсад зохион байгуулж байгаа Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын олон улсын уулзалтад оролцогчид Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна.

Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалтад Герман, Франц,

Индонез, Лихтенштейн, Өмнөд Африк, Австрали, Мозамбик зэрэг улсуудын төлөөлөл, мөн Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /OSCE/ болон олон улсын бусад байгууллагын төлөөлөгчид оролцож байна.

Энэ уулзалтаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, хүнсний аюулгүй байдал болон олон улсын энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэхэд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг дэлхий дахины нийтлэг анхаарал татаж буй асуудлуудыг хэлэлцэж байна.

Олон улсын зохих оролцоотойгоор хүн төрөлхтний амин чухал асуудлуудыг хэлэлцэж байгаа энэ уулзалтаас хамтын ажиллагааны чиг хандлагыг тогтоосон бодит үр дүн гаргана гэдэгт итгэлтэй байна.

Монгол Улсын Их Хурал шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, нийгмийн ээдрээ түвэгтэй, зөрчилтэй шийдлээ хүлээсэн чухал асуудлуудад тэдний хүч нөлөөллийг ашиглахад анхаарал хандуулж бодитой алхмуудыг хийж байна.

Г.Тэмүүлэн гишүүн ээ, та хоёр энэ хүмүүст хүндэтгэлтэй хандаач.

Мөн хууль тогтоох үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг дэмжих, жендэрийн мэдрэмжтэй парламентыг бэхжүүлэх чиглэлээр Олон улсын парламентын холбоотой Монгол Улсын Их Хурал нягт хамтран ажиллаж байгаа.

Тухайлах юм бол хэдхэн хоногийн өмнө Монгол Улсын Их Хурал “Алтайд дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээр” чуулга уулзалтыг

Улаанбаатар хотод зохион байгуулж, бүх салбар дахь эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг дээшлүүлэх асуудлуудыг Стэнфордын их сургууль, “**Бан Ги Мун сан**”-тай хамтран зохион байгуулж хэлэлцлээ.

Өнөөдөр бид улс төрийн нам, сонгуулийн тухай хуулиудыг шинэчлэн найруулж, улс төр, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, баталгаажуулах чиглэлээр тодорхой ахиц, дэвшил гарган ажиллаж байгаагаа онцлон тэмдэглэж дурдахад таатай байна.

Та бүхний уулзалт, хурлын үйл ажиллагаанд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс өндөр амжилтыг хүсэн ерөөж, сайн сайхныг хүсье. /алга ташив/

Одоо Буланы Бейсен гишүүн асуултаа асууна.

**Б.Бейсен:** Энэ Баяр наадмын тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм.

Тэгээд хоёр асуулт асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт, энэ допингийн асуудал. Бөхчүүдийн. Энэ допингийн шинжилгээг заавал гадаад хийлгээд байх уу? Манайд дотооддоо хийж болдоггүй юм уу? Манай эрдэмтэд хийж чадах байх гэж бодож байна. Тоног, төхөөрөмж аваад дотооддоо хийх боломж байдаггүй юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Э.Оюунболд аваргын эрхийг 8 жилээр хаслаа гээд тэгж ярьж байна. Энэ үнэхээр батлагдсан юм уу? Өвдөг нь өвдсөн. Эм уудаг юм байна.

Түрүүн надтай тааралдсан. Тэгээд би хэрэглээгүй. Өвдөгний эм уусан. Түүнээс гарсан юм болов уу гэж байна.

Тэр найрлагад нь жишээлбэл өвчин намдаах эм юм уу, ямар нэгэн найрлага байгааг нь тогтоох юм байдаггүй юм уу? Заавал гадаадад бид хийлгээд байх уу? Гадаадын юунд хийлгэж байх нь жаахан зохимжгүй байна л даа. Дотооддоо шийдэж болдоггүй юм уу?

Хоёрдугаарт, тэр Б.Бат-Өлзий заан байна. 524 бөх барилдаад түрүүлсэн. Түүнд арслан цол олгох уу? Энэ удаад. Энэ талаар.

Хоёрдугаар асуудал, энэ баяр наадам улс даяар аймаг, сум нэг л өдөр хийнэ гээд тэгж байна. Сумдаа түрүүлээд аймагт барилдах бөхчүүд байна. Үүнийг яаж шийдэх вэ? Ер нь.

Зарим нүүдлийн сумд байж байна. Зундаа наадам хийх боломжгүй. Манайд 5, 6 сум байна. Нүүгээд явчихдаг. Тэгээд тэр цэнгэлдэх нь бас байхгүй тийм газар. Үер, устай. Тэгээд ногоо гараагүй үед нь.

Манай аймагт 7 сарын 01-нээс ногоо гараад 8 сарын 01 шарлачихдаг юм шүү дээ. Бараг. Уултай газрууд. Ихэнх нь уул руу гарчихдаг. Тэгээд намаржаандаа буух үедээ зарим нь тэгш ойгоо хийх сумууд байдаг.

Үүнийг яаж зохицуулах вэ? Аймагтаа эрхийг нь өгөх үү? Аль эсвэл нэг л өдөр хийнэ гээд ингээд зохицуулах уу? Тэр талаар асууя.

**Г.Занданшатар:** 82. Дэлэгниамдоржийн Мөнхболд. Монголын допингийн эсрэг байгууллагын гүйцэтгэх захирал.

**Д.Мөнхболд:** Допингийн хяналтын шинжилгээг Дэлхийн допингийн эсрэг агентлагаас итгэмжлэгдсэн допингийн хяналтын лаборатори нь хийдэг.

Өнөөдөр 27 улсад допингийн хяналтын лаборатори 30 ширхэг үйл ажиллагаагаа явуулж байгаа. Өнөөдрийн байдлаар.

Монгол Улсад допингийн хяналтын шинжилгээ хийлгэх лаборатори одоохондоо байхгүй байгаа.

**Г.Занданшатар:** Буланы Бейсен гишүүн тодруулж асууна. 1 минут.

**Б.Бейсен:** Би өөрөө бас бөх, эмч хүний хувьд асууж байна л даа.

Допингийн лабораторийг байгуулаад олон улсын итгэмжлэлийн эрх авах боломжтой байгаа байхгүй юу. Авч болно. Тэрийг чинь.

Тийм учраас байнга ингэж байснаас допингийн юу авч байгаад нэг, хоёр жилийн дараа тэр допингийн шинжилгээг дотооддоо хийх олон улсын эрх авч болно. Үүнийг чинь Эрүүл мэндийн яамтай ярьж байгаад үүнийг авах тал дээр нь яриад цаашдаа ажил хэрэг болгох шаардлагатай байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Хариулт болчихсон уу? Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье. Ц.Магалжав тэргүүн нэмж хариулья.

**Ц.Магалжав:** Таны асуултад хариулья.

КОВИД-ын жил буюу 2021 онд Үндэсний бөхийн холбооноос “Хүй долоон худагт” 512 бөхийн барилдааныг зохион байгуулсан.



Энэ барилдаанд барилдсан бөхчүүдэд цол олгуулах хүсэлтийг Монголын Үндэсний бөхийн холбоо 2022 оны 7 дугаар сард Улсын Их Хурлаар батлагдсан Дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу.

Энэ хууль дээр нь “**Үндэсний бөхийн маргаантай цолыг Монголын Үндэсний бөхийн холбооны саналаар нэг зарчим, нэгдсэн журмаар эрх бүхий этгээд шийдвэрлэж болно.**” гээд заачихсан.

Тэгээд хуулийн заалтад нийцүүлээд 512 бөхийн барилдаанд амжилт гаргасан бөхчүүдийн цолыг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Гүйцээгээд хариулчихъя. Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье. Ц.Магалжав тэргүүн гүйцээгээ хариулъя.

**Ц.Магалжав:** Манай холбооны зүгээс маргаантай цол гэж бас үзэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл 330 сум, 21 аймаг нь бөхийн цолоо олгочихсон. Уяачдад нь цолыг нь олгочихсон байгаа юм.

Тэгээд маргаантай цол гэж үзэж байгаа учраас үндсэн холбооны эрх үүргийнхээ дагуу бөхийн эрх ашгийг хамгаалах үүрэгтэй. Үүнийхээ дагуу эрх бөхийн этгээдэд нь санал хүргүүлж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Б.Бейсен гишүүний асуултад нэмж хариулъя. П.Сайнзориг дарга хариулъя.

**П.Сайнзориг:** Б.Бейсен гишүүн тэр сумын наадам, аймгийн наадмуудын хугацаатай холбоотой асуудлыг асуулаа.

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5.2 дээр аймаг, сумын баяр наадмыг 7 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд тэмдэглэхээр хуульчилсан.

Тэгэхээр магадгүй сум нь 10-даа тэмдэглээд, аймаг нь 11-дээ ч гэдэг юм уу ингээд тэмдэглээд явахад зөрөх ер нь бүрэн боломжтой гэж харж байгаа.

Үнэхээр тэр онцгой тохиолдолд асуудал үүсээд өөр өдрүүдэд тэмдэглэнэ хийх юм бол тухайн аймгийн Засаг дарга нь сумын наадмуудаа тэмдэглэх өдрүүдээ 8 сарын 10-ны дотор багтаагаад зохион байгуулах бүрэн боломжтой байгаа юм.

Тэгэхээр тодорхой хэмжээнд энэ хуулийн бүрэн боломж байна. Бид хэд зөв зохион байгуулалт хийж чадвал сумдууд маань 10-даа наадаад, 11-дээ аймгийн наадамдаа оролцоод явах уяачдын хувьд ч тэр, бөхчүүдийн хувьд ч тэр бүрэн бололцоо нь байна.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Гонгорын Дамдинням гишүүн үг хэлье.

**Г.Дамдинням:** Баяр наадмын тухай хууль яах вэ, одоо ингээд хүмүүсийн дунд яриа байдаг юм л даа. Энэ чухал уу, биш үү гээд.

Энэ бол жинхэнэ нөгөө монгол дархлаа, монгол хүнийг бүтээхэд их үр нөлөөтэй ийм л юм шүү дээ.

Бид жилдээ энэ залуу үедээ цагаан сараар нэг удаа, улсын баяраар нэг удаа монгол дархлааны их том дооз шахчхаж байгаа юм.

Тэгэхээр үүнийг бид их чухал авч үзэх ёстой. Энэ хуулийг яагаад бид онцгой харах ёстой вэ гэхээр наадам сайхан болох ёстой. Наадам сайхан болоход шударга шийдэгддэг байх ёстой. Шударга шийдэгддэг байхын тулд хариуцлага нь тодорхой байх ёстой л байхгүй юу.

Сая ингээд л тодорхой хугацаа заагаад өгчихсөн байхад гишүүд асуугаад байна. Юу яригдаад байгаа вэ гэхээр бүгдийг нь жигд явуулья гэдэг засгийн шийдвэр гарчхаад байхад энд тэнд зохион байгуулаад байна гээд.

Тэгээд л засгийн шийдвэрээ дагахгүй байгаа сум, аймгийн наадмын цол чимгийг нь өгөхөө больчихгүй юу даа. Тэгээд тэр ёс зүйн асуудал гаргаад байгаа, хууль, дүрэм зөрчөөд холбоогоо тоохгүй байгаа, ёс зүйн зөвлөлөө тоохгүй байгаа энэ хүмүүсийнхээ цол чимгийг хураадаг, хариуцлага тооцуулдаг ийм систем энэ хуулийнхаа боловсруулалтын явцад сайн анхаарч хийгээрэй.

Наадам шударга сайхан болчих юм бол ард иргэд бүгдээрээ л баяртай байдаг. Наадам сайхан боллоо гэдэг. Энэ бас ингээд дархлаатай холбоотой их чухал зүйл учраас Та бүхэн анхаараарай л гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан үг хэлье.

**С.Амарсайхан:** Дарга нэг ийм асуудал байгаа юм.

Энэ цол, чимэгтэй холбоотой, аварга цол олгохтой холбоотой бас нэг ганц хоёр. Ер нь үзэл баримтлалтайгаа нийлж байгаа хэдий ч зүгээр үг, үсгийн

бас нэг нэмж зохицуулах асуудлууд байгаа. Үүнийг та Байнгын хороон дээр ярилцаж хэлэлцэж, тодорхой болгож шийдвэрлэ гэдэг ийм нэг чиглэл өгчихмөөр байгаа юм. Тийм.

**Л.Мөнхбаатар:** Одоо бол яах вэ, энэ таны оруулж ирсэн Үндэсний их баяр наадмын тухай хуулийн хэлэлцэх эсэхийг нь ярьж байгаа.

Гэхдээ С.Амарсайхан сайдын ярьсан агуулгаар Байнгын хороон дээрээ уг асуудлыг авч хэлэлцэхийг чиглэл болгож байна.

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны саналаар Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

61.0 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Б.Бейсен гишүүн түрүүн дэмжиж дарсан протоколд тэмдэглэе.

Дараагийнхаа асуудалд орёе. Ажлын хэсэгт баярлалаа.

**Гурав.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**

*/Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун танилцуулна. Таныг индэрт урьж байна. Х.Болорчулуун сайд.

**Х.Болорчулуун:** Улсын Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2022 оны 04 дүгээр тогтоолоор Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд заасан мал эмнэлгийн байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийн давхардлыг арилгах, Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Мөн уг тогтоолоор Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэгтэй

байгууллагуудын жагсаалтад Мал эмнэлгийн албыг нэмж оруулах хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан байдаг.

Түүнчлэн “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолд өндөр ашиг шимт малын үр хөврөлийг гадаад улсаас нэгдсэн бодлогоор авах, үржил, селекцийн ажилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан.

Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах талаар салбарын хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдээгүйгээс мал, амьтны гоц халдварт өвчний гарал, тархалт нэмэгдэх, малын генетик нөөцийг ашиглах тусгай зөвшөөрөл олгох, тавих тусгайлсан нөхцөл, шаардлага тодорхой бус байгаагаас малыг өөрийн дур зоргоор үржүүлж ашиглаж, үүний улмаас малын үүлдэрлэг байдал, тэсвэр чанар алдагдах, бие давжаарах, ашиг шим буурах нөхцөл байдал үүсээд байна.

Иймд эдгээр асуудлыг шийдвэрлэх Монгол Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дээрх тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор мал аж ахуйн салбарын харилцааг зохицуулж байгаа

Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Малын генетик нөөцийн тухай, Амьтан, ургамлын тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт дараах үр дагавар гарна.

Хууль, тогтоомж үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад бодлогын баримт бичигт тусгагдсан хүнсний аюулгүй байдлыг хангах, мал, амьтны эрүүл мэнд, малын удмын санг хамгаалах, баталгаажуулах, мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг экспортлох талаарх зорилтууд хэрэгжих боломж бүрдэх юм.

Мал эмнэлгийн хяналтын нэгдсэн тогтолцоо бий болж, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд тавигдах худалдааны түнш орнуудын шаардлагыг хангах нөхцөл бүрдэнэ.

Төрийн байгууллагууд давхардуулан гэрчилгээ олгодог явдал үгүй болж, бизнес эрхлэх таатай орчин бүрдэж, иргэдийн эрхийн баталгаа сайжирна.

Хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Х.Болорчулуун сайдад баярлалаа.

Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны

санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакир танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Т.Аубакир:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч мал аж ахуйн салбарын хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, мал эмнэлгийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт, гаалийн болон мэргэжлийн байгууллагын дундын мэдээллийн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, мэдээлэл дамжуулах, хэрэглэхтэй холбоотой зохицуулалт, мал, амьтан, эдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой төрийн байгууллагуудын бүрэн эрхийг тодорхой болгохоор уг хуулийн төслүүдийг боловсруулсан байна.

Мал аж ахуйн салбарын хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгаснаар үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад бодлогын баримт бичигт тусгагдсан хүнсний аюулгүй байдлыг хангах, мал, амьтны эрүүл мэнд, малын удмын санг хамгаалах, баталгаажуулах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг

экспортлох таатай орчин бүрдэнэ гэж үзэн хууль санаачлагчид хуулийн төслийг боловсруулан D-Parliament.mn сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогогийн Энхтүвшин Гаалийн ерөнхий газрын Хилийн мэргэжлийн хяналтын алба мах экспортлох зөвшөөрлийг өгч байгаа нь олон улсын дүрэм журмыг зөрчиж байгаа гэснийг тодруулах, Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал хамгаалалттай аж ахуйн талаар, түүнчлэн малын гоц халдварт өвчний онош нь батлагдаагүй байхад нийтэд мэдээлэх, баталгаажсан тохиолдолд олон улсын байгууллагад хүргүүлэхгүй нуун дарагдуулахыг хориглоно гэж заасныг тодруулах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан орон нутгийн мал эмнэлгийн албаны хүний нөөцийн дутагдлыг хэрхэн шийдвэрлэх, малын гоц халдварт өвчнийг бууруулахад салбарын яам бодлогын шинэчлэл хийж байгаа эсэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх асуудалд баримталж байгаа бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир мал, махыг экспортлох нэг цонхны бодлогын явц, байдлын талаар асуулт асууж хариулт авлаа.

Түүнчлэн хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир мал, махны экспортын хүндрэл, чирэгдэл учруулахгүйгээр шийдвэрлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг төрөөс тууштай дэмжих, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин мал эмнэлгийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, малын эрүүл мэндийг хамгаалах, дархлаажуулалт болон мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг тухайн жилийн

инфляцтай уялдуулан тогтоох зохицуулалтыг холбогдох хуулийн төсөлд тусгахад салбарын яам анхаарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал хөдөө аж ахуйг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэхэд анхаарч, шинжлэх ухааны хүрээлэн, салбар яамдын уялдаа холбоог хангаж хамтарч ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хөдөө аж ахуйг шинэчлэх, нүүдлийн мал аж ахуйгаас хагас суурин хэлбэрт шилжих, бэлчээрийн асуудлыг зохицуулах, эрүүл бүсийг байгуулах. Ингэснээр мал, махны экспортлох асуудлыг нэмэгдүүлэх талаар нэгдсэн бодлого, төлөвлөгөө гаргаж ажиллах нь зүйтэй гэсэн санал хэллээ.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 71.4 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд  
ээ,

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт

оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Т.Аубакир гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлгийн бодлогын асуудал эрхэлсэн ахлах шинжээч Хөхөөгийн Алтангэрэл, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Аюушжавын Нарантуяа, Мал эмнэлгийн ерөнхий газрын Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газрын дарга Сандагийн Батхуяг нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Г.Тэмүүлэн гишүүнээр тасаллаа. Б.Бейсен гишүүн асуултаа асууя.

**Б.Бейсен:** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа юм.

Ер нь мал эмнэлгийг улсын мэдэлд авахгүй бол болохгүй нь. Одоо энэ сумдын бүх мал эмнэлгүүдийг хувьчилчихсан. 70, 80 сая малтай байж мал эмнэлгийн газар байхгүй. Зарим нь бүр мал эмнэлгийн сумдын контор, эм хадгалах юу ч байхгүй.

Үүнийг цаашдаа улсын мэдэлд авахгүй бол жинхэнэ анхан шат гэдэг шиг мал аж ахуй дээр ажиллаж байгаа, яах вэ Хөдөө аж ахуйн яаман дээр юу байж байна. Тийм ээ. Улсын мэдлийн харьяа газар нь байж байна. Аймаг, сумууд дээр чинь тийм юм байхгүй.

Тийм учраас үүнийг улсын мэдэлд авах шаардлагатай.

Хоёрдугаарт, мал, амьтны гаралтай хэчнээн төрлийн вакцин үйлдвэрлэж байна. Дотооддоо үйлдвэрлэж чадаж байна уу? Заавал гадаадаас авч байна уу?

Нөгөө талаар гадаадаас орж ирж байгаа эмийн хоруу чанар энэ тэрийг судалсан уу? Сүүлдээ малчид ярьж байна. Малын махны үнэр арилжчихаад байна.

Энэ имопектой холбоотой байна уу, өөр эмтэй нь холбоотой байна уу гээд асуудал тавьж байна л даа. Энэ талаар асууя.

**Л.Мөнхбаатар:** Б.Бейсен гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Х.Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Б.Бейсен гишүүн мал эмнэлгийг улсын мэдэлд авах хэрэгтэй гэж байна.

Ер нь тийм яриа сүүлийн үед гардаг болсон. Яагаад гэвэл яг анхан шатын нэгж дээр сум, баг дээр мал эмнэлгийн байгууллага үйлчилгээ муудсан гэж ярьдаг. Үүний улмаас малын өвчин тархалт нь нэмэгдсэн.

Энэ гол шалтгаан нь малын эмч нарынхаа ажиллах нөхцөл, боломжийг хангаж, малын эмч нар ажиллах үйлчилгээний хөлсийг хэт бага байсантай холбоотойгоор мал эмнэлгийн үйлчилгээ яг малдаа хүрэхгүй болсон юм.

Өнгөрсөн жил хүртэл нэг үхрийг тарихад, вакцин хийхэд 200 төгрөгөөр хийж байсан. Харин одоо 400 болсон. 200 төгрөг гэхээр ер нь мянган үхэр тарихад 200-хан мянга байна шүү дээ.

Тэгэхээр чинь тэр үхэр тарихад ганц хүн тарьчихгүй. Үхэр баригч байна, бензин тосны зардал байна. 400 байгаад ч энэ бага.

Та бүхэн мэдэж байгаа. Бараг хотод энэ дуудлагын сувилагч энэ тэр нэг хүн тарихад 10 мянгаар тарьдаг шүү дээ. 20 мянгаар тарьдаг. Тэгэхэд л 200, 400 төгрөгөөр хөдөө явж байгаад үхэрт үйлчилгээ хийж байгаа энэ байдал нь өөрөө малын эмч нарын хөдөлмөрийг үнэгүйдүүлсэн юм.

Ингээд малын эмч нар хангалттай Монгол Улсын хэмжээнд гарч төгссөн. Тооны хувьд хангалттай байгаа. Ажиллах нөхцөл, боломж нь ийм байдалд хүрсэн.

Цаашдаа бид энэ мал эмнэлгийн тарилга, үйлчилгээний хөлсийг, эмч нарын хөлсийг нэмэгдүүлэх бодлого баримталж Сангийн яаманд санал оруулаад байгаа гэдгийг хэлье.

Тэгж байж мал эмнэлэг хөгжинө. Түүнээс биш заавал улсад авснаараа

хөгжих юм биш. Нэгэнт хувьчилсан чигээрээ бид үйлчилгээнийхээ хөлсийг сайжруулаад л мал эмнэлгийн анхан шат дээрээ чадваржуулах явдал хамгийн чухал гэдгийг хэлье.

Тэр хэдэн төрлийн вакцин үйлдвэрлэж байна гэж. Энэ дээр тодорхой нарийн хариулаадах. Ажлын хэсэг нэмж.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэг. Хэн хариулах юм? Хэд вэ? 84 үү? Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд гишүүний асуултад хариулаарай.

**А.Нарантуяа:** Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын үүрэг гүйцэтгэгч А.Нарантуяа.

Ерөнхийдөө гоц халдварт өвчний 3 вакциныг гаднаас авдаг. Бусад 20 орчим төрлийн вакцин, оношлуурыг Монголын биоүйлдвэртээ үйлдвэрлэдэг.

Нийтдээ 1600 мал эмнэлгийн нэгж ажиллаж байна. 330 сумд тасаг 2 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа. Шинэ хуулиар.

Тэгээд ерөнхийдөө 1400 орчим малын эмч нар одоогийн байдлаар ажиллаж байна.

**Л.Мөнхбаатар:** Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд өглөөний мэнд хүргэе.

Энэ мал, махны экспорттой холбоотой асуудал дээр ер нь онцгой анхаарахгүй болохгүй нь.

Ер нь бид дорвитой юм хийхгүй бол экспортыг нэмэгдүүлнэ л гэж яриад байдаг, яриад л байдаг.

Ер нь эрдэмтдийн судалгаагаар одоо манай Монгол Улсын малын бэлчээрийн даац 50-иад сая байхад нормал болох гээд байна. Гэтэл бидэнд 70-аад сая байгаад байдаг. 20 сая малыг бид эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал энд яригдаж байгаа гэж ингэж ойлгож байгаа.

Тэгэхээр надад одоо жишээ нь малчидтай очоод уулзахад Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын н.Жамбалжамц гээд малчин юу гэж байна вэ гэхээр бид малын мах үнэгүй болчихоод байгаа учраас малын тоог шүтэж амьдарч байна шүү дээ. 2 сая төгрөгтэй болохын төлөө 20 хонийг 2 жил хариулж байна гэж хэлж байгаа.

Баянхутаг сумын н.Чинзориг гээд малчин энэ экспортын асуудлыг хурдхан төр засаг байдаг бол олигтойхон шийдээд өгөөч ээ. Нэг шуурганаар бид 200, 300 адуугаа үхүүлмээргүй байна. Хэрвээ энэ ингээд экспорт нь чөлөөтэй байсан бол явуулмаар байна гээд ингээд яриад байгаа юм.

Тэгэхээр яг экспортыг нэмэгдүүлэх тал дээр бодитой яг ямар ажлууд хийгдэж байгаа вэ? Би хоёр тодорхой юм асууя гэж бодож байна.

Одоо малын бүс болгоод ангилаад эхэлсэн. Сүхбаатар аймаг, Хэнтий аймгийн Дорнод. Энэ баруун аймгуудаар.

Ингэж ялгаж эхэлснээс хойш нэлээдгүй хугацаа өнгөрлөө. Одоо яг тодорхой юу хийсэн бэ энд. Хэзээ үр дүн гарч эхлэх юм бэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, малын амьдаар нь гаргах ажил ганцхан Замын-Үүд дээр ганцхан аж ахуйн нэгж гаргаад байна гэж байгаа юм. Энэ цаашаа нэмэгдэх юм уу? Нэмэгдвэл хэзээ нэмэгдэх вэ? Хаагуур гаргах юм бэ гэсэн ийм зүйл.

Хоёр дахь асуудал бол одоо энэ орон нутгаар яваад малчидтай уулзаад, энэ отрын бүс нутгаар явж байхад ахмад малын эмч нарын хэлээд байгаа зүйл бол Монгол Улсад гарч байгаа энэ малын замбараагүй өвчин чинь ердөө л зах замбараагүй шилжилт хөдөлгөөн шүү. Үүнийгээ хэзээ, яаж журамлах юм бэ? Ямар дүрэм, журам байдаг юм бэ?

Отрын бүс нутаг гэхэд зүүн аймагт яагаад баруун аймгаас ирээд байдаг юм. Дунд нь байгаа 7, 8 отрын бүс нутагт яагаад ирдэггүй өөр газар луу очоод байдаг юм. Ийм замбараагүй юмнаас болоод энд тэндгүй малын өвчин гардаг.

Энэ малын шилжилт хөдөлгөөн гэдэг зүйлийг ер нь яг яаж зогсоох юм бэ? Цаг уурын нөхцөл байдал хүндэрлээ гэхэд яаж, ямар зохицуулалтууд хийх юм бэ? Энэ дээр бас онцгой анхаарахгүй бол болохгүй нь.

Дараагийнх нь, энэ малын экспорттой холбогдуулаад үнийн асуудал. Бид малаа гадагш нь гаргаж байвал сайн байна гэж нэгдүгээрт ярьж байгаа. Одоогийн байдлаар сайн байгаа.

Гэхдээ гаргаж байгаа малын маань үнэ дэлхийн зах зээлийн үнэ хоёрын хооронд ямархуу зөрүү байгаа вэ? Энэ дээр яам ямар бодлого баримталж байгаа вэ?

Бид малаа хорогдуулахын тулд л гадагшаа гаргаж байгаа биш. Энэ эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулахын



тулд гадагшаа гаргаж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр тэнд борлуулагдаж байгаа махны үнэ, Монголоос гаргаж байгаа мах хоёрын хооронд ер нь ямархуу зөрүү байдаг юм бэ? Энэ дээр татварын бодлого, янз янзын юм юу байдаг юм бэ?

Надад ирж байгаа мэдээллээр одоо бид нар гадагшаа гаргалаа л гэж байгаа. Үхрийн махаа 12 мянгад өглөө гэсэн ийм л зүйл яригдаж байгаа. Гэтэл цаанаа тэр үхрийн мах нь хэд байдаг юм. Үүний зөрүү ер нь ямархуу байдаг юм бол гэсэн ийм үндсэн гурван асуулт асууя гэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Ц.Идэрбат гишүүний асуултад хариулья. Х.Болорчулуун сайд хариулья.

**Х.Болорчулуун:** Ц.Идэрбат гишүүний асуултад хариулья.

Мал, махны экспорт муу байна гэж байна. Экспорт энэ жил өссөн. Өнгөрсөн жил 2022 оны байдлаар ердөө 16-хан мянган тонн мах экспортод гарсан. Энэ хагас жилийн байдлаар гэхэд 40 мянган тонн мах экспортод гарч байна. Оны эцэст гэхэд үлэмж нэмэгдэнэ.

Тэгэхээр экспортын хувьд тооны хувьд өссөн байгаа гэдгийг хэлье.

Малын мах үнэгүй болсон байна гэж хөдөө орон нутгийнхан ярьж байна гэж байна. Орон нутгийн малчид мал, махны үнэ бага байна гэдэг. Нийслэл болон төв суурин газрынхан махны үнэ үнэтэй байна гэж хашхирдаг. Ялангуяа хаврын үед жил болгон л махны үнэ гээд бараг үлстөржилт явагддаг шүү дээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэ хоёр заагийн дунд ажилладаг гэж хэлж болно.

Экспортын хүнд суртлыг бид арилгасан. Хуучин бүх малын махыг гаргахад квоттой байсан. Квотыг чөлөөлсөн. Үхрээс бусад малын мах дээр. Энэ бол махны экспорт нэмэгдэхэд нөлөөлсөн гэж үзэж байгаа.

Түүнээс гадна олон байгууллагаас, 6, 7 байгууллагаас олон өдөр хөөцөлдөж байж, бичиг баримт цуглуулж байж, нэгтгэж байж экспортын зөвшөөрөл авдаг байсан. Үүнийг нэг цонхны бодлогод оруулж байгаа. 7 сарын 01-нээс бүрэн цахимжаад хэрэгжиж явна гэдгийг хэлье.

Амьдаар нь мал гаргах хэрэгтэй байна гэж. Яах вэ, бид амьдаар нь ялангуяа төрийн сүлдэндээ залсан адуу гаргах үнэхээр тохиромжгүй юм билээ. Хонийг гаргаж байгаа. Зөвхөн Дорноговь аймгаар гаргаж байгаа. Тэгэхдээ баруун бүс, зүүн бүсээр гаргах санал яригдаж байгаа гэдгийг хэлье.

Тэгэхдээ ер нь бид амьдаар нь гаргаад байх биш дотооддоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн бий болгож байж малын махыг экспортлох нь хамгийн чухал бодлогын нэгээ гэж хэлмээр байна.

Малын шилжилт хөдөлгөөнийг яаж зогсоох юм бэ гэж байна. Үүнийг хүчээр зогсооход хүндрэлтэй зүйл. Яагаад гэвэл цаг агаарын байдал, хур тунадаснаас шалтгаалаад бороо хур орохгүй, өвөлдөө зудтай болоод өөрийн эрхгүй малчид аймаг, сум дамжиж нүүж байгаа.

Гэхдээ ер нь Засгийн газрын нэг журам байдаг. Үүгээр цаашдаа энэ шилжилт хөдөлгөөнийг журамлах

хэрэгтэй, шинэчлэх хэрэгтэй гэсэн ийм бодлоготой ажиллаж байгаа.

Ялангуяа зэргэлдээ аймаг, сумандаа отор нүүдэл хийж болно. Бүр өөр бүсээс огт өөр бүс рүү отор нүүдэл хийх нь энэ малын өвчин гарах, тархах нөхцөл бүрдэж байгаа юмаа, түлхэц өгч байгаа юмаа гэдгийг хэлье. Энэ дээр анхаарч ажиллаж байгаа.

Экспортод гаргаж байгаа махны үнэ хямд байна гэж байна. Үнэхээр тийм байгаа. Манай аж ахуйн нэгжүүд мах экспортод гаргахад нэг нэгнийхээ доогуур очоод гэрээ хийчихдэг.

Энэ өвөл гэхэд Узбекистан руу мах гаргаж байхад адууны.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Гүйцээгээд хариулчихъя. Х.Болорчулуун сайд нэмж хариулъя. 1 минут.

**Х.Болорчулуун:** Узбекистан руу адууны мах 3.5 доллароор гэрээ хийгээд гаргаж байхад аж ахуйн нэгжүүд нэг нэгнийхээ доогуур хийсээр байгаад 2.5 доллар хүртэл буулгаад ашиггүй болгож байсан.

Ийм ч учраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Махны холбоо хамтарч хонь, үхэр, адууны махны экспортод гаргах доод үнийн бодлого баримталж байгаа. Ингэж хэрэгжүүлж явж байгаа гэдгийг хэлье.

**Л.Мөнхбаатар:** Та тодруулах уу? Ц.Идэрбат гишүүн тодруулж асууя.

**Ц.Идэрбат:** Малын махны экспорт жилээс жилд нэмэгдэж байгаа.

Гэхдээ багасчихсан шалтгаан нь тодорхой байгаа шүү дээ. КОВИД-ын цаг

үе, тээвэр ложистик, олон хүчин зүйлүүд нөлөөлж байсан. Одоо энэ байхгүй болчихоор угаасаа урсгалаараа наадах чинь нэмэгдээд хэвийн тал руугаа орж байгаа.

Дээрээс нь би сайн юмыг сайн гэж хэлэх ёстой байх. Хөдөө аж ахуйн яам нь монголчууд өөрсдөө үүсгэчихсэн байсан энэ хүнд суртлаа маш бага болгож байгаа нь их сайн байгаа байх.

Тэгэхээр ер нь дэлхийн зах зээл, энэ тээвэр ложистик, энэ КОВИД, энэ бүхэн ард үлдлээ. Дээрээс нь дотоодын хүнд суртлуудаа байхгүй болголоо.

Одоо бид зорилт яг хэдэн тоннд хүргэх юм бэ? Тэр мал гаргах, адуунаас бусдыг гаргах гэдгийг би зөв гэж бодож байгаа.

Энэ процесс яг хэзээ эхлэх юм бэ? Судалцгаа л гэж яригдаад байгаа болохоос биш. Үүнийг чинь малчид хүлээгээд байна шүү дээ.

Одоо энэ өвөл цаг хүндэрнэ. Энэ хүндрэхийн өмнө бид энэ мал, махны экспортоо олигтой.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад хариулъя. Х.Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Махны экспорт гэж байна. Яг үнэндээ манайх олон улсын шаардлагын дагуу махны экспортыг төдийлөн хийж чадахгүй байгаа гэж ойлгож болно.

Яагаад гэвэл олон улс махыг экспортлохдоо эрүүл гэдгийг нь баталгаажуулсан ийм бүс, хамгаалагдсан аж ахуй байгуулж экспортод гаргадаг. Тэндээ тийм малын мах үнэтэй байдаг.

Одоо нийт экспортын 80 гаруй хувь нь Хятад Улс руу экспортолж байгаа. Энэ нь хоёр улс хоорондоо гэрээ хийж 80 градус чанах байдлаар ингэж махыг экспортолж байгаа. Энэ нь ч бас ингээд яг бусад улс руу экспортлохтой адилхан үнэд хүрч чадахгүй. Дотоодын лангууны үнээс илүү гарахааргүй юм экспортод гарч байгааг бид бас хүлээн зөвшөөрөх ёстой.

Цаашдаа бид яг олон улсын жишгээр тэр шаардлагынх нь дагуу эрүүл.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Одоо Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн асуултаа асууя.

**Г.Тэмүүлэн:** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл орж ирж байна.

Хуультай холбогдуулаад хэд хэдэн асуудлууд дээр нягталж, тодруулж асуух зүйлүүд байна.

Тэгэхээр мал аж ахуйн салбар улс орны эдийн засгийн суурь багана болсон энэ салбараа дэмжих, тэтгэх. Цаашлаад мал айл өрхийн эдийн засгийн үндэс болсон энэ салбар дээр онцгой анхаарал хандуулахгүй бол болохгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ дотор би нэг асуудлыг онцгойлж үзэхгүй бол бидний сүүлийн хоёр жилд давтагдаад байгаа нэг алдаа, хийдэл байгаад байна.

Энэ нь өөрөө юу вэ гэхээр эм, тариа, вакцины хангамжтай холбоотой, хүртээмжтэй холбоотой асуудлууд байна.

2021 оны намраас авхуулаад зүүн аймгуудаас эхлээд, хил залгаа аймгуудаас

эхэлж энэ богийн мялзан, шүлхий, дээрээс нь үхрийн арьс товруудах өвчин энэ тэр гээд гурав, дөрвөн төрлийн өвчин их гарсан.

Үүнтэй холбогдуулаад бид 2022 оны төсөв дээр болоод 2023 оны төсөв дээр хангалттай төсөв, санхүүжилтүүдийг тавьж өгсөн.

Гаднаас авдаг эм, тариа, вакцины хангамж, хүртээмжүүд муу байна. 20-иос 30-хан хувьдаа хүрдэг гэдэг юм уу, цаг хугацаандаа орж ирдэггүй юм уу, малчдад хүндрэл учруулдаг. Эргээд нөгөө мал нь үхдэг, үрэгддэг, хорогддог, бухимдал үүсгэдэг асуудал гарч ирж байна.

Тэгэхээр энэ дээр бид нар жаахан хариуцлагатай баймаар байна. Цаг хугацаанд нь оруулж ирэх тал дээр, төлөвлөгөөт хугацаанд нь хийдэг байх тал дээр анхаарах зайлшгүй шаардлага байна. Асуудал нь хаанаа байна? Хил, гааль дээрээ байна уу? Эсвэл захиалга дээр байна уу? Цаанаасаа авахдаа удаашраад гараад байна уу? Хөрөнгө мөнгө, санхүүжилтийг нь шийдэхэд асуудал гараад байна уу? Нэг дэх асуудал нь.

Хоёр дахь нь, бид Биокомбинатаа уг нь бас нэг чадавхжуулах, эргээд нэг өргөтгөл хийгээд, хүчин чадлыг нь нэмэгдүүлээд, дотооддоо шаардлагатай байгаа төлөвлөгөөт эм, тариа, вакцинуудаа тогтмол нийлүүлдэг болох асуудлуудыг сүүлийн хэдэн жил яриад байгаа юм.

Тэгээд энэ маань бас нэг болохгүй л байгаад байх шиг байх юм. Ядаж нөгөө төлөвлөгөөт вакцинууд байдаг. Хамгийн гол асуудал. 4, 5 сар ногоо гарна. Дотрын хордлогын асуудлууд хамгийн их байна.

Тэгээд л дахиж дөнгөж онд орсон мал эргээд л ногоо амсаад л дотрын хордлогоор дахиад яваад өгдөг асуудлууд гарчхаад байгаа байхгүй юу.

Тэгтэл сумууд дээр, аймгууд дээр хүргэж байгаа дотрын хордлогын вакциных нь хангамж нь ерөөсөө л 30-аас 40 хувьтай байгаа юм.

Тэгэхээр бид ерөөсөө нийт хэрэгцээтэй байгаа эм, тариа, вакциныхаа хангамжийг ерөөсөө гүйцэхгүй байна, нийлүүлж чадахгүй байна. Энэ асуудал дээр ямар шийдэл, гаргалгаа байна вэ? Болж өгвөл дараагийн жил дахиад л энэ алдаа, хийдэл давтагдамааргүй байх юм.

Тэгэхээр хамтраад нэг гарц, шийдэл гаргамаар байна.

Одоо харьцангуй харин сая шүлхийний асуудал дээр сая 5 сард давтан вакцинууд хийгдсэн, 10 сард хийгдсэн. Одоо шүлхий бол би асуудалгүй болчихно гэж хараад байгаа юм. Богийн мялзан сая энэ хавар, өнгөрсөн намар хамгийн хүнд байсан.

Одоо тэгэхээр бид энэ эм, тариа, вакцины хангамжуудын асуудлуудад та хэд бас нэг анхаарч үзээч ээ. Яах вэ. Одоо үүнийг бид хийж байж л цаашдаа нөгөө хүнснийхээ аюулгүй байдлыг хангах, мал, амьтныхаа эрүүл мэндийг хамгаалах, ингээд цаашдаа нөгөө хүнснийхээ хангамж болоод аюулгүй байдлаа бүрдүүлэх асуудал дээр л ахиц, дэвшил гарах суурь асуудал болчихоод байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор би бас нэг асуудал тавих гээд байгаа нь ер нь энэ мал эмнэлгийн нэгжүүд болоод, мал үржлийнхээ нэгжүүдийг ер нь цаашдаа хэрхэн чадавхжуулах вэ? Яаж, хэрхэн эдийн засгийн харилцаанд оруулах вэ? Эдийн засагжуулах вэ? Яаж санхүүгийн

чадавхтай болгох вэ? Төлбөр, хөлс мөнгө нь хүрэлцээтэй байдаг болох вэ?

Яг үндсэндээ үржлийн ажил хийгээд ч ямар ч ашиггүй байгаад байдаг. Тэр үржлийн нэгж эдийн засгийн хувьд өөр өөрсдийгөө аваад явах эдийн засгийн бүрэн тогтолцоо бүрдэж чадахгүй болчихоод байгаа юм.

Мал эмнэлгийн нэгжүүд нь арай дээр. Тэгэхдээ л яг энэ салбарыг аваад явах эдийн засгийн бүрэн тогтолцоо, засаглалыг хийж чадахгүй болчихоод байгаа.

**Г.Занданшатар:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун. А.Нарантуяа хариулах уу? 84.

Аюушжавын Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

**А.Нарантуяа:** Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулья.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 3 гоц халдварт өвчний асуудал чухлаар тавигдаж байгаа.

Өнөөдөр шүлхий өвчнөөр Монгол Улс тайван байна. Арьс товруутах өвчнөөр тайван байна. Бог малын мялзан өвчин гол анхаарлын төвд байгаа.

Ерөнхий дархлаажуулалтын ажил 67.0 хувьтай явагдаж байна.

Арьс товруутах өвчнийг өнгөрсөн 3 сард Дорнод аймаг, Сүхбаатар аймгийн 2 сумын үхэр сүрэгт дархлаажуулалтын ажил явагдсан.

Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын сарын аян

Мал эмнэлгийн ерөнхий газар, яамны зүгээс бид энэ ажлыг зохион байгуулаад өнөөдрийн байдлаар мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналт буюу Улсын онцгой комиссын зарим төлөөлөлтэй 6 аймгийн нутагт өчигдөр гарсан байгаа.

Тэгээд ерөнхий мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд, оролцож байгаа хүчин чадлын хувьд бүх хүмүүс энэ ажилд онцгой анхааран ажиллаж байна.

Дотрын халдварт хордлогын вакцины асуудлын талаар ярилаа. Био үйлдвэр энэ жил 15.2 литр мянган тун вакцин үйлдвэрлэсэн. Энэ бол үйлдвэрийн хүчин чадлын 60.0 хувьд л хийж гүйцэтгэж байгаа. Үүнээс илүү үйлдвэрлэх гэхээр био үйлдвэрийн хүчин чадал бас хангалттай хэмжээнд байхгүй байгаа учраас өөрсдийнхөө боломжид үйлдвэрлэсэн вакциныг орон нутаг, аймаг нэгж, суманд хүргэгдсэн байгаа.

Нэгжүүдийн чадавхын асуудлыг ярьж байна. Мал эмнэлгийн нэгжүүдийн хувьд ялангуяа хүний нөөц, боловсон хүчний хувьд сая яам, Төрийн албаны зөвлөл хамтарч ажиллаж байгаад сум, тасагт ажиллаж байгаа боловсон хүчин, түүнд дутагдалтай байгаа 80 гаруй төрийн албан хаагчийн асуудлыг шийдвэрлэсэн.

Нэгжид ажиллаж байгаа эмч нарын тогтвортой байдлыг хангах, тэнд ажиллах хүчний талаар тийм дорвитой бодлого явуулах, дээр нь мал эмнэлгийн сургууль мал эмнэлгийн малын эмч нарыг бэлтгэж байгаа. Ялангуяа Дорнод аймаг, Ховд аймаг, хуучин Архангай аймагт байсан малын техникч бэлтгэх энэ тал дээр дорвитой бодлого явуулах хэрэгтэй юм байна гээд.

Ийм учраас бид сая олон улсын байгууллага төсөл, хөтөлбөртэй зарим үе шаттай сургалтуудыг явуулж байна.

**Г.Занданшатар:** Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууна.

**Г.Тэмүүлэн:** Энэ жил манай мал эмнэлгийн салбарын 100 жилийн ой болох гэж байгаа.

Тэгэхээр бид 100 жилийнхээ ойг тэмдэглэн өнгөрүүлэхээс гадна ер нь энэ салбартаа ер нь бодлогын шинэчлэлийг хийх нь зүйтэй байх гэж хараад байгаа.

Тэгэхээр сумдад ажиллаж байгаа хувийн мал эмнэлэг болоод үржлийн нэгж, гишүүдийнхээ энэ хөлс, төлбөр дээр нь тодорхой тарифын ч гэдэг юм уу шинэчлэлийг хийгээд. Эргээд тодорхой хэмжээнд өөрсдөө бие даасан байдлаар үйл ажиллагаагаа аваад явах санхүүгийн тогтолцоог нь хийж өгөх ёстой юм шиг харагдаад байгаа юм.

Тэгж байж анхан шатан дээрээ, суман дээрээ, баг дээрээ бид хувийн үржил болоод, мал эмнэлгийн нэгжүүдийг чадавхжуулж байж, эдийн засагжуулж байж суурь асуудлууд нь бас нэг арай нэг ахиц дэвшил гарах боломж бололцоо бүрдэх юм болов уу гэж хараад байгаа юм.

Хоёр дахь нь, Биокомбинат дээрээ бид энэ үйлдвэр, технологийн шинэчлэлийг хийхгүй бол, дахиж тодорхой шаардлагатай бол хөрөнгө санхүүжилтийг нь шийдэхгүй болбол үндсэндээ яг хэрэгцээт, төлөвлөгөөт вакциныхаа эм тариа, хангамжийнхаа хүртээмжийг бид гүйцэхээ болилоо.

Тэгэхээр энэ дээр та хэд маань бас нэг анхаарч ажиллаарай л гэдгийг хэлэх байна.

**Г.Занданшатар:** Санал хэлчихлээ дээ. Тийм ээ. Наянтайн Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Хуульдаа өөрчлөлт оруулах асуудлууд уг нь ч саяхан л Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хуулиудаа цуг байсныг нь салгаад. Саяхан хорио цээрийн асуудал нь мэргэжлийн хяналт дээр байна. Үүнийгээ авъя гээд нэгдсэн байдлаар улсын бодлого болгоод аваад ингээд л яваад л байна л даа. Тийм ээ.

Янз бүрийн л асуудлуудыг хийгээд л байна, хийгээд л байна. Байдал нь яг тийм огцом өөрчлөгдөхгүй байгаа байдлууд харагдаад байгаа.

Шалтгаан нь маш тодорхой байгаа. Малын түүхий эд, бараа, бүтээгдэхүүнийхээ үнийг бид үнэ цэнэтэй болгож чадахгүй. Малынхаа бүтээгдэхүүнийг борлуулж чадахгүй, олсон орлогоороо генетикийнхаа өөрчлөлт, үржлийнхээ сайжруулалтыг хийж чадахгүй байна. Олсон орлогоороо бид малаа эрүүл болгоход зарцуулж чадахгүй байгаа юм. Шалтгаан ердөө л энэ.

Мэдээж төрөөс тодорхой хэмжээний вакцин, тарилга, туулга хийж өгч байна. Тэгэхдээ нөгөөдөхийг нь тарьдаг хүмүүс, нөгөө мал эмнэлгийн хувийн нэгжүүд нь одоо залхалтын байдалд орчихсон. Тэр улсын төлөвлөгөөт вакциныг хийснийхээ төлөө бараг өөрсдөө өрөнд орох хэмжээнд хүртэл ингээд л явж байгаа.

Одоо үржлийн аж ахуйн нэгжүүд маань хангалттай орлого олох чадамжгүй байна. Мал аж ахуйн нэг л төрөл дээр энэ маш өндөр хэмжээнд хөгжсөн. Энэ нь адуу. Тэр нь тэгэхдээ хурдны адууны чиглэлээр энэ процессууд бүгдээрээ маш

өндөр түвшинд, дэлхийн түвшин рүү ойртож байгаа.

Тэнд борлуулсан адуунаасаа витамин тариаг хүнд хэрэглэдгээс илүү үнэтэй витамин тариануудыг хэрэглэж чадаж байгаа. Тэрийг тойрон ажиллаж байгаа эмч нар өнөөдөр малын эмч нар дотроо хамгийн өндөр орлоготой байгаа. Хамгийн эрэлттэй байгаа. Үнэтэй технологиудыг ашиглаж байгаа.

Бид бусад хонь, үхэр, ямаа бүгдээрээ л адилхан баймаар байна. Үүнийг л бид олж харах ёстой. Энэ бол мал аж ахуйг эдийн засагжуулах л асуудал байгаа юм.

Тэгэхээр тухайн бүтээгдэхүүн өөрөө үнэ цэнтэй байх юм бол үүнийг дагаад бүх үйлчилгээ, бүх ажлууд яваад эхэлчихнэ, зөв яваад эхэлчихнэ. Энэ бол бидний мал аж ахуйн салбарын, хөдөө аж ахуйн салбарын зорилго байх ёстой л гэж бодож байгаа.

Төрийн оролцоонууд нь сайн байгаа. Мал эмнэлэг, үржлийн тасаг байгууллаа. Сум болгонд нэгжийн ажилтнууд бий болголоо. Харамсалтай нь тэнд орон тоо олдохоо байсан. Эргээд төрийн албаны цалин бага байна. Дээрээс нь хөдөө, орон нутаг руу явдаг мэргэжилтнүүд олдохгүй боллоо. Эргээд цаана нь бидэнд гарч байгаа бэрхшээлүүд зөндөө байгаа. Үүнийгээ засах гээд л оруулаад ирсэн байна л даа.

Гаднаас орж ирж байгаа импортын мал дээр тавих хяналтаа жоохон багасгаж байгаа юм байна. Түүн дээрээ олон дамжлага баазуудыг нь байхгүй болгож байгаа юм байна. Экспортод гарч байгаа малын түүхий эд, бүтээгдэхүүн дээр хүнд суртлыг нь багасгаж байгаа юм байна гээд.

Гэхдээ эргээд гарч байгаа шалтгаан юу байна вэ? Хамгийн том шалтгаан юу вэ? Энэ бол чөлөөт эдийн засаг, хувийн хэвшил дээрээ тулгуурлаж явах ёстой. Энэ холбооснууд. Төр, хувийн хоёрын холбоосны алдаанууд юу байна вэ? Үүнийгээ та нар юу гэж бодож байна?

Өнөөдөр 3 хуульдаа гурвуулан дээр нь өөрчлөлт оруулаад ирсэн байна.

Одоо хяналтаа авсан чинь юу болохгүй байна? Дэндүү олон төрийн албатай нэг тийм том агентлагийн босоо тогтолцоонууд бий болгочхоод тэнд нэг бичиг цаас нэхдэг хэдэн хүнтэй болчихоод байгаа юм биш үү?

**Л.Мөнхбаатар:** Н.Ганибал гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсэг хариулах уу? Х.Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Ерөнхийдөө санал хэлчихлээ дээ. Н.Ганибал гишүүн.

Энэ мал, махны үнэ бага байна гэж ярьж байна. Бүх юм өөрийн чинь саяын хэлдгээр холбоостой байх ёстой. Яагаад экспортын мал, махны үнэ хямд байна вэ.

Манай улсын малыг эрүүл гэсэн баталгаа нь байхгүй байгаа. Олон улсын хэмжээнд. Экспортод гаргахад.

Нөгөө түрүүний хэлдэг эрүүл бүсийг байгуулаагүй, хамгаалагдсан аж ахуй байгуулаагүй. Энэ хууль нь л одоо орж байх жишээтэй.

Тийм болохоор экспортын махны үнэ бусад орныг бодвол хямд байгаа юм. Бүртгэл, хяналт хийгээгүй.

Энэ нь ямар учраас мал эрүүл биш байна гэхээр мал эмнэлгийн үйлчилгээ үнэхээр суларсан.

Тэгэхээр мал эмнэлэг хувьд шилжсэн. Төр үйлчилгээ үзүүлээч гэж үйлчилгээний хөлс мөнгийг хувийн малын эмч нартаа өгдөг. Энэ үнэлэмжээ хэтэрхий олон жил бага барьж ирсэн.

Би түрүүний хэлдэг. 200 төгрөгөөр өнгөрсөн жил хүртэл барьж ирлээ шүү дээ. Тэгээд 200 төгрөгөөр мянган үхэр тарина гээд бод доо. 200 мянгаар. Энэ чинь бензин тос, хөдөө явна, мал баригч хүнийг цалинжуулна.

Тийм ч учраас тарваганы нүхэнд тариагаа хийчихсэн байлаа гэсэн асуудал Өмнөговьд гарч байсан. Тэр ганц олдсон нь тэр болохоос биш. Яг ингэж аваад тарихгүй байсан асуудал маш их байсан. Энэ нь тэгээд малын өвчин та орон даяар тархах нөхцөл болсон.

Тэгэхээр цаашдаа бид малын эмч нарынхаа хөдөлмөрийг үнэлж, төр үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай. Мянга гаруй төгрөг болгох саналыг бид оруулж байгаа гэдгийг хэлэх байна.

Ингэж байж бүх холбоос нэгдмэл байж мал, мах нь үнэтэй байна. Мал нь өөрөө эрүүл байна. Малын эмч нарын ажлын байрны сэтгэл ханамж таатай байна. Бүх уялдаа холбоо ингэж бүрдэж байж мал аж ахуйн эдийн засгийн эргэлт сайжирна гэдгийг хэлэх байна. Тантай санал нэг байна.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу? Наянтан Ганибал гишүүн тодруулж асууя.

**Н.Ганибал:** Одоо тэгээд шалтгаанаа олж байгаа учраас тэрийгээ л

хэдүүлээ яаралтай бүгдээрээ нийлж байгаад л. Тийм ээ. Их Хуралтайгаа Засгийн газар бүгдээрээ нийлээд л хийх ёстой л доо.

Сэтгэл өвдөм нэг асуудал байгаа юм. Одоо малын тоо толгойн татвар гээд сумууд маань тодорхой хэмжээнд мөнгөтэй болсон. Татвараараа мөнгө аваад түүнийгээ мал аж ахуйн салбарт, нэн ялангуяа үржил рүү их зарцуулж байгаа.

Тэгээд ямар ч бодлогогүйгээр яваад байна. Сум болгон зарим нь нэг, хоёр бух авах юм. Зарим нь 20 бух авах юм. Зарим нь 200 бух авах юм. Нэг хуц авах юм.

Үүнийг та нар нэг цэгцлээч ээ. Энэ дээр мал аж ахуйн зоогийнхон маань. Тийм ээ. Энэ асуудал дээр бүр анхаарахгүй бол. Зураглалыг нь гаргаж өгөөд Монгол Улсын хэмжээнд бүс нутгийн тэр нэгдсэн бодлогуудыг нь гаргаж өгөхгүй бол сум болгон өөр өөрийнхөөрөө. Хангайн үржлийн малыг талд аваачаад нутагшуулах гээд л бөөн зардал болгож ирээд л үхүүлээд.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Одоо хоёр гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй.

Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**С.Ганбаатар:** Мал аж ахуйн чухал асуудал орж ирж байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хариуцах асуудлын 5 асуудал байгаа.

Хамгийн гол онцгой ажил нь хүнсний аюулгүй байдал. Аюулгүй байдал гэдэг бол стандартжуулна. Аюултай байдал байх юм бол торгоно л гэсэн хууль орж ирж байна.

Зөрчлийн тухай хууль дээр хэд хэдэн заалтууд байна. 5 дугаарт нь 1.3.4.

5 дугаарт нь энгийн зөвшөөрөлгүйгээр гадаадад мах гаргасан бол тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгоод нэр болон торгууль тавина гэсэн байна.

Мал үржүүлгийн бүтээгдэхүүнийг энгийн зөвшөөрөлгүйгээр гадаадад гаргахыг завдсан бол одоо бүр торгуулна. Айхтар нарийн л юм байна л даа. Би нэг тодруулж асуух зүйл байна.

Энэ олон зүйлүүд зөв байж болно. Та нар сургалтаа яаж хийж байгаа вэ? Мэдээллээ малчдад яаж өгч байгаа вэ? Мэдээлэл, сургалт байхгүйгээр үүнийг хэрэгжүүлэх юм бол хүнд суртал болно. Ахивал авлигалын үүд хаалга болж хувирна.

Энэ талаар та нар ямар үйл ажиллагаа, ямар төсөв, хөтөлбөртэй иргэдийг мэдээлжүүлж, үүнийг баталгаажуулж байгаа вэ?

10.3-т нэг ийм асуулт байна. Стандартын шаардлагад тэнцэхгүй хээлтүүлэгчийг, эсхүл малыг сайжруулагчаар ашигласан бол хүнийг 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг бол 5 мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан байна.

Миний асуулт. Одоо ард иргэд харж байгаа байх. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын Залаажинст гэдэг омгийн ухныг Баацагаан сумын малчин



авч ямаагаа хээлтүүлэхээр ашиглавал торгууль төлөх үү? Зөвшөөрөлгүйгээр.

Зөвшөөрлөө би тэгвэл хаанаас авах ёстой вэ? Торгуулахгүйн тулд хаанаас ямар нэг газраас зөвшөөрөл авах ёстой болно. Ямар процедураар яаж авах вэ? Хэд хоногийн дотор авах вэ? Хэнээс авах вэ? Надад үүнийг тодорхой, иргэдэд ойлгомжтой хэлж өгч тусална уу?

**Л.Мөнхбаатар:** Л.Ганбаатар гишүүний асуултад хариулья. Хэн хариулах вэ? Ажлын хэсэг үү? Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

**Э.Цолмонжаргал:** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал. С.Ганбаатар гишүүний асуултад хариулья.

Зөрчлийн тухай хууль дээр нэмсэн энгийн зөвшөөрөл гэдэг нь шинээр нэмж байгаа асуудал биш. Энэ нь өөрөө Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан тусгай зөвшөөрөлтэй этгээд нь дахиад гаргах бүртээ, мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүнийг гадаадад гаргах бүртээ энгийн зөвшөөрөл авах зохицуулалттай байсан.

Үүнийг нь энгийн зөвшөөрөлгүйгээр гадаадад гаргах тохиолдол байгаад байгаа учраас Зөрчлийн хуульд нэмж оруулж ирсэн байгаа.

Мөн стандартын шаардлагад тэнцэхгүй хээлтүүлэгчийг, эсхүл өөр үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашигласан бол торгоно гэсэн зохицуулалт.

Энэ зохицуулалт нь ялгаагүй Малын генетик нөөцийн тухай хууль дээрээ байсан зохицуулалт. Үүнийг

тухайн сумын хөдөө аж ахуйн тасгаасаа зөвшөөрөл авдаг.

**Л.Мөнхбаатар:** Та тодруулах юм уу? Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

**С.Ганбаатар:** Би яг энэ бизнесийг хийхгүй ч гэсэн ийм бизнес, бизнесийн ийм харилцаанд ордог олон зуун мянган малчдынхаа өмнөөс л би асууж байгаа юм шүү.

Тэгээд мэдэхгүй зүйл байж болно. Энэ энгийн зөвшөөрөл гэдэг зүйлийг яаж авах вэ, хэдэн бичиг баримт бүрдүүлдэг юм гэдгийг иргэдэд тодорхой ойлголт өгөөч.

Хоёрдугаарт, Баянхонгорын Шинэжинст сумаас Залаажинст омгийн ухныг Баацагаан сумын малчин өөрийнхөө мал дээр хээлтүүлчихсэн байхад зөвшөөрлөө би яаж авах юм? Хэдээр торгуулах юм гэдгийг тодруулж өгөөч ээ.

**Л.Мөнхбаатар:** Асуултад нь тодорхой хариулья. Ажлын хэсгийн 83 дугаар микрофон уу? Хэн хариулах юм? Тодорхой асуулт асуугаад байна шүү дээ. Энд нь тодорхой хариулаад өгчих. Ажлын хэсгийн 83 дугаар микрофон.

**Э.Цолмонжаргал:** Энгийн зөвшөөрөл нь мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүн гадаадад гаргахад тоо толгой тутмаар нь тооцож тэмдэгтийн хураамж төлөх зохицуулалттай байгаа.

Тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардана. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлсэн бичиг баримтыг нэмэлтээр шаардахгүй. 180 хоногийн хугацаатайгаар цахимаар олгож байгаа.

Энэ зөвшөөрөл нь ажлын 3 өдрийн дотор гарч байгаа.

Энгийн зөвшөөрлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам олгож байгаа.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсэгт жаахан тодорхой хариулаад өгчхөөч ээ. Их тодорхой л асуулт асуугаад байх шиг байх юм. Ажлын хэсгийн 86 дугаар микрофоныг өгье.

**С.Батхуяг:** С.Ганбаатар гишүүний асуултад хариулья.

Залаажинстийн цагаан ямааг Шинэжинст сумаас Баацагаан сумд авчрахаар бол мал эмнэлгийн гэрчилгээ гэдэг зүйлийг зөвхөн авдаг.

Шилжилт хөдөлгөөн хийхээр бол. Нэг сумын нутаг дэвсгэрээс нөгөө сумын нутаг дэвсгэрт мал, амьтан шилжүүлж байгаа бол иргэн хооронд мал эмнэлгийн гэрчилгээ авдаг.

Мал эмнэлгийн гэрчилгээг авахдаа тухайн орон нутагт буюу Шинэжинст суманд ажиллаж байгаа мал эмнэлгийн нэгжээсээ мал эмнэлгийн үзлэгт оруулаад өвчин, халдваргүй, ямар нэгэн асуудалгүй байна гэдгээ нотлоод энэ дээр цахимаар мал эмнэлгийн гэрчилгээг аваад төрийн мал эмнэлгийн нэгж буюу мал эмнэлгийн тасаг нь баталгаажуулснаар нөгөө суманд очих боломжтой болдог. Нэг сумаас нөгөө суманд очиход.

Хээлтүүлэгт ашиглахад тусгай зөвшөөрөл байхгүй. Саяын тусгай зөвшөөрлийн асуудал, лиценз, энгийн зөвшөөрлийн асуудал зөвхөн гадагшаа буюу гадаадын улс.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Дотоодынхонд хамаарахгүй гэсэн ийм агуулгатай хариулт өгч байна. Сая хариулсан хүн С.Батхуяг уу? Нэр, албан тушаалаа хэлж байгаарай.

Одоо О.Цогтгэрэл дарга асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд санал хураалт явагдах тул танхимд орж ирье. О.Цогтгэрэл дарга асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Мал аж ахуйн салбар мал, амьтны эрүүл мэндийн тухай асуудал яригдаж байна л даа.

Ер нь энэ асуудлыг ярихад бидэнд үнэхээр хуримтлагдсан асар том зүйлс их байна. Мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн аж ахуй, олж байгаа орлого, ирээдүйн баталгаа, энэ олон зүйлүүдийг ярихад үнэхээр асуудал түвэгтэй болчхож.

Энэ салбарт ажиллаж байгаа хүмүүс улсын дунджаас бүтээж байгаа баялаг, олж байгаа орлого энэ бүх зүйл бараг өмнө нь асар хэцүү явж ирсэн. Одоо улам уруудсан.

Мах нь олон улсын стандартад нийцээгүй, өвчтэй эрүүл нь мэдэгдэхгүй гэж үздэг. Сүү нь өвчтэй эрүүл нь мэдэгдэхгүй л гэж үздэг. Тэр салбарт ажиллаж байгаа малчид нь орлого байхгүй. Дахиад дээрээс нь байгаль орчин нь сүйдсэн, бэлчээр нь гандсан ийм нөхцөл байдалтай.

Тэгээд нөхцөл байдал дээрээ бид асуудал хүнд байна. Нөхцөл байдал дээрээ эхлээд оношоо зөв тавих ёстой.

Тэгэхээр Хөдөө аж ахуйн яамнаас ер нь энэ салбарын оролцогчид тал талдаа гарч байгаа энэ хүндрэл бэрхшээлийг, энэ мухардлыг. Энэ бол

үнэхээр зөвхөн нэг хүндрэл бэрхшээл биш. Нэг ийм мухардалд орчихоод байгаа шүү дээ.

Энд онош тавигдаад байгаа юм уу? Та нар яг энэ мухардлаас яаж цаашаагаа гарах гэж байгаа юм? Энэ дээрээ нэг тийм бодлогын өөрчлөлтөө хэлээч?

Нөгөө талаасаа энд мал, амьтны эрүүл мэнд гээд. Би бас оношийн тухай л ярих гэж байна л даа.

Энэ 70 сая малыг ер нь яг яаж эрүүл болгох. Үнэхээр энэ чинь ингээд боломжтой юм уу? Бүгдийг нь бид өнгөрсөн жилүүдэд вакцинжуулж байна. Вакцин нь хуурамч, вакцины мафи, вакцины луйвар гээд л ярих юм. Аль нь ч байлаа гэсэн энэ ер нь өөрөө боломжтой юм уу?

70 сая малыг вакцинжуулаад, эрүүлжүүлээд явна гээд яриад байгаа энэ зорилго, бодлого чинь өөрөө ер нь тийм боломжтой юм уу? Аль эсвэл бид нэг ийм боломжгүй, бэлчээрээр явдаг. Нөгөөдөх нь зэрлэг ан амьтантайгаа хамт бэлчиж байдаг. Тэр нь хил дамнаад нүүдэллэж байдаг. Энэ бүх зүйл чинь бидний тавьж байгаа зорилго болоод, энэ зорилгодоо хүрэх гэж байгаа, тавьж байгаа онош маань зөв юм уу?

Ер нь цаашдаа бид яг одоо энэ дээр ингээд л сайхан хууль батлаад л одоо ингээд тусгаарлаж байгаад гоё болгочих юм л гэнэ, яах юм л гэнэ. Нөхцөл байдал бид өөрсдийгөө л хуурсан. Энэ салбар нь өөрөө ядуурсан. Нөгөө анхан шатны бүтээгдэхүүн гардаг байсан ч бараг анхан шат нь ч байхгүй. Нөгөө арьс шир нь жалга руу явсан. Олон улсад баталгаажилтын тэр эрүүл сертификатын стандартын асуудал дээр ахиц дэвшил юу ч байхгүй.

Энэ үе салбар чинь өөрөө эдийн засгийн салбар биш. Монголын хөдөө аж ахуйн эдийн засаг гэдэг салбар биш нэг тийм иргэдийн амин зуулгын салбар болоод хувирчихсан.

Тэгэхээр энэ дээрээ гол нь яг ямар дүгнэлт хийж, энэ тавьж байгаа эрүүлжүүлнэ гэдэг зорилго, бодлого, чиглэл, онош маань ер нь хэр боломжтой юм бэ?

Би сүүлд нь эргэлзэж байгаа. Ер нь баахан том салбар, баахан яам байгаад. Тэгээд сүүлд нь явсаар явсаар байгаад вакцинжуулаад, энэ 70 сая малыг вакцинжуулж эндээс гарах юм уу?

Ер нь яг яах ёстой юм бол оо? Энэ мухардал дээрээ ер нь яг ямар үнэлэлт дүгнэлт өгч, гарц гаргалгаагаа ер нь юу гэж харж байгаа вэ? Тэрнээс л энэ асуудал эхлэх байх. Үүний цаана чинь төсөв төлөвлөгөө, хүн хүч, олон зүйл л явж байгаа. Татвар төлөгчдийн мөнгө л явж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Хариулъя.  
Х.Болорчулуун сайд хариулъя.

**Х.Болорчулуун:** Яам өмнө нь зөвхөн бодлого хэрэгжилтийн яам байсан.

Мэргэжлийн хяналт татан буугдаад бодлого, хэрэгжилт, хяналтыг цогцоор нь явуулах ийм үүрэг хариуцлага бүхий яам болсон.

Ингэснээрээ ажлын ахиц дэвшил гарах нь ойлгомжтой.

70 сая малыг эрүүлжүүлэх боломжтой юу гэж. Боломжгүй гэж бид орхиж хэрхэвч болохгүй л дээ.

Боломжтой байлгахын төлөө бид ажиллах ёстой.

Ер нь бид нөгөө харамч хүн хоёр төлнө гэгчээр мал эмнэлэг, үржлийн салбарт вакцин, тарилгаас авхуулаад эм, тариаг үнэхээр санхүүжилтийг хасчихсан байсан шүү дээ. Тавихгүй олон жил байсан. Хоёрын хооронд хэлбэр төдий санхүүжилт тавьж байсан.

Харин хүнсний хангамж 36 дугаар тогтоолоор ирэх 4 жилд 145.0 тэрбумыг малын тарилга, вакцин, мал эмнэлгийн үйлчилгээн дээр тавьсан. Зөвхөн энэ жил гэхэд 45 тэрбумыг тавьж байх жишээтэй. Энэ болгон үр дүнд хүрнэ.

Түүнээс биш бид боломжгүй гээд ажиллахгүй зогсоно гэвэл байдал ямар байх нь ойлгомжтой. Тийм байх ямар ч, одоо өөрийн чинь хэлдэгээр боломжгүй.

Ажиллах ёстой. Ний нуугүй хэлэхэд урсгалаараа явж ирсэн. Мал, махаа эрүүл болгох, экспортод гаргах бодлого тэгээд олон улсын жишгийн дагуу биш байсан. Урсгалаар явж ирсэн.

Үүнийг бусад улсуудтай адилхан эрүүл бүс байгуулах, хамгаалагдсан аж ахуй байгуулж одоо эхний ээлжинд тэр хамгаалагдсан аж ахуй, эрүүл бүсийнхээ малыг нэн түрүүнд, хамгийн түрүүнд эрүүлжүүлэх бодлогыг хүчтэй явуулж байж мал, махаа олон улсын жишгээр үнэтэй гаргана.

Түүнээс биш одоогийн экспортод гаргаж байгаа махны үнэ лангууны үнэдээ хүрэхгүй байна шүү дээ.

Тэгээд бүртгэл, хяналт бүрэн хийгдээгүй. Олон улсын шаардлага хамгийн наад зах нь бүртгэл, хяналт. Үхэр дээр хэлэхэд нөгөө ээмэгжүүлэлтээс эхэлдэг байхгүй юу. Ингэж байж мал,

махны экспорт бусад улсын жишгээр явах ёстой.

Энэ бол хоцрогдож, хаягдаж ирснийг бид хүлээн зөвшөөрөх ёстой.

Цаашдаа бүхий л боломжоороо бодлого болгон хэрэгжүүлж ажиллах болно гэдгийг хэлэх байна.

**Л.Мөнхбаатар:** Одонгийн Цогтгэрэл дарга тодруулж асууя.

**О.Цогтгэрэл:** Харин тийм ээ. Мал аж ахуйн салбарт зүгээр л ингээд бие биеийгээ хуурсаар л явж ирсэн. Нэг гоё гоё лоозон, урианууд тавьдаг. Бодит оношоо зөв оношилсон, үнэлэлт дүгнэлт хийсэн, үүнээсээ гарсан томоохон өөрчлөлтийн чиглэлтэй юу ч байхгүй.

Тэр тусмаа улс төрчид нь дандаа сонгогчид гэдэг үүднээс тэр салбарынханд, малчдад нөхцөл байдлыг өөрөөр гоёчилж хэлдэг, аргацааж өнгөрүүлдэг. Яг л энэ бодлого энэ чигээрээ л мал аж ахуйн салбарт үргэлжилж байна.

Энд шинэ техник, технологийн яриа, бүтээмжийн тухай яриа, гадна дотнын ноу-хаугийн тухай яриа шинээр яригдаж байгаа зүйл байхгүй.

Ерөөсөө л бүх зүйлийг нэг хонины ээлж өнгөрүүлээд л дараагийн нөхдүүд рүү гулсуулаад л оруулдаг. Яг л энэ нөхцөл байдал дээр.

70 сая малыг боломжтой, боломжгүйн тухай биш. Энэ хүн төрөлхтөн нь өөрөө хоолоо эрүүл хийж идээд.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулья.

Баянхонгор аймгийн 8 жилийн сургуулийн 1988 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдийн ажил, амьдралд сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.  
/алга ташив/

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Н.Ганибал гишүүнээр тасаллаа. Б.Бейсен гишүүн асуултаа асууя.

**Б.Бейсен:** Хуулийн төслийг дэмжиж байгаа.

Түрүүн асуулт асуусан. Сумын мал эмнэлгийн салбар улсын мэдэлд авахгүй бол анхан шат дээр. Түрүүн сайд ч ярьж байна. Мал эмнэлгийн тэр урьдчилан сэргийлэх тарилга, эмчилгээний асуудал туйлын хангалтгүй. Хувийн эмч нар чинь ажиллахгүй байгаа юм.

Нөгөө талаар нөгөөдүүл чинь цалин байхгүй юм чинь эмийг дамлаж зараад өндөр нэр дарж байгаа.

Нөгөө талаар сум мал эмнэлгийн салбартай болсноор хариуцлага нь дээшлэх юм байна. Энэ чинь албан ёсны цалинтай, хариуцсан улс. Одоо хувийн хэвшил чинь хариуцах хүн. Сум, багийн эмч нар чинь бүгд малчид шүү дээ. Малчид зүгээр эмч гэдэг нэртэй болохоос малчид болчихсон байж байгаа.

Энэ дээр анхаараад, цаашдаа ер нь малын эрүүл ахуйг хамгаалах, нөгөө талаар эрүүл мах экспортлох, дайвар бүтээгдэхүүн дотоод болон гадаадаа

хэрэглэх, боловсруулах юман дээр мал эрүүл байж байж энэ асуудлууд хийгдэнэ.

Энэ дээр анхаараад ер нь мал эмнэлгийг улсын мэдэлд авах тал дээр анхаарахгүй бол хуучин сумууд дээр мал эмнэлгийн салбар байртай байсан шүү дээ.

Одоо хувьчилж авсан улсууд чинь тэгээд өөр юманд зарцуулчихсан. Хувьчлал нь буруу явагдсан.

Тийм учраас энэ тал дээр анхаараад цаашдаа төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж Засгийн газар танилцуулаад үүнийг шийдүүлэх тал дээр анхаараач ээ гэдэг санал хэлье.

**Л.Мөнхбаатар:** Б.Бейсен гишүүн үг хэллээ. Одоо Наянтайн Ганибал гишүүн үг хэлье.

**Н.Ганибал:** Хуулийн өөрчлөлтүүдийг дэмжиж байна.

Гэхдээ одоо бид ер нь том зургаар нь харж Монгол Улс мал аж ахуйн салбараас малын түүхий эд, бараа, бүтээгдэхүүнээс олох орлогоо хангалттай нэмэх боломж болж байгаа.

Олж байгаа орлого хэдий хэмжээгээр нэмэгдэх хэмжээний зарлагыг бид гаргах ёстой. Өнөөдрийн байгаадаа бид сэтгэл ханаж болохгүй.

Нэн ялангуяа малаа эрүүлжүүлэх, үржлийг нь сайжруулах, нэгжээс гарах ашиг шимийг нэмэгдүүлэх тал дээр бид ажиллах нь зүйн хэрэг.

Өнөөдрийн энэ хууль дээр харж байхад байгаа асуудлаа нэг сайжруулъя л гэсэн санал яваад байна л даа.

Ер нь мах экспортод гарахгүй байна гэж ярьж болохгүй л дээ. Гарах боломж байгаа. Гарч байгаа. Дулааны аргаар боловсруулаад гаргаж болж байгаа. Энэ нь өнөөдөр дэлхий нийтэд бүгд нээлттэй л байна.

Нэн ялангуяа урд хөрш Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу бид махаа экспортод гаргах боломжийг бүгдийг нь нээж өгсөн. Адууны мах түүхийгээрээ гарч байгаа.

Үүнийгээ хэдүүлээ сайжруулах ёстой. Үүнийгээ маш сайн болгох ёстой.

Үүнийг бид сайжруулахын тулд өнөөдөр Монгол Улсын нийт нутаг дэвсгэр дээр хуучин арван жилийн өмнө нядалгааны цех гэдэг асуудал бараг байдаггүй байсан.

Одоо бараг аймаг болгон махны үйлдвэртэй боллоо. Сум болгон нядалгааны цехтэй боллоо. Асуудал явж байгаа байхгүй юу.

Үүнийгээ бид дараагийн түвшинд яаж гаргах вэ гэдэг дээрээ илүү түлхүү ажиллах хэрэгтэй. Илүү түлхүү ажиллах хэрэгтэй.

Тэр дулааны аргаар боловсруулсан мах яагаад Хятадын зах зээл дээр нэг болохоороо үнэ цэнтэй зарагдаад, зарим үед нь зарагдахгүй байгаа.

Яг эцсийн бүтээгдэхүүн хэн хэрэглээд байгаа юм. Энэ том зураглалаа гаргаж ир ээ.

Тэгэхгүй тэр дээр ямар нэгэн байдлаар юу гэдэг юм дулааны аргаар гаргаж байгаа нь зөв, буруу гэдэг асуудлыг бид ярих нь буруу л даа.

Одоо энэ үйлдвэрүүд технологиудаа маш сайн сайжруулсан байна. Маш сайн сайжруулсан байна. Хятадын тэр хорио цээрийн алба хүрч ирээд хянан магадлагаа хийх юм бол олон үйлдвэрүүд энэ зөвшөөрлийг авах боломж нээгдсэн байгаа.

Харамсалтай нь энэ ажил маш дутуу дулимаг хийгдээд өнөөдөр хүрсэн.

Хуучин Мэргэжлийн хяналт руугаа буруугаа чихээд, тэд ажил хийдэггүй байна гэдэг байсан. Одоо бол Хүнс, хөдөө аж ахуйн яам энэ асуудлыг бүрэн өөрөө шийддэг болж байна.

Тэгээд энэ гарц гаргалгаануудаа бүгдийг нь энэ хуульд оруулж өгч байна л даа. Энэ нь сайн.

Эргээд бидэнд байгаа боломжийг сайн ашиглаад байх юм бол дараагийн боломж нээгдэх байхгүй юу. Дараагийн боломж гэдэг маань өнөөдөр малчид орлого нь нэмэгдээд ирэх юм бол илүү анхаарал тавьдаг болно.

Малынхаа эрүүл мэндийн асуудал дээр илүү анхаарал тавина. Магадгүй бүр цаашлаад төр зохион байгуулаад өгөх юм бол вакциныг худалдаж аваад өөрсдөө хийх ийм боломж руу хүртэл орчихно.

Гол нь өнгөрсөн цаг хугацаанд хийгдсэн бидний Монголын төрийн хамгийн том алдаа бол махныхаа экспортыг явж байхад нь зогсоодог. Хавар болонгуут махны экспортуудаа зогсоочихно, техникийн зохицуулалтаар арьс ширээ зарах бүх боломжийг хаасан.

Энэ нь өөрөө бид тэр том зах зээлд ороод өөрийн гэсэн байр сууриа олох тэр бүх боломжуудыг хаасан. Бид махаа экспортолж байгаад больчхонгуут Монгол хэзээ хилээ нээхийг нь хүлээгээд

тэнд хүмүүс өлсөөд суухгүй шүү дээ. Өөр улс орноос, өөр боломжит бүх л дэлхий тэнд Хятад Улсад бүтээгдэхүүнээ зарах гээд очерлож байгаа. Дараагийнх нь очерын хүмүүс хүрч ирээд л нийлүүлчихнэ.

Тэгэхээр бидэнд байгаа боломжуудаа хэзээ ч хааж болохгүй. Хаана гэдэг тэр ойлголтоор бид хамгийн буруу үйл ажиллагаанууд манай өнөөдрийн мал аж ахуйн салбарын доройтлын хамгийн том шалтгаан тэнд байгаа юм.

Тэгэхээр ер нь аливаа асуудалд өнөөдрийн энэ зах зээлийн нийгэмд бүтээгдэхүүнээ хүмүүс хэрэглэдэг болтол ямар ч үнэ цэнээр тэр боломжоо хаахгүй л байх ёстой. Ингэж чадах юм бол бид дараагийнхаа боломж руу орно.

Ноолуур дээр та бүхэн үндэсний үйлдвэрлэлүүдээ дэмжинэ, хөгжүүлнэ гээд бас техникийн зохицуулалт хийх гээд тодорхой хэмжээний хаалт хийх гэж оролдсон. Энэ буруу. Үүнийг хэдүүлээ байнгын нээлттэй байлгах ёстой юм.

Харин Монголын тэр үндэсний үйлдвэрүүдээ Хятадын зах зээлээр дамжуулахгүйгээр шууд тэр Европ руу нь гаргаж зардаг тэр хаалгыг нь нээж өгсөн нь зөв. Тэрийгээ л та нар сайн хий. Ингэж явах юм бол манай салбар, танай салбар.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Одоо Үйлдвэржилтийн байнгын хороон дарга Төмөртоогогийн Энхтүвшин үг хэлнэ. Үүний дараа санал хураалт явагдана.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж байгаа.

Үнэхээр энэ чухал хууль, чухал нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж байна гэж харж байгаа. Тэгээд бид олон жил ярилаа даа. Малаа эрүүл болгоё гээд. Ерөөсөө малыг эрүүл болгох хамгийн чухал салбар бол мал эмнэлгийн салбар байгаа юм.

Тэгэхээр сумдад ажиллаж байгаа бид хувийн мал эмнэлгийн байгууллагуудаа дэмжих хэрэгтэй байна. Мөн сумын Засаг даргын Тамгын газар ажиллаж байгаа мал үржлийнхээ тасгийг бид тодорхой хэмжээгээр дэмжиж ажиллах хэрэгтэй байна.

Үнэхээр тэдэнд өгч байгаа хөлс мөнгө нь хангалтгүй байгаа учир цаашид ажиллах бололцоо боломж байхгүй байна шүү дээ. Үндсэндээ тэнд ажиллаж байгаа сумын Мал эмнэлгийн тасаг, хувийн мал эмнэлэг бол одоо юу гэдэг юм, тэр өвчин гарсан голомттой бүсэд хүртэл хүрч ажиллах бололцоо боломж муу байна шүү дээ. Хөрөнгө мөнгө, хөлс нь муу байдаг учир.

Тийм учраас бид энэ вакцины хөлсийг нэмэгдүүлэх, ялангуяа тэр томилолтын зардлыг нэмэгдүүлэх, урсгал болон тэр юу гэдэг юм бусад зардлыг нь нэмэгдүүлж өгч байж цаашдаа бид энэ мал эмнэлгийн үйлчилгээг хэвийн түвшинд явуулж болох байх гэж харж байна.

Энэ хуульд орсон бас нэг таатай зүйл юу гэдэг юм, гаалийн байгууллагаас өгдөг экспорт, импортын зөвшөөрлийг, мал эмнэлгийн байгууллагаас өгдөг зөвшөөрлийг нэг болгоод нэг доороос өгч давхардлыг арилгаж байгаа нь нэлээн их ач холбогдолтой ийм хуулийн төсөл болжээ гэж харж байна.

Цаашдаа бид ч гэсэн өөрсдөө их анхаарах хэрэгтэй байна. Дулааны аргаар

боловсруулсан мах гээд. Үнэхээр юу гэдэг юм Монгол Улс өөрөө малын гоц халдварт өвчин их гардаг учир гаднын энэ хөрш зэргэлдээ улсууд маань л дулааны аргаар боловсруулж явж байна шүү дээ. Мал маань өөрөө эрүүл болчих юм бол бид мах боловсруулах үйлдвэрээр дамжуулаад нядалсан махаа бүрэн гаргах бололцоо боломж байгаа юм.

Тийм учраас аль болохоор бид вакциныг цаашдаа хийхгүй байх энэ тал руугаа л нэлээн сайн ажиллах нь зүйтэй.

Тийм учраас энэ мал эмнэлгийн байгууллагуудаа төрөөс дэмжиж байж цаашдаа бид эрүүл малтай болгох энэ асуудал яригдана.

Мал маань өөрөө Үндсэн хууль дээр заачихсан байгаа шүү дээ. Мал өөрөө төрийн хамгаалалтад байна гээд. Тэгээд энэ төрийн хамгаалалтад байгаа малыг эрүүл болгох хүмүүс нь ерөөсөө л энэ мал эмнэлгийн байгууллагууд юм.

Тийм учраас энэ дээр төрөөс тодорхой бодлогоор дэмжих ёстой л гэсэн ийм байр суурьтай байна. Миний хувьд дэмжиж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явагдана. Гишүүд танхимд байраа эзэлье.

Г.Тэмүүлэн дарга, Ц.Сандаг-Очир гишүүн суудлаа эзэлье. Саналын томьёоллыг уншиж байя. Гишүүд байраа эзэлье.

Байнгын хорооны саналаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хурааа.

П.Анужин дарга суу. Санал хураалт явагдана. Гишүүд байраа эзлээрэй. Санал хураалтын явуулъя. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

Нямаагийн Энхболд гишүүн горимын санал гаргая.

**Н.Энхболд:** Сая би уг нь дэмжээд өгсөн юм. Дарга аа. Энэ ажилласангүй. Та дахиад санал хураалгаад, хүчингүй болгож байгаад нэг санал хураалгаадхаач.

**Л.Мөнхбаатар:** Нямаагийн Энхболд гишүүний саналаар санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

55.3 хувиар санал дэмжигдлээ.

Одоо үндсэн санал хураалтаа явуулъя. Саналыг хүчингүйд тооцсон. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан байгаа. Санал хураалт гишүүд ээ. /алх цохив/

55.3 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны



хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийнхаа асуудалд оръё.

---

**Дөрөв.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

*/Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүн 2023.06.09-ний өдөр өргөн мэдүүлсэн/*

---

Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах асуудлаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Ж.Чинбүрэн:** Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 28 гишүүнээс 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын даргаас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33 дахь хэсэгт заасан Хянан шалгах түр хороо байгуулах шаардлага, үндэслэлийг тодорхой зааж, төслийг холбогдох заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.3 дахь хэсэгт заасны

дагуу асуудлыг дахин хэлэлцүүлэхээр Байнгын хороонд буцаасан билээ.

Төсөл санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн үндэслэлийг хуульд нийцүүлэн тусгасныг албан бичгээр Байнгын хороонд ирүүлсэн.

Байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үндэслэлийг тусгасан саналыг хэлэлцэн дэмжиж төсөлд саналыг тусган Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

**Г.Занданшатар:** Ж.Чинбүрэн гишүүнд баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооны саналаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт. Гишүүд ээ. /алх цохив/

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Б.Бейсен гишүүн дэмжиж санал өгсөн. Протоколд тэмдэглэе.

Одоо даргын дэргэдэх зөвлөл хуралдана. Даргын зөвлөлийн гишүүд хуралдаа ороорой.

14.00 цагт чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилнэ. Чуулган түр завсарлалаа.

## ЗАВСАРЛАГА

### Тав.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

*/Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/*

**Л.Мөнхбаатар:** Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжлэн явна.

Дараагийнхаа хэлэлцэх асуудалд орёе.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны

Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Басангийн Батжаргал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль эрх зүйн хэлтсийн дарга Дугаржавын Ренчиндорж, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга Зоригтын Батболд, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын ахлах зөвлөх Алтанбулагийн Нинжин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Өлзийбаярын Бодьгэрэл нар оролцож байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор үргэлжлүүлэн санал хураана.

Горимын санал байгаа юм уу? Байнгын хороон дарга П.Анужин горимын санал гаргая.

**П.Анужин:** Баярлалаа. Хувийн нэмэлт тэтгэвэртэй холбоотойгоор өчигдөр анхны хэлэлцүүлгийн үед гишүүдээс саналууд гарсан.

Ер нь эдгээр саналуудыг үндэслээд хууль санаачлагчтай нь бид ярилцсан.

Ингээд бид нарийвчлан ярилцах шаардлагатай байгаа учраас Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг Байнгын хороо руу нь анхны хэлэлцүүлэгт шилжүүлж өгөөч ээ гэсэн горимын санал байна.

Мэдээж анхдагч хууль учраас хуулийн хүлээлт нийгэмд маш их байгаа.

Тэгэхээр энэ хуулийг илүү нягталж үзэж, тал талаас нь ярилцах шаардлага байна гэж үзэж байна. Баярлалаа. Горимын санал гаргаж байна.

**Л.Мөнхбаатар:** Тийм. Горимын саналаар санал хураалгана.

Одоо Ням-Осорын Учрал гишүүн санал гаргая.

**Н.Учрал:** 2020 оны 10 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар миний болон Их Хурлын 4 гишүүн хамтарч санаачилсан Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийн хэлэлцэх эсэхийг дэмжсэн юм.

Тухайн үед Их Хурал хэлэлцэх эсэхийг дэмжигдсэний дараа ажлын хэсэг байгуулагдсан.

Ингээд хуулийн анхны хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг ажиллаад хэлэлцүүлэх гээд нэлээдгүй олон саналаа Их Хуралд өгсөн.

Гэсэн хэдий ч Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ Хувийн нэмэлт тэтгэврийн хуультай хамтатгаад хэлэлцээд баталъя гэдэг саналуудыг гаргасан учраас хууль санаачлагчийн хувиар хуулийг орж ирэхээр нэгтгээд хэлэлцье гэдэг саналтайгаар хүлээж байсан.

Тэгэхээр өнөөдөр чинь юу гэсэн үг вэ. 2023 он гэхээр бараг 2 жил, 7, 8 сар, 3 дахь жил рүүгээ орж байна.

Ер нь Их Хурал дээр хууль ингээд царцчихдаг талтай.

Гэтэл түүний цаана нийгмийн харилцаа өрнөөд байдаг.

Жишээ нь, 2007 онд анх Монгол Улсад энэ хувийн тэтгэврийн сангууд хуульгүй учраас төрийн бус байгууллагын нэрээр, банк бус санхүүгийн байгууллагын нэрээр аж ахуйн нэгж, хуулийн этгээд нь өөрөө хязгаарлагдмал хариуцлагатай компанийн статустайгаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Ингээд яг сүүлийн авсан судалгаагаар жишээ нь “National Life” <https://nlic.mn/> дээр даатгалын компанийн нэрээр авсан.

Тэгэхдээ тэтгэврийн хуримтлал үүсгэж байгаа. Үүн дээр 2 мянга орчим хүн хамрагдчихсан байгаа юм билээ.

Нийт тэтгэврийн хэмжээ нь 2 тэрбумд хүрчихсэн.

Голомтын “Тэтгэврийн Ууган сан” <https://www.tus.mn/> дээр 1500 орчим хүн байгаа. 3 тэрбум орчим төгрөгийн тэтгэврийн хуримтлал үүссэн.

Өнгөрсөн хугацаанд бүр эхнээсээ 30 хувь нь тэтгэвэрт гарчихсан.

“Ард даатгал” <https://arddaatgal.mn/> дээр 160 мянган харилцагч, 32 тэрбум төгрөгийн тэтгэврийн хуримтлал үүсгэчихсэн.

Энэ нь ерөөсөө ямар асуудал юм бэ гэхээр 3 жилийн хугацаанд энэ тоо нэмэгдээд л байгаа.

Үүний цаана иргэдийн эрх ашиг гэдэг юм орхигдоод байгаа байхгүй юу.

Хэрвээ энэ тэтгэврийн сангууд хууль гарахгүйгээр энэ төрийн бус байгууллагын статустайгаар яваад байх юм бол цаашдаа бид энэ тэтгэврийн сангууд ямар нэгэн дампуурлын ирмэгт хүрвэл, эрсдэлд учрах юм бол хэн энэ иргэдийн эрх ашиг, хуримтлалыг хариуцах вэ гэдэг ийм л асуудлыг л яриад.

Тийм учраас үүнийг хуультай болгоод иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах нь нэн тэргүүний зорилт юм гэж үзсэн.

Хоёрт, “pillar” буюу энэ “тэтгэврийн тулгуур” гэж байгаа юм.

**Манай тэтгэврийн тогтолцоо бол нэг тулгуур баганатай.**

Хоёр тулгуур баганатай буюу хоёр “pillar”-тэй болох юм бол нэг тулгуур нь унахад нөгөө тулгуур дээрээ тогтох.

Нэг ёсондоо эдийн засаг чинь өөрөө **банк**, дээр нь нэмэх нь **хөрөнгийн зах зээл** байх ёстой шүү дээ.

Гэтэл Хувийн нэмэлт тэтгэврийн хууль бүхэлдээ **хөрөнгийн зах зээлийг**

дэмжээд, **санхүүгийн зах зээлийг** дэмжих ийм зорилготой хууль юм.

Тийм учраас бид нэг хоног, нэг цаг мөч өнгөрөх тусам энд иргэдийн эрх ашиг яригдаад байгаа юм.

Тэгэхээр иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж, үүнийг хуультай болгох нь зайлшгүй.

Дээрээс нь тэтгэврийн тогтолцоо өөрөө тэтгэвэр нь өвлөгддөг, шимтгэл төлсөн бол түүнийхээ дагуу ядаж хадгаламжийн хүүгээс илүү өндөр тэр хуримтлал нь өсдөг, үрждэг.

Ингээд тэтгэвэрт гарахдаа тэр шимтгэлд суурилсныхаа үр шимийг хүртдэг тогтолцоо руу шилжүүлэхийн тулд л энэ хуулийг санаачилсан.

Ингээд Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуультай хамтатгаад хэлэлцээд явъя гэсэн боловч мэдээж Их Хурлын гишүүдийн зүгээс бас зарчмын зөрүүтэй хэд хэдэн санал яригдаад байгаа учраас ажлын хэсэг буцаая гэж үзэж байгаа юм байна.

Тэгээд яах вэ, би ажлын хэсгийг дэмжиж байгаа.

Гэхдээ ажлын хэсэгт нэг зүйлийг хэлэхэд энэ өөрөө тийм царцааж болохгүй хууль юм.

Тэгээд царцааж болохгүй хууль учраас яг бидний 5 гишүүний санаачилсан хуулийг нэгтгэж хэлэлцэнэ гэх юм бол үүнийг Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороогоор хамтатгаж хэлэлцээд ажлын хэсгийн ажлыг хурдлуулах хэрэгтэй байгаа юм.

Энэ бол бүхэлдээ эдийн засгийн ойлголт. Энэ бол бүхэлдээ өөрөө энэ “санхүүгийн салбарыг дэмжих”, “хөрөнгийн зах зээлийг дэмжих” ийм томоохон тэтгэврийн **реформ шүү** гэдгийг хэлмээр байгаа юм.

Бид Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт олон тулгууртай болгоно гэж зорилт дэвшүүлсэн.

Бид нэг зүйлийг ялгах ёстой. **Олон давхаргат тогтолцоо** гэдэг бол **эрүүл мэндийн даатгалын тогтолцоо**.

Энэ давхарга гэдэг бол “layer”.

“Pillar” бол энэ тэтгэврийн тулгуур багана.

Тэгэхээр бид цаашдаа тэтгэврийг 2 тулгууртай. Цаашлаад бүр **5 тулгууртай байгаа шүү дээ. Зарим улс.**

Тэр тулгуурыг нь олон болгож байж л цаашаа иргэдийнхээ шимтгэлд суурилсан үр шимийг нь иргэддээ хүртээдэг ажлуудыг хийх ёстой.

Нийгмийн даатгалын багц хууль маш том ахиц урагшилтыг авч ирж байгаад би талархалтай байгаа.

Гэхдээ Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг гаргахгүйгээр тэтгэврийн реформ бүхэлдээ хийгдэхгүй учраас ажлын хэсгийг анхааралтай ажиглаж, удахгүйгээр хурдан хугацаанд ажилдаа ормоор байна.

Тэгээд үүн дээр би манлайлж оролцоод анхны хэлэлцүүлгийг хурдлуулахад анхааръя.

**Л.Мөнхбаатар:** П.Анужин Байнгын хорооны дарга санал гаргаж байгаа юм байна.

Анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай байна гэж үзсэн байна.

Би дэгийн хууль бас танилцуулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41.8 дээр нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн бол хуулийн төслийг Байнгын хороонд буцаана гэсэн ийм заалт байгаа.

Ийм болохоор Байнгын хорооны дарга П.Анужингийн гаргасан горимын саналаар санал хураалт явагдана.

Санал хураалт явуулъя. Гишүүд суудалдаа суугаарай.

П.Анужин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Уг санал 57.5 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Ингэхдээ Нийгмийн бодлогын байнгын хороо Н.Учрал гишүүний хэлсэн тодорхой саналууд буюу тодорхой хэлэлцүүлгүүдийг богино хугацаанд шуурхай хийгээд эргэж оруулж ирнэ шүү гэдгийг энд дурдаж хэлье. Буцаалаа. /алх цохив/

Дараагийнхаа асуудалд орёе.

---

**Зургаа.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн  
Дээд боловсролын тухай хуулийн төсөл болон Судалгааны их сургуулийн  
эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүд**  
*/Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

---

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төсөл болон Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Ч.Ундрам:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу зүйл бүрээр хэлэлцэн дараах санал дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Нэг.Дээд боловсролын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрдмийн зөвлөл, хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүн, чиг үүргийг тодорхойлов.

Хоёр.Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл, дотоод чанарын баталгаажуулалт гэсэн хэлбэртэй байхаар тусгав.

Гурав.Орон нутаг дахь төрийн өмчийн их, дээд сургуульд ажиллаж байгаа багш ажилтанд орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах боломжийг нээж өгсөн.

Дөрөв.Боловсролын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэрийг олон талт үр ашигтай болгох, улс орны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд нөлөө үзүүлсэн судалгааны зардлыг төрөөс санхүүжүүлэх тогтолцоог бий болгох.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн анагаахын сургуулийн суралцаж төгсөх хугацаа нь бусад мэргэжлээс илүү байдаг тул үүнийг хэрхэн зохицуулсан талаар асуулт асууж, санал хэлсэн болно.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх тус Байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Ч.Ундрам гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Боловсрол шинжлэх ухааны дэд сайд Ганболдын Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Төмөр-Очирын Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Жадамбын Мягмар, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга Хөжөөгийн Тамир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын

дарга Огнонгийн Хуягцогт, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Арьяагийн Цолмон, тус яамны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Чимэдрэгзэнгийн Баярмаа, тус яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын шинжээч Жамцын Нарантуяа, тус яамны Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн дарга Авирмэдийн Халиунаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Дарьсүхбаатарын Билгүүдэй, Боловсрол судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч Ухнаагийн Туяа, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор Шажинбатын Ариунаа, Монгол Улсын Боловсролын их сургуулийн багш Эрдэнийн Чойсүрэн, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Замбалын Цогтгэрэл, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Наранцэцэгийн Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн Алтангэрэлийн Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Дондогдуламын Тунгалаг нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. С.Чинзориг гишүүнээр тасаллаа.

Ням-Осорын Учрал гишүүн асуултаа асууя.

**Н.Учрал:** Боловсролын ерөнхий хууль болон дээд боловсролын хуулиудыг ажлын хэсэг ажиллаж

нэлээдгүй удаан хэлэлцэж баталж байх шиг байна.

Би зарчмын хувьд дэмжиж байгаа.

Их Хурлын чуулганы дэгийн хуулийн 14.10 дээр гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй тул энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй байх гэсэн хуулийн зохицуулалттай.

Тэгээд 1994 оноос хойш миний аав дээд боловсролын салбарт хувийн сургууль байгуулж, өнөөдрийг хүртэл үр бүтээлтэй ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ сургуулийг төгссөн 30 гаруй мянган төгсөгчид байна. Дээрээс нь 2010 онд би Роял олон улсын их сургуулийг байгуулсан. Их Британийн магадлан итгэмжлэх зөвлөлийн Удирдах зөвлөлд ажилладаг.

Тийм учраас Дээд боловсролын хууль дээр би ашиг сонирхлын зөрчилтэй байгаа тул энэ тухай Их Хурлын дэд дарга танд мэдэгдэж, санал хураалтад оролцохгүй гэдгээ илэрхийлье.

**Л.Мөнхбаатар:** Ням-Осорын Учрал гишүүн хуулиа дагаж Улсын Их Хурлын чуулганд үг хэллээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14.10-д гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй

гэсэн заалтын дагуу Ням-Осорын Учрал гишүүн үг хэллээ.

Одоо С.Чинзориг. Сая даргын зөвлөл хуралдаад Эрүүл мэндийн сайд С.Чинзоригийн саналын дагуу Дархлаажуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Төсвийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг ирэх долоо хоногт хэлэлцэхээр болсон гэдгийг зориуд хэлье.

Содномын Чинзориг сайд асуултаа асууя.

**С.Чинзориг:** Би сонирхлын зөрчилгүй юм хэлнэ. Нэг асуудал байгаа юм. Би ч өөрөө ажлын хэсгийн гишүүн л дээ.

Тэгээд бас жоохон өөрөө өөртэйгөө эргэлзээд л, зөрчилдөөд л яваад байгаа юм.

Их, дээд сургуулиуд чинь ер нь санхүүжилтийнхээ, хувийн сургуулиуд бол 100 хувь, төрийн мэдлийн дээд сургуулиуд үндсэндээ төсвийнхөө 95 орчим хувийг оюутны сургалтын төлбөрөөр санхүүжүүлдэг тогтолцоотой болоод бид олон жил боллоо доо.

Тэгэхээр цаашдаа бид хувийн сургуулиуд байг гэхэд ядаж энэ төрийн мэдлийн их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийг тогтмол түвшинд байлгах. Энэ чинь нэмэгдээд байхад чинь иргэдийн амьжиргааны түвшинд асар их дарамт учруулж байгаа асуудал шүү дээ.

Хоёрдугаарт, цаашдаа ер нь төрийн мэдлийн сургуулиуд маань ядаж хөрөнгө санхүүжилт олдог байх тэр нөхцөл нөхцөл боломж нь яаж нэмэгдэж байгаа юм?



Төрийн мэдлийн сургуулиуд зөвхөн төсвөө сургалтын төлбөрөөр бүрдүүлдэггүй байх нөхцөл боломж нь яаж бүрдэх юм?

Тэгэхгүй бол төрийн мэдлийн дээд сургуулиуд зөвхөн оюутны сургалтын төлбөрөөрөө л төсвөө бүрдүүлдэг энэ тогтолцоо цаашдаа үргэлжлэх юм бол энэ нь иргэдийн амьжиргааны түвшин маш дарамт болж байгаа. Ялангуяа хөдөөгийн иргэдийн, ялангуяа малчдын хүүхдийн сургалтын төлбөрийг төлнө гэдэг маш амаргүй хүнд ачаалал болж байгаа шүү дээ. Жилээс жилд л сургалтын төлбөр нэмэгдээд л байдаг.

Тэгэхээр энэ дээр манай яам, ажлын хэсэг ямар зохицуулалт, гол бодлогын өөрчлөлт орох юм бэ?

Цаашдаа ялангуяа их, дээд сургууль, ялангуяа төрийн мэдлийн их, дээд сургуулиуд төсвөө зөвхөн сургалтын төлбөрөөр бүрдүүлдэггүй байх нөхцөл боломж нь яаж нэмэгдэж байгаа юм? Ингэснээр яаж сургалтын төлбөр нэмэгдэхгүй байх, тогтмол түвшинд хадгалагдах, иргэдийн амьжиргааны түвшинд сөргөөр нөлөөлдөггүй байх чиглэлээр ямар дорвитой өөрчлөлт орж байгаа юм бэ гэдгийг л тодруулмаар байна.

Би өөрөө энэ ажлын хэсэгт байгаа. Бас мэдэж байна. Гэхдээ жаахан өөрөө өөртэйгөө зөрчилдөөд л яваад байгаа хүн л дээ.

**Л.Мөнхбаатар:** С.Чинзориг сайдын асуултад хариулья. Л.Энх-Амгалан сайд хариулах уу?

**Л.Энх-Амгалан:** С.Чинзориг сайд Засгийн газрын гишүүн, тэгээд ажлын хэсгийн гишүүн.

Тэгээд өөрөө өөртэйгөө зөрчилдөөд яваад байна гээд яриад байна л даа.

Тэгэхээр өөрөөсөө асуугаад, өөрөө хариулах л асуултуудыг асуугаад байгаа юм л даа. Ажлын хэсгийн гишүүний хувьд.

Тэгэхээр яах вэ, ярьж байгаа асуудал нь бас нэлээн одоо энэ хуулийн батлагдах гэж байгаа гол концепцтой холбоотой санхүүжилтийн хэсэгтэй холбоотой асуудлуудыг ярьж байгаа учраас хариулт өгөх ёстой гэж ойлгож байна.

Тэгээд мэдээж одоо юу гэдэг юм, Саяын С.Чинзориг сайдын ярьсан манай их, дээд сургуулиуд сүүлийн 30 жилийн турш зөвхөн оюутны сургалтын төлбөрөөсөө орлогоо олдог нэг ийм буруу гаж тогтолцоотой явж ирсэн.

Тийм учраас л одоо ингээд энэ их, дээд сургуулиудын санхүүжилтийн тогтолцоог бусад улсуудад байдаг илүү тийм олон эх үүсвэрээс бүрддэг тогтолцоог л бид нээж, боломжуудыг нь нээж өгч байгаа юм.

Тэгээд ерөнхийдөө төрийн өмчийн сургуулиудаа бид сургалт, судалгаа үйлдвэрлэлийн цогцолбор хэлбэрээр хөгжүүлэх энэ ажлууд бас өнгөрсөн жилээс хийгдээд эхэлсэн.

Тийм учраас дан ганц хүүхдийн сургалтын төлбөрөөр эх үүсвэр биш, судалгаа хийж, тэр тусмаа улс орны өмнө тулгамдаж байгаа суурь судалгаануудыг их, дээд сургуулиуд хийдэг. Үүнийгээ амьдралд нэвтрүүлдэг, инновац болгодог, үйлдвэрлэлд нэвтрүүлдэг энэ бүтэн санхүүжилтийн циклийг л бас нээж өгч байгаа гэж ойлгож байгаа.

Нөгөө талаасаа С.Чинзориг сайд аа, одоо хувийн цэцэрлэгийн төлбөр 3 сая төгрөг болчихсон шүү дээ. Тийм ээ.

Тэгээд бакалавр, магистрын зэрэглэлийг 3-хан сая төгрөгөөр бакалавр, магистрын сургалтуудыг олго гэж хэлэх юм бол бид дахиад боловсролын чанарын тухай ярих ямар ч утгагүй асуудал. Утгагүй асуудал.

Тэгэхээр цаашдаа бид үнэхээр энэ боловсролынхоо чанарыг дээшлүүлээд, тэр тусмаа дээд боловсролынхоо чанарыг дээшлүүлэе гэх юм бол энэ хөтөлбөрийн бодит өртгийг тооцож, яг ямар мэргэжлийн хөтөлбөр ямар өртгөөр сурах ёстой юм гэдэг энэ юман дээр л бид тодорхой санхүүжилтийнхээ хэлбэр, тогтолцоог өөрчилж байж дээд боловсролын чанарт тодорхой ахиц гаргах зайлшгүй тогтолцоо, механизмыг хийж өгөхөөс өөр арга байхгүй л гэж би харж байгаа. Тийм.

**Л.Мөнхбаатар:** Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Их, дээд сургуулийн тухай асуудал, хууль орж ирж байна л даа.

Тэгэхээр яг үүн дээр, тэр тусмаа тэр төрийн өмчийн сургууль дээр засаглал дээр яг ямар бодит өөрчлөлтүүд орж байгаа юм? Энэ сургуулиуд чинь өөрсдөө засаглалын хувьд тодорхой хэмжээнд бие даагаагүй, хар хараат бус шийдвэр гаргахгүй, улс төрөөс шийдвэр гаргадаг, удирдлага өөрчлөгддөг байсан тохиолдолд нэгдүгээрт нь ямар ч гоё сайхан зүйлүүд яригдаад энд юу ч биелэхгүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр яг бодитой засаглалын хувьд ямар өөрчлөлтүүд орж байгаа вэ?

Тэр тусмаа засаглалаасаа гадна одоо чинь бараг энэ их, дээд сургуулиуд чинь төрийн өмчит улсын үйлдвэрийн газар ч билүү, бараг тэр статусаар зарим нь явж байгаа байх. Энэ чинь улсын үйлдвэрийн газар гээд их, дээд боловсролыг зохицуулаад явна гэдэг. Эндээс хүлээх үр дүн, олон зүйлүүд, харилцаа дутуу байна л гэсэн үг.

Дахиад нөгөө талаас нь. Ер нь засаглал, засаглалаас үүдсэн хараат бус байдал дээр дахиад л түрүүн С.Чинзориг гишүүний би яг эсрэгийг нь л хэлэх гээд байна л даа.

Энэ их, дээд боловсрол гэдэг зүйл чинь өөрөө чөлөөтэй, тэр төлбөр нь зах зээлд гарах боловсон хүчнээс авах, төлж байгаа төлбөр, олон зүйл нь тэр зах зээлийнхээ харилцаагаар зах зээлд өрсөлдөхүйц тэр дэд бүтэц, чанартай багш, сургалтын хөтөлбөр, олон зүйл авахын тулд тэр төлбөр гэж байгаа зүйл чинь илүү тэр засаглалынхаа хувьд бие даан шийддэг боломж, бололцоо энд хуулиараа олдож байгаа юу?

Тэр шийдэгдэхгүйгээр дахиад цэцэрлэгийн хүүхдээс хямдхан төлбөрөөр ямар бүтээгдэхүүн эргээд гарах вэ гэдэг дахиад л тодорхой шүү дээ.

Тэгэхээр энэ дээр тодорхой тийм нэг либералчлалын боломж, бодлого яг юу сууж байгаа вэ?

Хоёрдугаарт нь, ер нь энэ их, дээд боловсролоос гарч байгаа бүтээгдэхүүн л гэж хэлье л дээ. Одоо яг юу гэж томьёолж байгаа юм? Энэ өөрөө тийм нэг үнэмлэх, дипломд суурилсан хуучны тэр концепт[concept], дахиад чадвар, чадамж

гэдэг зүйл рүүгээ ямар алхам хийгдэж байгаа юм бол? Энэ чинь хүртэл өөрөө концептын хувьд нэлээн тийм өөрчлөлттэй болоод явж байгаа байх гэж бодож байна.

Тэгээд үүнтэй холбоотой дахиад л янз бүрийн олон асуудлууд гарна. Тэр судалгааны их сургууль болох, эндээс гарааны компаниуд, дэргэдээ тэр инновацын төв, олон зүйлтэйгээ ер нь нийт их, дээд сургуулиудад бодлогын ямар тийм түлхэлт эндээс энэ хуулиар хийгдэж байгаа вэ? Ямар боломж, бололцоонууд нь нээгдэж байгаа вэ? Энэ дээд боловсролын хуулиар.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням хариулья.

**Г.Дамдинням:** О.Цогтгэрэл гишүүн их чухал зүйлийг хөндөж хэлж байна.

Манай боловсролын ерөнхий хуультай хамт өргөн баригдсан нийт 7 хууль, одоо 4 хууль болж ирж байгаа хуулиудын үндсэн зарчмын нэг зарчим нь энэ засаглалын шинэчлэлийг хийе гэж байгаа юм.

Улс төрөөс хараат бус томилгоог зохион байгуулдаг больё. Мэргэжлийнхний оролцоог энд нэмье гээд.

Хуулийн төслийн 24 дүгээр зүйл дээр бид заагаад өгчихсөн байгаа. Удирдах зөвлөл захирлаа өөрөө шууд шийднэ.

Хуучин батламжилдаг байсан. Сайд. Одоо тэр бол байхгүй болж байгаа.

Хоёрдугаарт, санхүүжилттэй холбоотой асуудал дээр Та асууж байна.

Санхүүжилттэй холбоотой асуудал дээр ер нь багцлаад хэлэхэд “сургалтын төлбөр”, “эрдэм шинжилгээний санхүүжилт”.

**Endowment fund** гэж ярьдаг юм даа. “Их сургуулийн өөрийнх нь сан”.

“Инновац, гарааны компанийн орлого” гэсэн **4 багц санхүүжилт** их, дээд боловсролын салбарт орж ирж байгаа.

Энэ сургуулиудын эрх чөлөө, тэгээд Удирдах зөвлөлийн хэм хэмжээ, Эрдмийн зөвлөлийн эрх чөлөөний асуудал энэ хуулиуд дээр их тодорхой туссан.

Ер нь хуучин байсан нь их хязгаарлагдмал. Тэгээд тэр статустай холбоотой асуудлууд ер нь байхгүй болсон.

Боловсролын ерөнхий хуулийг хэлэлцэгдэж байх үед бид ярьсан байгаа. Боловсролын ерөнхий хуулийг дагуулаад Улсын бүртгэлийн тухай хуульд энэ боловсролын байгууллагуудыг 6, 7 төрлөөр бүртгэдэг байсныг цэгцэлсэн.

Хуучин “**төрийн бус байгууллага**”, “**улсын үйлдвэрийн газар**” гээд л янз янзаар бүртгэдэг байсан бол одоо “**боловсрол, сургалтын байгууллага**” гэдэг шинэ төрөл гаргаж ирж бүртгэж явж байхаар хуульчилж цэгцэлж байгаа.

Энэ нь татвар хураамжтай холбоотой, тэгээд бүртгэлтэй холбоотой олон асуудлыг шийдэх шийдлүүд хуулиар орж ирж байгаа. Тийм.

**Л.Мөнхбаатар:** Та тодруулах юм уу? О.Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

**О.Цогтгэрэл:** Одоо чинь хэдэн их, дээд сургууль байдаг билээ? Бараг 180 мянган оюутан суралцдаг гэдэг байх. Ерөнхий боловсрол төгсөөд бараг бүгдээрээ л ийшээгээ очоод орчихдог.

Тэгэхээр энэ хуулийн дараа яг энэ хандлагууд ер нь яаж өөрчлөгдөх юм?

Одоо чинь ер нь тэгээд л их, дээд сургууль төгслөө гэдэг. Аж ахуйн нэгжүүд дээр гараад чанарын шаардлага хангадаггүй. Аж ахуйн нэгжүүд дахин бараг тодорхой хугацаа орж байж нэг юм ажилтантайгаа ойлголцдог ийм л тогтолцоо, ийм бүтээгдэхүүн гаргадаг үйлдвэрлэл тэнд бий болчихоод байгаа шүү дээ.

Тэгэхээр эндээс ямар нэгэн чанартай бүтээгдэхүүн гарах чиглэл рүү яг ямар алхмууд хийгдэж байгаа юм бол?

Тэр тусмаа тодорхой хэлбэл оюутны тоо одоо хэд байгаа билээ? Энэ ер нь цаашдаа энэ чигээрээ яваад байх юм уу, буурах юм уу? Тодорхой үр дүнгүүдээс эндээс л гарч эхлэх ёстой. Энэ бодлогын чиглэлүүд хаашаа явж байгаагаас л харагдах ёстой байх л гэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Л.Энх-Амгалан сайд хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Одоо Монгол Улсад 60 гаруй их, дээд сургуультай болсон. О.Цогтгэрэл гишүүн ээ,

100 гаруй байсан. Одоо ямар ч байсан бид сүүлийн хоёр жилд Монгол Улсын Засгийн газраас боловсролын чанарыг дээшлүүлэх чиглэлд хийсэн шинэчлэлийн хүрээнд их, дээд сургуулиудын тоо нэлээн цөөрч байгаа.

Тоо цөөрч байгаа гэдэг бол чанар чанар дээр дэвшилт гарч байна л гэж ойлгож болно.

Ерөнхийдөө манай Монгол Улсын дээд боловсролын тогтолцоо мэргэжлийн болон техникийнх нь боловсролын тогтолцоог залгичихсан нэг ийм л тогтолцоо шүү дээ.

Тэгэхээр яг хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтэй, тэргүүлэх мэргэжлээр шаардлагатай байгаа тэр хүмүүсээ бэлдэж чаддаггүй. Ерөөсөө түншлэл гэдэг юмыг ерөөсөө бий болгоогүй. Одоо ажил олгогч яг ямар ур чадвартай хүн хүсээд байгаа юм бэ гэдгийг сайн тодорхойлж чаддаггүй. Ажил олгогч нарт байгаа түншлэлийн хэлбэрүүдийг биелүүлж чадаагүй учраас л өнөөдөр зах зээлийн эрэлт нийлүүлэлт дээр тодорхой гажуудал гарчихсан нэг ийм л тогтолцоог бид засъя гэж оруулж ирж байгаа юм.

Тэгэхээр одоо үндсэндээ юу гэдэг юм, бараг гурав.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Одоо эрхэм гишүүн Сайнхүүгийн Ганбаатар асуултаа асууя.

**С.Ганбаатар:** Дээд боловсролын хуулийг дэмжиж байгаа. Өөрчлөх цаг нь болсон. Өмнөх хууль гажуудалтай зүйл олон байсан.

Эхний нэгдүгээр асуулт. 12.12-т, хуудас 20 дээр байгаа.

Магадлан итгэмжлэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон ашгийн төлөө бус байгууллага хэрэгжүүлэх бөгөөд тус байгууллага нь үйл ажиллагааныхаа үр дүнг боловсролын асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллагад тайлагнана гэж байгаа.

Одоо 60 гаруй дээд боловсролын салбарын энэ олон сургуулиуд чанартай, чанаргүй олон янз байгаа. Зарим нь дээд боловсролын дипломтой худалдагч хийгээд явж байна гэдэг бол тэр хүүхдийн мөрөөдлөөр мөнгө хийсэн хэсэг хүн байна л гэсэн үг шүү дээ.

Тэгэхээр магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаан дээр дээд боловсролын тогтолцоонд яг чанартай байгаа тал дээр яаж хариуцлага тооцож байгаа вэ? Хүүхдүүдэд яг чанартай ирээдүйдээ мөнгөтэй, баталгаатай ажлын байртай боловсрол эзэмшүүлэхэд чанарыг нь яаж баталгаажуулж байгаа вэ? Магадлан итгэмжлэл яаж ажиллаж байгаа вэ? Яаж өнөөдрийн байдлаас өөр болох вэ? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт. Түрүүн Л.Энх-Амгалан сайд хэлж байна. Зөв өө. Их, дээд сургууль, ялангуяа улсын их, дээд сургуулиуд сонгуульд сайн явсан хүнийг менежерээр тавьдаг нэг албан тушаал болчихсон юм шиг л байдал 30 жил Монголд үзэгдлээ шүү дээ. Хэтэрхий. Энэ бол хүүхдүүдийн хувь заяагаар тоглож байгаа асуудал.

Тэгэхээр дээд боловсролын байгууллага нь оюуны өмчийг бүртгэлжүүлэх, хамгаалах, ялангуяа их сургууль нь аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжсэн тогтолцоог бүрдүүлсэн байна гэж байгаа. Яг энэ тогтолцоогоо яаж бүрдүүлэх вэ?

Баруунд их, дээд сургуулиудаа түшиглэж л ноу-хау, патент, инженерийн үйлдвэрлэлүүд нь урагшилдаг. Анагаахын сургуулийн дэргэдэх эмнэлгүүд нь бараг хамгийн том

судалгааны эмнэлгүүд болоод хувирчихсан байдаг.

Тэгэхээр энэ тал дээр реформ хийх хэрэгтэй байгаа. Хувийн хэвشلүүдийг татан оролцуулах шаардлагатай байгаа. Зүгээр энэ тогтолцоог бүрдүүлсэн байна гээд л орхисон байгаа. Яг яаж вэ гэдгийг энэ дээр олон хүмүүс харж байгаа байх.

Удирдах зөвлөлд нь тухайн салбарын тэргүүлэгч эрдэмтэд, бизнесийн төлөөллүүд оролцох уу? Хөтөлбөрүүдээ яаж боловсруулах вэ гэдэг дээр тэр барууныхан анхаардаг юм байна лээ. Үүнийг нэг дэлгэрүүлж тайлбарлаж өгөөч ээ.

Гуравдугаар асуулт. Энэ том хууль л даа. Том асуудлыг зохицуулж байгаа. Олон журам баталж байгаа. Маш олон журам. Явж явж нохойноосоо гинжинэ гэгчээр журам дотор чинь ер нь хуулиасаа том том заалтууд орчих гээд байдаг.

Миний асуулт техникийн чанартай л юм шиг болчихлоо доо.

24.9 дээр. Энэ номер нь жоохон өөрчлөгдсөн байж магадгүй. Зөвлөл нь орон тооны ажлын алба тухайн чиглэлийн дэд зөвлөлтэй байна. Ажлын алба дэд зөвлөлийн үйл ажиллагааг журмаар зохицуулна гэж байгаа юм.

Энэ журмыг хэн батлах вэ гэдэг нь тодорхойгүй байна. Энэ дээр би хариулт авахыг хүсэж байна.

Дөрөвдүгээр асуулт. 28.1.8-д багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан болон бусад ажилтны орон тоо, цалингийн сүлжээг баталж, сонгон шалгаруулалтын чадавхын мерит болон хөгжихүйн зарчимд үндэслэн явуулж томилох гэгчихсэн байгаа.

Энэ дээр багш нар, боловсролын салбарын ажилтнуудаа төлөөлж байгаа үйлдвэрчин болон тэр эрх ашгийг нь хамгаалдаг байгууллагуудын оролцоо хэр байгаа вэ? Зүгээр л дарга л шийдээд байх уу?

Энэ дээр суралцагч буюу тэр гол бүтээгдэхүүнүүдийн чанарыг тодорхойлж байгаа оюутнуудын төлөөллийн байгууллагуудын бас санаа бодлыг тусгаж байгаа зүйл байна уу?

**Л.Мөнхбаатар:** Асуултад Л.Энх-Амгалан сайд хариулья.

**Л.Энх-Амгалан:** С.Ганбаатар гишүүн ээ, яг таны сая хөндөж тавьж байгаа асуудал бол энэ дээд боловсролын чанарын баталгаажуулалтын, чанарын тогтолцооны асуудлуудыг Та яг хөндөж ярьж байна.

Монголд ерөөсөө дээд боловсрол баахан дипломтой ажилгүйчүүдийг үйлдвэрлэдэг нэг ийм дээд боловсролын тогтолцоотой болчихсон.

Азийн хөгжлийн банкны гаргасан судалгаагаар Монгол Улсын дээд боловсролын тогтолцоо чинь өөрөө ядуурлыг өдөөдөг тогтолцоо болчихсон байна гэсэн дүгнэлт гарсан шүү дээ. Тийм ээ.

Хүүхдүүд төгсгөөд л байдаг, төгсгөөд л байдаг. Өнөөдөр гурван хүүхдийн нэг нь л ажлын байртай болж байгаа. Энэ тогтолцооны гажгийг л бид арилгая гэж байгаа.

Тэгээд яаж арилгах вэ гэж. Мэдээж боловсролынхоо чанарын баталгаажуулалтын тогтолцоон дээр бид шинэчлэл хийж байж л үүнийг арилгах ёстой.

Тэгээд цаашдаа бид “**дотоод чанарын баталгаажуулалт**”, “**хөндлөнгийн үнэлгээ**”, “**магадлан итгэмжлэл**” гэсэн ийм 3 хэлбэрээр чанарын баталгаажуулалтуудаа хийж явъя гэж байгаа.

Одоогийн байгаа Магадлан итгэмжлэлийн төв нь их марзан юм билээ. Юу вэ гэхээр бараг ингээд бүх хөтөлбөрүүд сайн дураараа магадлан итгэмжлэгддэг. Сайн дураараа.

Тэгээд магадлан итгэмжлэл хийлгэж байгаа сургуулиасаа мөнгө аваад магадлан итгэмжлэл хийдэг нэг ийм л тогтолцоо байгаад байгаа байхгүй юу.

Тэгээд нөгөө нүглийн нүдийг гурилаар хуурна гэдэг чинь нэг ийм тогтолцоо.

Одоо тэгэхээр цаашдаа бид энэ хөндлөнгийн үнэлгээнийхээ тогтолцоо, магадлан итгэмжлэлийнхээ тогтолцоог жаахан шинэ шатад гаргая.

Ер нь бид нарын бас энэ мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол. Түүрүүн О.Цогтгэрэл л гишүүний асуугаад байсан энэ тогтолцооны гажиг чинь өөрөө ерөөсөө энэ үндэсний мэргэжлийн шаталсан тогтолцоогоо бид үүнийхээ ач холбогдлыг ойлгож чадаагүй юм байна.

Үүнийгээ бид боловсролынхоо түвшин бүрийн бүтэцтэй уяж, хүн яг ямар насандаа боловсролын ямар түвшинд ямар ур чадваруудыг авах ёстой вэ гэдэг тогтолцоогоо бид хийж чадаагүй юм байна.

Тийм учраас одоо бид Магадлан итгэмжлэх төвийг үндэсний мэргэжлийн шаталсан тогтолцоогоо авч явдаг, дахиад

магадлан итгэмжлэхээ авч явдаг удирдлагын ийм том зохион байгуулалтын асуудлуудыг бас хийж байгаа юм гэдгийг би нэг онцлоод хэлчихье гэж бодож байна.

Хоёр дахь асуудал. Та маш чухал асуудал хөндлөө.

Ерөөсөө манай энэ дээд боловсрол, шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагаа гэдэг юм ноль. Ноль. Хоёр тусдаа. Шинжлэх ухаан нь тусдаа, дээд боловсрол нь тусдаа.

Гэтэл бусад улс орнуудын хөгжлийн нууц нь боловсролынхоо, тэр тусмаа дээд боловсролынхоо тогтолцоог шинжлэх ухаантай уяж, шинжлэх ухааны хүрээлэнгүүд нь, эрдэмтэд нь хамтарч ажиллаж байж улс орны өмнө тулгамдсан асуудлуудаа шийдэж чаддаг энэ тогтолцоог л хийж урагшилсан юм билээ.

Тийм учраас энэ хуулиар ганцхан дээд боловсролын байгууллага хүүхдүүд сургаад, оюутан сургаад, хүүхэд сургадаг гэдэг байгууллагаасаа илүү судалгаа, шинжилгээнийхээ чиглэл рүү илүү инновац бүтээдэг, мэдлэгийг инновац болгодог энэ тогтолцоог дэмжсэн ийм л эрх зүйн шинэчлэлтүүдийг хийхээр бид зорьж байгаа юм.

Гуравдугаар асуудал. Та тэр нөгөө засаглалтай холбоотой асуудлууд, төлөөллийн асуудлуудыг хөндөж тодруулж байх шиг байна.

Энэ дээр нэлээн томоохон ахиц гарч байгаа. Юу гэхээр хуучин сайд томилдог байсан тогтолцооноос бид татгалзаж тухайн сургуулийн удирдах зөвлөл нь сургуулийнхаа удирдлагыг сонгон шалгаруулалтаар томилдог, удирдах зөвлөл нь гэрээгээ хийдэг.

Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд нь тэр оюутнуудын эрх ашгийг хамгаалсан оюутнуудын төлөөллүүд, мөн багш нарын төлөөллүүдийг оруулдаг. Тодорхой төлөөллүүд нь тэдэн хувиас багагүй байна гэдэг хамгаалалтуудыг, төлөөллүүдийн оролцоог нь хангаж өгсөн ийм шинэчлэлүүдийг л хийж байгаа юм.

С.Ганбаатар гишүүн ээ. Тийм ээ. Ажил олгогчдын оролцоо байгаа.

**Л.Мөнхбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураана. Нийтдээ 34 санал байна.

Боловсролын ерөнхий хуультай хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дэмжсэн саналууд байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгаа, санхүүжилт, эдгээртэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Э.Батшугар, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг,

Б.Пүрэвдорж, Ч.Ундром, С.Чинзориг,  
Т.Энхтүвшин. Цаашид “Ажлын хэсэг”  
гэнэ. Санал хураалт. /алх цохив/

70.0 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1  
дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн  
найруулах:

“2.1.Дээд боловсролын зорилго нь  
нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь  
нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа,  
судалгаа, инновацыг хөгжүүлэх,  
бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд  
ажиллаж амьдрах чадвартай, ёс  
суртахуунтай иргэн бэлтгэхэд оршино.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1  
дэх хэсгийн “Судалгааны их сургуулийн  
эрх зүйн байдлын тухай хууль,” гэснийг  
хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

70.0 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1  
дэх заалтын “дээд боловсролын” гэсний  
дараа “сургалтын байгууллагын” гэж,  
4.1.3 дахь заалтын “төлбөр” гэсний дараа  
“судалгааны болон” гэж нэмж, 4.1.1 дэх  
заалтын “дипломын” гэснийг “дэд  
бакалаврын” гэж 4.1.2 дахь заалтын  
“магистр, докторын хөтөлбөрийн  
сургалтыг” гэснийг “магистрын болон  
докторын сургалтын хөтөлбөрийг  
хэрэгжүүлэх үйл ажиллагааг” гэж, 4.1.4  
дэх заалтын “олгогдох” гэснийг  
“суралцагчид олгох” гэж өөрчилж, 4.1.5  
4.1.6 дахь заалтыг төслөөс хасаж, мөн

зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.7-  
4.1.10 дахь заалт нэмэх:

4.1.7.“сургалтын төлбөрийн  
хөнгөлөлт” гэж дээд боловсролын  
сургалтын байгууллагын суралцагчийн  
сурлагын амжилт, төлбөрийн чадамжийг  
тооцож төлбөрөөс тодорхой хувиар  
чөлөөлөхийг;

4.1.8.“шаталсан сургалт”  
гэж боловсролын бусад түвшний  
хөтөлбөрийг зэрэгцсэн болон дараалсан  
байдлаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

4.1.9.“судалгааны грант”  
гэж Инновацын тухай хуулийн 3.1.7-д  
зааснаас гадна байгууллага, судлаачийн  
судалгааны ажилд зориулж иргэн,  
хуулийн этгээд, олон улсын  
байгууллагаас урьдчилан нөхцөл,  
болзолтой буцалтгүй олгох мөнгөн,  
мөнгөн бус хөрөнгийг;

4.1.10.“судалгааны их  
сургууль” гэж судалгааны үйл ажиллагаа  
эрхэлдэг, бакалавр болон ахисан түвшний  
сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд  
боловсролын сургалтын байгууллагыг.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

67.5 хувиар санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай  
5 дугаар зүйл нэмэх:

**“5 дугаар зүйл.Дээд  
боловсролын сургалтын байгууллага  
үйл ажиллагаандаа баримтлах зарчим**

5.1.Дээд боловсролын сургалтын  
байгууллага үйл ажиллагаандаа  
Боловсролын ерөнхий хуульд зааснаас  
гадна дараах зарчмыг баримтална:



5.1.1.Эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;

5.1.2.оюуны бүтээл, судалгааны ёс зүйг дээдлэх;

5.1.3.дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг дэмжсэн байх;

5.1.4.хамтын удирдлагатай, улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

65.0 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийн “**БОЛОВСРОЛЫН**” гэсний дараа “**СУРГАЛТЫН**” гэж нэмж /цаашид тохиолдол бүрд/, төслийн 5.1 дэх хэсгийн “гэсэн ангилалтай” гэснийг, мөн зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 5.5, 5.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 5.7-5.9 дэх хэсэг нэмэх:

“5.5.Энэ хуулийн 5.1, 6.7-д заасан дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг техникийн зохицуулалтад үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

5.6.Цэрэг, цагдаагийн мэргэжлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 3.1.19-д заасан төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага эрхэлнэ.

5.7.Энэ хуулийн 5.1, 6.7-д заасан дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалтыг Засгийн газар батална.

5.8.Консерватор нь ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, техникийн болон дээд боловсрол эзэмшүүлэх шаталсан сургалттай хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллага байна.

5.9.Технологийн коллеж нь бүрэн дунд боловсрол, техникийн болон дээд боловсролын шаталсан сургалттай, дэд бакалавр, бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллага байна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4, 6.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 6.1, 6.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.7-6.11 дэх хэсэг нэмэх:

“6.1.Их сургууль нь дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

6.5.Их сургууль нь харьяалалтай коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, судалгааны лаборатори, төв, хүрээлэн, ахлах сургууль, дадлагын баазтай байж болно.

6.7.Их сургуулийг үйл ажиллагааны хүрээ, сургалт, судалгааны чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагч, төгсөгчийн тоо, холбогдох бусад үзүүлэлтэд үндэслэн судалгааны, сургалтын, мэргэжлийн гэж ангилна.

6.8.Их сургууль нь сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор байж болно.

6.9.Багш бэлтгэх их сургууль нь харьяалалдаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

6.10.Соёл, урлаг, цэргийн мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль нь бүрэн дунд сургуультай /6-12 дугаар анги/ байж болно.

6.11.Судалгааны их сургуулийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

67.5 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалтын” гэснийг “дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгааны” гэж, 7.4 дэх хэсгийн “боловсрол, сургалтын байгууллагатай” гэснийг “боловсролын сургууль, ахлах сургуультай гэж өөрчилж, 7.2, 7.3, 7.5 дахь хэсгийг төслөөс хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

67.5 хувиар санал дэмжигдлээ.

9.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 8.2 дахь хэсгийг төслөөс хасах:

“8.1.Коллеж нь дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг

сургалт-судалгаа, сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

8.3.Коллеж нь харьяалалдаа политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, ахлах сургуультай байж болно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

65.0 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “зөвшөөрөл” гэсний өмнөх “, тусгай гэснийг хасаж, 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр харьяаллын сургуульд байгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

67.5 хувиар санал дэмжигдлээ.

11.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Эрдмийн зөвлөл,” гэсний дараа “Хөтөлбөрийн хороо,” гэж, 10.3 дахь хэсгийн “Эрдмийн” гэсний дараа “зөвлөл болон хөтөлбөрийн хороо,” гэж нэмж, төслийн 10.5 дахь хэсгийн “Төрийн өмчийн” гэснийг, мөн зүйлийн 10.4, 10.6, 10.7, 10.9, 10.11, 10.15 дахь хэсгийг төслөөс хасаж, 10.14 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.16-10.18 дахь хэсэг нэмэх:

“10.14.Дээд боловсролын сургалтын байгууллага нь дотуур байртай байж болно. Дотуур байранд тавих

шаардлагыг стандарт, техникийн зохицуулалтаар тогтооно.

10.16. Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлэх, сайжруулах дүгнэлт, санал гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хөтөлбөрийн хороотой байна.

10.17. Энэ хуулийн 10.5-д заасан их сургуулийн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлж болно.

10.18. Энэ хуулийн 9.2-г заасан дээд боловсролын сургалтын байгууллага нь цэрэг, цагдаагийн тогтолцоонд хамаарах анги, байгууллага, цэргийн байртай байна.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. /алх цохив/

Нямаагийн Энхболд дарга үг хэлье.

**Н.Энхболд:** Баярлалаа. Энэ 10.18 гээд заалт байна. Шинээр орж байгаа. Дээд боловсролын сургалтын байгууллага нь цэрэг, цагдаагийн тогтолцоонд хамаарах анги, байгууллага, цэргийн байртай байна гээд.

“Байгууллага” гэдэг дотор нь тухайлбал Цэргийн нэгдсэн их сургуульд байгаа тэр салбар хэсгүүд нь академи, ахлагчийн сургууль, “Тэмүүжин өрлөг” эд нар бүгд багтаж байгаа гэж нэгд ойлгож байгаа.

Хоёрдугаарт, 5.6 дээр байгаа. Цэрэг, цагдаагийн мэргэжлийн чиглэлийн

сургалтын үйл ажиллагааг төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага эрхэлнэ гэгчихсэн байгаа.

Энэ нь өөрөө тэр удирдлагын чиглэл дээр нь янз бүрийн хоёрдмол байдал үүсэх. Одоо жишээ нь, цэргийн сургуулиудыг Боловсролын яам удирдана ч гэдэг юм уу. Тийм зүйлүүд гарахгүй гэж ойлгож, бодож, саналаа өгч дэмжих гэж байна. Зөв үү? Сайд аа, ажлын хэсэг ээ.

Микрофондоо хэлчихвэл сайн байна.

**Л.Мөнхбаатар:** Н.Энхболд гишүүн үг хэллээ.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 11 дүгээр зүйлийг 18 дугаар зүйл болгон шилжүүлж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“18 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт**

18.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт бүрэн дунд боловсрол эзэмшсэн, элсэлтийн шаардлага хангасан хүнийг элсүүлнэ.

18.2. Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч тухайн мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэхэд энэ хуулийн 18.1 дэх хэсэг хамаарахгүй.

18.3. Боловсролын ерөнхий хуулийн 17.8, энэ хуулийн 18.8-д заасан

үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.4.Дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэгчийн элсэлтийн шалгалтын босго оноог өмчийн хэлбэр харгалзахгүйгээр боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ижил хэмжээгээр тогтооно.

18.5.Элсэлтийн шалгалтын босго оноог шинэчлэхэд өмнөх босго оноог бууруулахгүйгээр тогтооно.

18.6.Дээд боловсролын сургалтын байгууллага мэргэжил эзэмшихэд шаардагдах мэдлэг, ур чадварыг харгалзан элсэлтийн нэмэлт шалгалт зохион байгуулж болно.

18.7.Ахисан түвшний сургалтад элсэгч, суралцагчид тавих шаардлага, элсэлтийн шалгалтыг сургуулийн дотоод журмаар зохицуулна.

18.8.Элсэлтийн шалгалтын зохион байгуулалт, үнэлгээний арга зүйг олон улсын чиг хандлагад нийцүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

70.0 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 12 дугаар зүйлийн гарчгийн “**Чанарын баталгаажуулалт**” гэсний өмнө “**Дээд боловсролын**” гэж нэмж, 12.1 дэх хэсгийн “үйл ажиллагааны” гэснийг, мөн зүйлийн 12.5, 12.6, 12.9, 12.12 дахь хэсгийг төслөөс хасаж, төслийн 12.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 12.13-12.18 дахь хэсэг нэмэх:

“12.8.Дээд боловсролын сургалтын байгууллага, Боловсролын ерөнхий хуулийн 12.4, энэ хуулийн 12.16-д заасан хөтөлбөр, тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг 5 жил тутамд магадлан итгэмжилнэ.

12.13.Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг энэ хуулийн 12.18-д заасан цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран хоёр жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ.

12.14.Энэ хуулийн 12.13-т заасан хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.15.Анагаах ухааны мэргэжлийн чиглэлийн сургалтын хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

12.16.Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансааны үзүүлэлт тухайн байгууллагын суралцагчид хуульд заасан дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох үндэслэл болно.

12.17.Дээд боловсролын цахим мэдээллийн сан нь Боловсролын ерөнхий хуулийн 48.3-т зааснаас гадна магадлан итгэмжлэл, эрдэм шинжилгээний бүтээл, санхүүжилт, иргэний гадаад улсад эзэмшсэн боловсрол, үнэлгээ, хөдөлмөр эрхлэлт зэрэг мэдээллээс бүрдэнэ.

12.18.Энэ хуулийн 12.8-д заасан хугацаагаар 3 удаа магадлан итгэмжлэл хийлгэсэн дээд боловсролын сургалтын байгууллага цаашид 10 жил тутам магадлан итгэмжлэл хийлгэнэ.

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг хүчингүйд  
тооцлоо.

Ц.Сэргэлэн гишүүн үг хэлье.

**Ц.Сэргэлэн:** Баярлалаа.

Ер нь энэ ганц зүйл дээр биш. Энэ хууль дээр түрүүн Н.Энхболд гишүүн ч асууж байна лээ.

Энэ үндэсний аюулгүй байдлын судлал, чиглэлээр үндсэн болон нэмэгдэл боловсрол олгодог сургалтын үйл ажиллагаа. Үүнийг юу гэж томъёолоод байгаа вэ гэхээр цэрэг, цагдаагийн боловсрол эзэмшүүлдэг сургалтын тогтолцооны асуудал энэ хууль дээр орж ирж байгаа.

Үүнийг оруулах талаар яг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сургуулиудын эрдэмтэн багш, судлаачид, удирдлага, энэ хуулийн ажлын хэсэг маш сайн ажилласан.

Яг энэ чиглэлийн мэргэжлийн байгууллагуудын саналыг нэгтгэн авч хуульд тусгах тал дээр идэвхийлэн ажиллаж нэлээд асуудлууд нь дорвитой орж иржээ.

Ер нь базаад хэлэх юм бол миний саяын хэлдэг энэ сургалтын тогтолцоо. Өөрөөр хэлбэл цэрэг, цагдаагийн, төрийн тусгай байгууллагуудын боловсон хүчнийг төрийн захиалгаар бэлтгэдэг энэ боловсролын байгууллагуудын эрх зүйн орчныг маш тодорхой болгох зайлшгүй шаардлага байгаа юм.

Яагаад гэвэл одоогийн мөрдөж байгаа Боловсролын хуульд энэ асуудал ерөөсөө байхгүй. Одоо харин энэ

шинэчлэгдэж байгаа хуулиудад нэлээн сайн суулгаж өглөө.

Ингэснээрээ энэ байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахад эрх зүйн зохицуулалт нь ойлгомжтой, тодорхой болж ирснээрээ энэ чиглэлийн үйл ажиллагаагаа явуулж байгаа сургуулиудын сургалтын эцсийн үр дүн сайжирна гэж би бодож байгаа юм.

Тэгээд энэ дээр идэвхтэй ажилласан ажлын хэсгийнхэндээ талархал дэвшүүлье. Манай гишүүд үүнийг дэмжиж байгаад би талархаж байна.

Ер нь нэлээн нарийн агуулгатай юмнууд орсон шүү гэдгийг бас хэлье гэж бодсон юм. Яагаад гэвэл энэ сургуулиуд чинь өөрөө төрийн тусгай байгууллагуудын статустай байгууллагууд. Өөрөөр хэлбэл цэргийн ангийн дугаартай гэсэн үг.

Нарийн хэлэх юм бол янз бүрийн цагийн байдал үүссэн тохиолдолд энэ байгууллагууд өөрөө шууд тушаал биелүүлэх ийм статустай субъектүүд. Үүрэг гүйцэтгэдэг.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн шууд бэлтгэл хүч, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хилийн цэргийн командлагчийн бэлтгэл хүч энэ сургуулиудад байдаг.

Энэ утгаараа шаардлага гарсан үед үүрэг гүйцэтгэдэг энэ байгууллагуудыг ердийн боловсролын байгууллагуудтай адилтган үзэх ямар ч боломжгүй учраас элсэлтээс нь эхлээд төгсөлт, эргээд томилолт нь хүртэл шууд төрийн тусгай байгууллагад очдог учраас ингэж шийдсэн юм гэдгийг би хэлэхийг хүсэж байна.

Тэгээд гишүүд маань үндэсний аюулгүй байдлын судлал чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, боловсрол олгодог энэ системийг шинээр эрх зүйн үндсийг нь бүрдүүлэхэд дэмжиж өгөөрэй гэдгийг хүсэж байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн Гочоогийн Ганболд нарын урилгаар Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын даргын Тамгын газрын алба хаагчид, мөн Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын сургуулийн 1991, 1993 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажил, амьдралд нь сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

64.1 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “эрдэм шинжилгээ” гэснийг “судалгааны ажилд оролцох, бусад сургуулийн суралцагч, багштай хамтран” гэж өөрчилж, төслийн 13.1.6 дахь заалтын “баялаг болгон хувиргах” гэснийг, мөн зүйлийн 13.1.4, 13.1.7 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 13.1.10, 13.1.11 дэх заалт нэмэх:

“13.1.10.улиралд судлах багц цагийг сонгож, суралцах хугацааг төлөвлөх;

13.1.11.ижил түвшний бусад сургуулийн хичээл болон багшийг сонгон суралцах, багц цагийг дүйцүүлэх.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.1.4 дэх заалт нэмэх:

“14.1.4.хууль тогтоомжид заасан сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх;”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.0 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн “Суралцагчийн сургалтын үнэлгээ” гэсэн 15 дугаар зүйлийг 21 дүгээр зүйл болгон шилжүүлж доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“21 дүгээр зүйл.Суралцагчийн үнэлгээ, төгсөлт**

21.1.Суралцагчийн үнэлгээ нь суралцахуйн үр дүнг бататгах, бие даан суралцах үйл ажиллагаа, бүтээлч хандлагыг дэмжих, авьяас, ур чадварыг хөгжүүлж урамшуулахад чиглэнэ.

21.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын онцлогоос хамааран суралцагчийн судалгааны ажлын үр дүн, суралцаж буй мэргэжлийн чиглэлээр олон улсын тэмцээн, уралдаанд гарсан амжилтыг багц цагт тооцож болно.

21.3.Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцахуйн үр дүнг үнэлэх үйл ажиллагааг энэ хуулийн 15.4-т заасан журмаар Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогчийн төлөөлөл хамтран хэрэгжүүлнэ.

21.5.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид диплом олгох, хүчингүй болгох, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчийн дипломыг хүлээн зөвшөөрөх, бүртгэх, баталгаажуулахтай холбогдсон харилцааг Боловсролын ерөнхий хуулийн 30.1.31-д заасан журмаар зохицуулна.

21.6.Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод журмаар, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

65.0 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “хичээлийг” гэснийг “хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, “багш заана” гэснийг “байна” гэж өөрчилж, 16.3 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 16.2, 16.5 дахь хэсэг нэмэх:

“16.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна.

16.5.Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн хөгжлийг хангах журмыг баталж, хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.2.3 дахь заалт нэмэх:

“17.2.3.судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

67.5 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 18 дугаар зүйлд доор дурдсан 18.2 дахь хэсэг нэмж, мөн зүйлийн 18.1.4 дэх заалтыг 18.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тухайн ажиллаж байгаа байгууллагаас дараах дэмжлэгийг үзүүлж болно:

18.2.1.орон нутаг дахь төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багш, ажилтанд орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг 5 жил тутамд нэг удаа олгох;

18.2.2.дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багшид Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16.1.2-т заасан тэтгэмж олгох.

18.3.Энэ хуулийн 18.2.1, 18.2.2-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбогдсон бусад харилцааг тухайн сургалтын байгууллагын дотоод журмаар зохицуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн “Сургалтын зохион байгуулалт” гэсэн 21 дүгээр зүйлийг 19 дүгээр зүйл болгож, төслийн 21.2. дахь хэсгийн “Магистр, докторын сургалтын” гэснийг “Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт,” гэж өөрчилж, мөн зүйлийн 21.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 21.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 21.5-21.8 дахь хэсэг нэмэх:

“21.3.Дээд боловсролын сургалтын байгууллагын хичээлийн жил нь улиралд хуваагдах бөгөөд 2-4 улиралтай байж болно. Суралцах хугацааг элсэлтийн шалгалттай уялдуулан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөөр тогтооно.

21.5.Суралцагч элссэн мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт суралцах хугацаанд бусад мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт давхар суралцаж хос мэргэжил эзэмшиж болно.

21.6.Дээд боловсролын сургалтын байгууллага нь ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

21.7.Дээд боловсролын сургалтын байгууллага нь төгсөгчийн мэргэжлийн хөгжлийг хангах, насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

21.8.Дээд боловсролын сургалтын байгууллага нь бие даан, эсхүл хамтран цахим сургалтын системийг бүрдүүлэн сургалт зохион байгуулж болно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

65.0 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн “Сургалтын хөтөлбөр” гэсэн 19 дүгээр зүйлд “Сургалтын хөтөлбөрийн агуулга” гэсэн 20 дугаар зүйлийг нэгтгэн “Сургалтын хөтөлбөр, агуулга” гэсэн 20 дугаар зүйл болгож, төслийн 19.1 дэх хэсгийг төслөөс хасаж, төслийн 20.2 дахь хэсгийн “Сургалтын хөтөлбөрийн агуулга нь” гэснийг “Дэд бакалавр, бакалаврын сургалтын хөтөлбөрт” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 19.9-19.16 дахь хэсэг нэмж, төслийн 20.3, 20.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.9.Сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.10.Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн хүсэлтээр энэ хуулийн 19.2-т заасан журмын дагуу бакалавр-магистрын 150-иас, магистр-докторын 90-ээс доошгүй



багц цаг бүхий нэгдмэл агуулгатай хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

19.11.Энэ хуулийн 19.10-т заасан нэгдмэл хөтөлбөрөөр суралцсан төгсөгчид тухайн түвшин бүрийн боловсролын баримт бичгийг олгоно.

19.12.Бакалаврын хөтөлбөрт суралцаж 90 багц цаг судалсан боловч цаашид суралцах боломжгүй болсон суралцагчид дэд бакалаврын зэрэг олгоход тавих шаардлагыг хангасан тохиолдолд тухайн боловсролын баримт бичгийг дүйцүүлэн олгож болно.

19.13.Боловсролын ерөнхий хуулийн 3.1.4-т заасан багц цаг нь дээд боловсрол эзэмшихэд тавих шаардлага, сургалтын төлөвлөгөө, төлбөр, багшийн ажлын ачаалал зэргийг тогтоох үндэслэл болно.

19.14.Боловсролын ерөнхий хуулийн 30.1.10-д заасан дээд боловсролын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн индексийн жагсаалтыг 5 жил тутам шинэчлэн батална.

19.15.Сургалтын хөтөлбөрийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, төгсөгчийн төлөөллөөс бүрдсэн энэ хуулийн 10.2-т заасан хөтөлбөрийн хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

19.16.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцахад хөтөлбөрийн агуулга, багц цаг дүйцүүлэн тооцож болно.

20.3.Дээд боловсролын түвшин нь багц цагаар хэмжигдэх дэд бакалаврын,

бакалаврын, магистрын, докторын зэрэгтэй байна.

20.4.Багц цагийн хэмжээ нь дэд бакалаврын зэрэгт 90 багц цагаас доошгүй, бакалаврын зэрэгт 120 багц цагаас доошгүй, магистрын зэрэгт 30 багц цагаас доошгүй, докторын зэрэгт 60 багц цагаас доошгүй байна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

55.0 хувиар санал дэмжигдсэн байна.

22.Төсөлд **“ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ ИННОВАЦИ”** гэсэн **ТАВДУГААР БҮЛЭГ** нэмж, төслийн 22 дугаар зүйлийг тус бүлэгт хамааруулан, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 22.8 дахь хэсэг нэмэх:

“22.8.Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

23.Төсөлд доор дурдсан агуулгатай 23 дугаар зүйл нэмэх:

**“23 дугаар зүйл.Судалгааны ёс зүй**

“23.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, суралцагчийн эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглахтай

холбогдох үйл ажиллагааг Шинжлэх ухаан, технологийн сан хариуцна.

23.2.Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23.3.Дээд боловсролын судалгааны ёс зүйг Боловсролын ерөнхий хуулийн 27.4-д заасан судалгааны ёс зүйн дэд хороо хариуцна.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан дэд хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

23.4.1.судалгааны ажилд оюуны өмч, зохиогчийн эрхийг зөрчихгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаар дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх журам, заавар, зөвлөмж боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

23.4.2.судлаачийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан хэлэлцэх, хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

65.0 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 5 дугаар бүлгийг 6 дугаар бүлэг болгож, төслийн 23.1 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд” гэснийг хасаж, 23.1.4 дэх заалтын “зэрэг” гэсний дараа “, цол” гэж нэмж, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 23.1, 23.3, 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.1.Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.

23.3.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага нь хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй байж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан нэгжийг Засгийн газар байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

67.5 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 24 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“24 дүгээр зүйл. Дээд боловсролын зөвлөл**

24.1.Дээд боловсролын салбарт Боловсролын ерөнхий хуулийн 27.4-д заасан мэргэжлийн зөвлөл нь Дээд боловсролын зөвлөл байна.

24.2.Дээд боловсролын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгааны үйл ажиллагаа, үр дүнг хэлэлцэх, санал зөвлөмж гаргах, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага байна.

24.3.Зөвлөл нь төрийн, дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага болон үйлдвэр, аж ахуйн нэгж, оюутны төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байна.

24.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Боловсролын ерөнхий хуулийн 27.6-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

65.0 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 25 дугаар зүйлийн 25.4-25.7, 25.9 дэх хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлийн 25.10-25.13 дахь хэсэг нэмж, 25.2, 25.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“25.2.Удирдах зөвлөл нь эцсийн өмчлөгч буюу үүсгэн байгуулагч, тухайн сургуулийн багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.

25.3.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл найм, багшийн төлөөлөл гурав, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл гурав, суралцагчийн төлөөлөл нэг байна.

25.10.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн энэ хуулийн 25.3-т заасан төлөөллийн оролцоог хангасан байна.

25.11.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага дундын удирдах зөвлөл байгуулж болно. Энэ тохиолдолд энэ хуулийн 25.3-д заасан төлөөллийг оролцуулсан байна.

25.12.Энэ хуулийн 25.11-д заасан Удирдах зөвлөл байгуулах тохиолдолд зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

25.13.Энэ хуулийн 25.1-д заасан Удирдах зөвлөлийн даргыг сонгох, гишүүнээр ажиллах, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болгох, дарга, гишүүнийг эргүүлэн татахтай холбогдох харилцааг зохицуулах нийтлэг дүрмийг боловсролын асуудлаар эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг түдгэлзүүллээ.  
Содномын Чинзориг гишүүн үг хэлье.

**С.Чинзориг:** Удирдах зөвлөлд байвал. Уг зарчим чинь талуудын төлөөлөл тэнцүү байх асуудал яригддаг шүү дээ. Удирдах зөвлөл дээр.

Одоо энэ Удирдах зөвлөл чинь төлөөлөл нь тэнцвэртэй бус юм байна л даа. Үүсгэн байгуулагчийн төлөөлөл 8, багшийн төлөөлөл 3, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл 3, сурагчийн төлөөлөл 1 гээд.

Удирдах Зөвлөл байгаагийн зарчим чинь өөрийн удирдлага, талуудын төлөөлөл уг нь тэнцүү байх зарчим нь л байдаг шүү дээ.

Энэ яагаад ингээд алдагдаад. Үүсгэн байгуулагчийн төлөөлөл нь давамгай болоод л. Тэгээд л үндсэндээ үүсгэн байгуулагчийн төлөөлөл үндсэндээ асуудлаа шийдээд яваад байх ийм л юм руу л явна шүү дээ. Үүнийг юу гэж үзэж байгаа юм?

Тэр багшийн суралцагчийн төлөөлөл 1 байдаг. Төгсөгчийн төлөөлөл 3 байдаг нь яагаад ялгамжтай болчихсон юм? Үүсгэн байгуулагчийн төлөөлөл нь 8 гээд.

Үүсгэн байгуулагчийн төлөөлөл чинь 15-ын чинь 8 гэдэг чинь тэгээд 50 хувь нь.

Тэгээд дандаа л үүсгэн байгуулагчийн тал л асуудлыг шийдээд байна. Нөгөөдүүл нь нөгөө “түзээнд наалдсан дэлүү” гэдэг шиг л нэр төдий л Удирдах зөвлөлийн гишүүн гээд чирэгдээд л явдаг иймэрхүү юм руу явах нь байна шүү дээ.

Ер нь Удирдах зөвлөлүүдийн зарчим чинь талуудын төлөөлөл тэнцүү байх л зарчим баримталдаг.

Салбар дундын удирдах зөвлөл байж болно гэдэг нь ямар агуулгаар ороод ирчихсэн юм бол доо. Би үүнийг анзаараагүй юм.

Салбар дундын төлөөлөл гээд байгаа. Салбар дундын удирдах зөвлөл байгуулж болох юм шиг. Салбар дундын удирдах зөвлөл байгуулбал Засгийн газар дүрмийг нь батална гээд. Тэр “салбар дундын удирдах зөвлөл” гэж юуг хэлж байгаа юм? Нөгөө нэг салбар хоорондын асуудлыг ярьж байгаа юм болов уу, яаж байгаа юм бол?

**Л.Мөнхбаатар:** Асуулт байхгүй. Яах юм? Л.Энх-Амгалан сайд үг аваад хэлэх юм уу? Л.Энх-Амгалан сайд үг хэлье.

**Л.Энх-Амгалан:** Тэгэхээр С.Чинзориг гишүүн ээ, энэ Удирдах зөвлөл чинь өөрөө төрийн өмчийн сургуулиудын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн бас нэг өөр.

Энэ хууль чинь өөрөө дан ганц төрийн өмчийн их, дээд сургуулиудыг зохицуулж байгаа хууль биш. Төрийн бус, хувийн их, дээд сургуулиудын Удирдах зөвлөлүүд ч гэсэн бас иймэрхүү

хэлбэрээр зохион байгуулагдана гэж байгаа учраас.

Төрийн өмч, өмчлөгч юм байхаас шалтгаалж тэр харьцаан дээр нь тиймэрхүү юмнууд байгаа байх. Энэ чинь нэлээн ярьж байж хийсэн л харьцаа байгаа юм. Тэр оролцоо нэгдүгээрт бүрэн хангагдаж байгаа.

Хоёрдугаар асуудал. Энэ “дундын удирдах зөвлөл” гэж одоо байгуулагдчихсан шүү дээ. С.Чинзориг гишүүн ээ.

Төрийн өмчийн 6 их сургууль чинь Засгийн газраар сая “дундын удирдах зөвлөл”-өө байгуулчихсан. Ер нь цаашдаа ч гэсэн их, дээд сургуулиуд бас ийм “дундын удирдах зөвлөл”-тэй байх нь их зөв юм байна гэж харж байгаа юм. Тийм.

**Л.Мөнхбаатар:** Санал хураалтаа явуулъя.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын “журмын дагуу” гэсний дараа “төрөөс хараат бусаар” гэж нэмж, 26.1.10 дахь заалт, 26.3, 26.4 дэх хэсгийг төслөөс хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

57.5 хувиар санал дэмжигдлээ.

28.Төсөлд доор дурдсан агуулгатай 27 дугаар зүйл нэмэх:

“27 дугаар зүйл.Эрдмийн зөвлөл

27.1.Эрдмийн зөвлөл нь 21-ээс доошгүй гишүүнээс бүрдэх бөгөөд гишүүнээр эрдмийн зэрэг, цолтой багшийг үндсэн орон тооны нийт багш нарын төлөөллөөс сонгоно.

27.2.Эрдмийн зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.2.1.сургалт, судалгааны чиглэлийг тогтоох, хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, дүгнэлт гаргах;

27.2.2.дэд профессор, профессор, хүндэт цол олгох;

27.2.3.судалгааны төсөл болон ахисан түвшний сургалт судалгааны үр дүнг хэлэлцэх, дүгнэх;

27.3.Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдох бусад харилцааг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

27.4.Эрдмийн зөвлөл нь сургалт, эрдэм шинжилгээний бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 27.4 дэх хэсгийн “цагдаа, аюулгүй байдлын” гэснийг “цагдаагийн” гэж, “хууль тогтоомжид” гэснийг “хуульд” гэж өөрчилж, мөн хэсгийн “тус тус” гэснийг хасаж, мөн зүйлийн 27.2, 27.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 27.7 дахь хэсэг нэмэх:

“27.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага нь дээд сургууль, коллежид захирал /цаашид “захирал” гэх/, их сургуульд ректор /цаашид “ректор” гэх/ байна.

27.7.Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

65.0 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 28.1.9 дэх заалтын “бусад харилцааг” гэсний дараа “сургуулийн” гэж нэмэх.

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

62.5 хувиар санал дэмжигдлээ.

31.29.1.1 дэх заалтын “төрөөс болон удирдах зөвлөлөөс” гэснийг “эрх бүхий этгээдийн” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 29.2 дахь хэсэг нэмэх:

“29.2.Дээд боловсролын сургалтын байгууллага доор дурдсан хамтын ажиллагааг бэхжүүлэх үүрэгтэй:

29.2.1.олон улсад өрсөлдөх чадвартай багшлах хүний нөөцийг бэлтгэх, дэмжих;

29.2.2.онцгой авьяастай суралцагчийг дэмжих, авьяасыг хөгжүүлэх хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх;

29.2.3.дээд боловсролын сургалтын байгууллага хооронд харилцан тохиролцсон бусад хэлбэр.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар санал дэмжигдлээ.

32.Төслийн 30.1 дэх хэсгийн “байгууллагын санхүүжилт нь” гэсний дараа “Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, 30.1.2 дахь заалтын “олон улсын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “сангуудаас татах” гэснийг “сангаас олгох” гэж өөрчилж, мөн заалтын “албан ёсны зээл” гэснийг хасаж, 30.1.4 дэх заалтын “их, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж, “компаниас орох” гэснийг “компанийн үйл ажиллагаанаас орсон” гэж өөрчилж, 30.1.7 дахь заалтын “олсон орлого” гэсний дараа “, гэрээт ажил, үйлчилгээ, түрээс, аж ахуйн үйл ажиллагаанаас орсон орлого” гэж нэмж, 30.1.5, 30.1.6, 30.1.8 дахь заалт, 30.5 дахь хэсгийг төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 30.1.10-30.1.15 дахь заалт, 30.6-30.10 дахь хэсэг нэмж, төслийн 30.2, 30.3 дахь хэсгийг нэгтгэн 30.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30.1.10.хүүгийн орлого;

30.1.11.байгууллагын болон судалгааны грант;

30.1.12.өрсөлдөөнт төсөл;

30.1.13.их сургуулийн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс олгосон орлого;

30.1.14.хөрөнгө оруулалтын зээл;

30.1.15.орон нутгийн төсвийн дэмжлэг.

30.2.Дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс дараах дэмжлэг үзүүлнэ:

30.2.1.тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагчид олгох сургалт, судалгааны тэтгэлэг;

30.2.2.улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдол бүхий Засгийн газрын захиалгат судалгаа шинжилгээ, дэвшилтэт технологи дамжуулалт болон инновацын үйл ажиллагааны зардал;

30.2.3.төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардал;

30.4.Энэ хуулийн 30.1.1-30.1.15-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогыг захиран зарцуулах журмыг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл батална.”

30.6.Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.7.Энэ хуулийн 5.8-д заасан дээд боловсролын сургалтын байгууллага нь хуулиар зөвшөөрсөн нийтлэг санхүүжилтийн эх үүсвэрээс гадна үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэл, онцлогоос хамаарч улсын төсвийн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэртэй байж болох бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.

30.8.Аймаг, нийслэлийн удирдлага дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид хуульд заасан

санхүүгийн дэмжлэг олгож болох бөгөөд санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээ, олгох нөхцөл, журмыг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтоож, тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

30.9.Энэ хуулийн 30.2-т заасан зардлыг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлнэ.

30.10.Энэ хуулийн 30.2-т заасан зардлыг санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг түдгэлзүүллээ.  
Содномын Чинзориг гишүүн үг хэлье.

**С.Чинзориг:** Энэ 30.1.13 дээр их сургуулийн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс олсон орлогыг гээд “сургуулийн захиран зарцуулах орлого” гээд оруулаад ирж байгаа юм байна.

Хуучин Анагаахын их сургууль эмнэлэггүй байсан юм. Дэргэдээ Монгол, Японы эмнэлэг гээд нэг эмнэлэгтэй болсон юм байна лээ. Тэгээд үүнтэй холбоотойгоор ийм заалтууд орж ирж байгаа юм байна.

Би энэ зарчим нь буруу л гэж бодож байна. Одоо эрүүл мэндийн байгууллагууд чинь Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжилт аваад, тэгээд тэр орлогоо эмнэлэг нь өөрөө захиран зарцуулдаг байх ийм зарчимд шилжээд бид хоёр жил болж байна л даа.

Тэгээд одоо Анагаахын их сургууль энэ эмнэлэгтэй болсон гээд энэ орлогыг нь их сургуулийн олох орлогод

тооцох юм байна. Тэгээд сургууль нь өөрөө захиран зарцуулах юм байна.

30.4 дээр энэ олсон орлогыг 30.1.1-ээс 30.1.15-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогыг дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл шийднэ гээд.

Ингээд эмнэлэг нь энэ гүйцэтгэлийн санхүүжилтээр олсон орлогоо өөрөө захиран зарцуулах эрхгүй. Сургуулийн удирдах зөвлөл нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж, орсон орлогыг нь дээд сургуулийн удирдах зөвлөл нь захиран зарцуулдаг эрхтэй болох юм байна л даа.

Би энэ зарчим нь буруу л гэж бодож байна. Хэдийгээр тэр их сургуулийн харьяа эмнэлэг ч гэсэн өөрөө тэр гүйцэтгэлийнхээ санхүүжилтийг олоод санхүүжилтээ авч байгаа. Өөрөө тэр эмнэлэг нь захиран зарцуулах эрх нь хадгалагдах эрхтэй шүү дээ.

Тэр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авч сургуулийн эмнэлэг гэж санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж орлого олчихоод, тэгээд тэр орлогыг нь эмнэлэг өөрөө захиран зарцуулах эрхгүй, сургуулийнх нь удирдах зөвлөлд захиран зарцуулдаг эрхтэй болох юм байна л даа.

Энэ зарчим нь буруу байна. Энэ орлогыг сургуулийн захиран зарцуулах, орлого олох эх үүсвэрээс нь хасах. Тэгээд тэр 34 дээр байгаа удирдах зөвлөл нь энэ захиран зарцуулах журмыг нь удирдах зөвлөл нь батална гэдэг саналыг би дэмжиж болохгүй л гэж бодож байгаа юм.

Тийм учраас хуралдаан даргалагч үүнийг гүйцээн боловсруулах гэсэн

чиглэл өгөөд дахиж ярьчихсан нь дээр байх.

Тэгэхгүй бол энэ даатгалын сангаас иргэдийн мөнгийг эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байна гэж авчхаад тэгээд тэрийг нь эмнэлэг өөрөө иргэдэд үзүүлж байгаа эмнэлгийн тусламж үйлчилгээгээ боловсронгуй болгох, сайжруулах чиглэлээр захиран зарцуулах эрхгүй. Сургуулийн удирдах зөвлөлд нь захиран зарцуулаад байдаг зарчим байж болохгүй байх.

Би үүнийг дэмжихгүй байна. Гүйцээн боловсруулах чиглэл өгдөг юм уу, яадаг юм. Энэ жаахан эргэлзээтэй асуудал. Даатгалын мөнгө шүү. Даатгалын мөнгөөр санхүүжилт авчхаад, тэгээд сургуулийн удирдах зөвлөлд нь захиран зарцуулдаг байдаг зарчим нь буруу.

Тэгэхээр эмнэлэг өөрөө харин захиран зарцуулах эрхтэй байх чиглэлээр явах нь зүйтэй гэж би тийм байр суурьтай байна.

**Л.Мөнхбаатар:** Одоо яах юм? Энх Л.Энх-Амгалан сайд үг хэлье.

Тэгээд цаашаа явна. Л.Энх-Амгалан.

**Л.Энх-Амгалан:** С.Чинзориг гишүүн ээ, би гайхаад байх юм.

Та Засгийн газрын гишүүн. Тэгээд боловсролын тогтолцооны шинэчлэлийн асуудлаас Та ингээд хойшоо суугаад байдаг нь ямар учиртай юм.

Одоо энэ чинь их сургуулийн эмнэлгийн тогтолцоо гэдэг чинь Монгол Улсад цоо шинэ эмнэлгийн тогтолцоо шүү дээ. Тэгээд тэр эмнэлэг чинь ганцхан даатгалаас орлого олохгүй шүү дээ.

Даатгалаас орлого олохгүй шүү дээ. Тэр чинь олон төрлийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж байж, тэндээс орж байгаа орлого чинь тэр сургалтынхаа байгууллагад зарцуулах эрхтэй юм байгаа биз дээ.

Ер нь та жаахан шинэлэг баймаар байна. С.Чинзориг сайд аа.

Та Японд, Солонгост их сургуулийн эмнэлгийн тогтолцоог та сайн ойлгож байгаа биз дээ. Ер нь одоо ингээд их сургуулийн эмнэлгийн тогтолцоо чинь эрүүл мэндийнхээ салбарын хамгийн чанартай тэр үйлчилгээг л авч явдаг ийм л тогтолцоо юм байна лээ шүү дээ.

Ер нь яваандаа би Нэгдүгээр эмнэлэг, Хоёрдугаар эмнэлэг, Гуравдугаар эмнэлгүүд ч гэсэн их сургуулийн эмнэлгийн тогтолцоо руу орох ёстой гэж ойлгож байгаа.

Энэ чинь ганцхан төрийн өмчтэй сургууль Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн асуудал биш. Хувийн анагаахын чиглэлээр явж байгаа сургуулиуд дэргэдээ эмнэлэгтэй байгаад орлого олоод, орлогоо тэр сургалтынхаа байгууллагын хөгжилд зарцуулах нь яг юу нь буруу болчихоод байгаа юм.

Таны ганцхан Эрүүл мэндийн даатгалын сангаас авч байгаа мөнгө биш шүү дээ, энэ чинь. Биш байхгүй юу. Тийм.

**Л.Мөнхбаатар:** Саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

57.5 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, 31.2, 31.3 дахь хэсгийг



төслөөс хасаж, төсөлд доор дурдсан агуулгатай 31.1.5 дахь заалт нэмэх:

“31.1.5.дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг түдгэлзүүллээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Цэвэгдоржийн Туваан гишүүн үг хэлье.

**Ц.Туваан:** Энэ дээр түрүүний 30.2 дээр дээд боловсролын сургалтын байгууллагууд улсын төсвөөс дараах дэмжлэг үзүүлнэ гээд байгаа юм.

Энэ заалт. Тэгээд дээрээс нь саяын санал хураалгах гэж байгаа 33 дээр, 31.1.5 дээр “дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах” гээд.

Тэгээд ер нь энэ дээр нэг юм хэлчихье. Протоколд ч байна биз.

Дээд боловсролын тогтолцоог шинэ шатанд гаргах гээд энэ хууль оруулж ирж байгааг дэмжиж байгаа.

Тэгэхдээ одоо энэ дээр нэг зүйлийг бас хэлье. Юу гэхээр манайд хэрэгтэй, хэрэггүй мэргэжлээр. Тухайлах юм бол мэдэхгүй. 20, 30 дахин их боловсон хүчин бэлдчихсэн. Нөгөөдүүл нь ажилгүй ийм мэргэжлүүд зөндөө байгаа.

Ингэхэд эсрэгээрээ хөдөө аж ахуйн чиглэлийн боловсон хүчнүүд. Тэр

дотор малын эмч. Тодорхой хэлэхэд малын эмч, зоотехникч, агроном. Ийм хүмүүс чинь одоо бүр тэтгэврийн нас нь тулаад, бүр даваад, одоо бүр ахмад хүмүүс энэ байгууллагыг чинь, энэ мэргэжлийг чинь нуруун дээрээ үүрч явж байна.

Тэгэхээр үүнийг тэр тэргүүлэх зэрэг, эрэлттэй мэргэжлийн чиглэлд бас оруулж өгөөрэй, сайд аа.

Манай энэ салбарт чинь ер нь хөдөө ажиллах хүн байхгүй болчихсон.

Хоёрдугаарт, яах вэ энэ ташрамд хэлэхэд өмнөх нийгмийн үед ч гэсэн хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийн чинь бараг 80 хувийг нь дунд мэргэжилтнүүд эзэлж нуруундаа үүрч явж байсан байна.

Одоо малын бага эмч, дундын зоо, агротехникч гээд энэ хүмүүс.

Тэгэхээр энэ хүмүүсийг бэлдэж байгаа тоо, хэмжээ. Би энэ ажлын хэсгийнхнээс авсан. Хангалтгүй л харагдаж байна лээ.

Монгол Улс хөдөө аж ахуйн орон гэхэд үнэхээр хангалтгүй. Бэлдээд гарсан ажлын байран дээр нь цалин цавуутай холбоотой асуудлууд нь бага байдаг.

Ингээд энэ дээр нь ажлын байр нь цалин багатай холбоотойгоор залуучууд очиж ажилладаггүй.

Тэгээд тэд нарын асуудал нь шийдэгдээгүй гэсэн ийм байдлуудаас болоод энэ голлох эдийн засгийн хоёр дахь салбар чинь мэргэжлийн боловсон хүчингүй болчихсон шүү. Манай яамныхан, ажлын хэсгийнхэн үүнийг дараа нь анхаараарай.

Тэгээд одоо яах юм. Энэ тэгтгэврийн хүмүүс нэлээн нас нь ахиад ирэхэд ажлын чадваргүй.

Тэгээд төр засгаас мянган сайн бодлого, малын эрүүл мэнд, үржил селекц, газар тариалантай холбоотой сайн бодлого явуулаад үүнийг чинь анхан шат дээр хэн хэрэгжүүлэх юм.

Тэгэхээр энэ талаар би маш олон саналуудыг хэлсэн. Энэ мэргэжлүүдийг Боловсролын зээлийн санд оруулж өгөөч.

Тэр хуучин багш нарын гэр бүлээс нэг хүүхдийг багшаар сургавал нэгийг нь сургалтын төлбөрийг нь даадаг байсан тогтолцоо байхгүй болчихсон.

Үүн шиг одоо бид яг малын эмч хүмүүсийн гэр бүлээс үр хүүхэд нь ойрхон өссөн ойлгодгоороо малын эмчээр сурах юм бол энэ мэргэжлийг нь Боловсролын зээлийн сангаас.

Тухайлбал, саяын хэлсэн тэргүүлэх эрэлтэй мэргэжилтэн оруулж ингэж бодлогоор авч явахгүй бол манайд бодлогогүй, яг дур дураараа жоохон залалт, зохицуулалт хийж өгөхгүйгээс болоод энэ салбар яг эзэнгүй боллоо.

Одоо бид хүнсээ хангана, хөдөө аж ахуйгаа хөгжүүлнэ гэж ярьж байгаа бол, тэгээд дээр нь Монгол төр байгаа юм бол, салбарын яам байгаа юм бол, хуулиа шинэчилж баталж байгаа бол энэ бодлогыг анхаарч өгөөрэй гэдгийг бас энэ ажлын хэсгийнхэнд хэлж протоколд үлдээе.

**Л.Мөнхбаатар:** Санал хураалтаа явуулъя. Цаашаа. Саналын томьёоллыг

уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

65.0 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 33 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.0 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг агуулгын хувьд эрэмбэлэн, үг, найруулгыг жигдлэх, хууль зүйн техникийн болон бусад засварыг хийх.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

57.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёолоор санал хурааж дууслаа. /алх цохив/

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн төсөл болон Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлээ.

Дараагийнхаа асуудалд орёе.

**Долоо.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн  
Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн  
шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн  
хуулийн төслүүд**

*/Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

**Б.Жаргалмаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг

явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу зүйл бүрээр нь хэлэлцэн, дараах санал, дүгнэлт гаргасныг Та бүхэндээ танилцуулж байна. Үүнд:

1.Сургалтын байгууллагын бие даасан байдлыг хангаж, дэргэдээ гарааны компани байгуулах, үр дүнд суурилсан удирдлага, санхүүжилтийн шинэ тогтолцоог нэвтрүүлэх, мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан нэг суралцагчид ногдох хувьсах зардлаар санхүүжүүлэх.

2.Багш хүний нөөцийн цацралтгүй хөгжлийг дэмжих, багш бэлтгэх тогтолцоо бүрдүүлэх, мэргэжлийн багш жил бүр аж ахуйн нэгж, байгууллагад дадлага хийж ур чадвараа дээшлүүлэх, өөрийн судалгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний үр дүнд бий болсон бүтээл, бүтээгдэхүүний орлогоос хувь ногдол, ашиг хүртэх.

3.Бүс, орон нутгийн хөгжлийн төлөвлөлт, эдийн засгийн бүтэц, үйлдвэржилт, онцлог зэрэгтэй уялдуулан сургалтын байгууллагыг төрөлжүүлэн хөгжүүлэх.

4.Иргэн гадаад, дотоодын сургалт, үйлдвэрлэл, амьдралын орчноос олж авсан мэдлэг, ур чадвараа үнэлүүлж зохих түвшний чадамжийн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх, диплом авч хөдөлмөр эрхлэх боломжийг өргөжүүлэх.

5.Ажлын байр, үйлдвэрлэлийн орчин болон сургалтын байгууллагыг түшиглэн хосмог, уян хатан, нээлттэй сургалтын тогтолцоог бүрдүүлэх.

6.Хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын оролцоог нэмэгдүүлж, түншлэлд суурилсан тогтолцоог бүрдүүлэхээр зохицууллаа.

Хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс гарсан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж Байнгын хорооны гишүүдийн олонх нь дэмжлээ.

Төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт болон санал гараагүй болно.

Мэргэжлийн болон техникийн нийтийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэндээ хүргэсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Б.Жаргалмаа гишүүнд баярлалаа.

Ажлын хэсэг бол өмнөх хуулийн ажлын хэсэг хэвээрээ байгаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? М.Оюунчимэг, Ж.Чинбүрэн гишүүнээр тасаллаа.

Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн асуултаа асууя.

**Д.Тогтохсүрэн:** Мэргэжлийн боловсролын хуульд би хоёр зүйлийг тодруулья гэж бодоод байгаа юм.

Хэлэлцэх эсэхийг ярих үед нь би бас санал хэлсэн. Тэгээд тэр санал тусаж уу, үгүй юу гэж би асуух гээд байгаа юм.

Мэргэжлийн боловсролд хийх бид нарын хамгийн том шинэчлэл бол хөдөлмөрийн зах зээлтэйгээ холбож өгөх асуудал байгаа юм. Ажил олгогчтойгоо холбож өгөх асуудал байгаа юм.

Танхимын сургалт, үйлдвэрлэлийн сургалт хоёрыг хамтатган явуулдаг систем рүү оруулах ёстой байгаа юм. Өнөөгийнх шиг нэг тэтгэмжийн хэдэн төгрөгт нь болж явдаг системээ бүрэн халах ёстой байгаа юм.

Өнөөдөр манай эдийн засгийн салбаруудад хамгийн тулгамдаж байгаа юм бол ажиллах хүчний асуудал байгаа. Тэр дотроо мэргэжилтэй ажиллах хүчний асуудал байгаа.

Дээд боловсрол эзэмшсэн ажилгүйчүүд өнөөдөр дүүрэн байгаа. Монгол даяараа байгаа. Мэргэжлийн ажил чинь олдохоо больчихсон байгаа.

Тийм учраас энэ мэргэжлийн боловсролын хууль дээр бид зарчмын

маш том шинэчлэл хийх ёстой гэж бодож байгаа. Тэгэхийн тулд нэгдүгээрт би тогтолцоон дээр нь санал хэлсэн юм.

Энэ мэргэжлийн боловсролыг бэлтгэхдээ нэгдүгээрт би аймаг, нийслэл буюу засаг захиргааны нэгжээ дагасан тэдний хөдөлмөрийн зах зээлд тулгуурласан нэг тогтолцоо байх ёстой гэж бодож байгаа. Сургалтын тогтолцоо нь.

Хоёр дахь нь, мэргэжлийн холбоодыг дагасан тогтолцоо байх ёстой. Жишээ нь, Тариаланчдын холбооны МСҮТ<sub>[мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв]</sub> ч юм уу. Хөнгөн үйлдвэрийнхний МСҮТ хэд байдаг юм. Улсын хэмжээнд ч юм уу. Уул уурхайн үйлдвэрлэлийнхний МСҮТ хэд байдаг юм гээд ингээд үүнийг дагасан тогтолцоо байх ёстой гэж бодож байгаа. Үүнийг яг энэ хуульд яаж тусгасан бэ? Ажлын хэсэг.

Хоёр. Энэ МСҮТ-д суралцагчдын хувьд хугацааны асуудал байгаа юм. Суралцах хугацааны асуудал. Үүний 50-иас доошгүй хувь нь би үйлдвэрлэлийн дадлага байх ёстой гэж боддог юм. Энэ чинь үйлдвэрлэлдээ суралцдаг ажил болохоос, танхимд суралцдагаас илүү үйлдвэрлэлдээ суралцдаг ажил байхгүй юу.

Тийм учраас нийт суралцагчдын хугацаа ямар байгаа вэ? Тэр дотроо үйлдвэрлэлийн дадлагын хугацаа нь ямар байгаа вэ? Тэр нь ямар ямар хугацаатай байх вэ?

Би бүр тэгж боддог байхгүй юу. 3 сар танхим хийгээд л, 3 сар үйлдвэрлэлд явах ёстой. Ингэж байж л энэ өөрөө жинхэнэ бид мэргэжлийн ажилчдыг бэлтгэнэ.

Гурав дахь юм нь, ажил олгогчдын захиалгаар хийж байгааг яаж хийх вэ гэдэг ийм гурван зүйлийг би ажлын хэсгээс асууя гэж бодож байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням хариулъя. Ажлын хэсэг нэмж хариулж болно.

**Г.Дамдинням:** Д.Тогтохсүрэн дарга мэргэжлийн боловсрол дээр энэ хуулийн төсөл эхэлснээс нь хойш ерөөсөө яг л үүнийг л яриад байгаа л даа.

Тэгээд энэ үндсэндээ дэлхийд байдаг ерөөсөө хамгийн оновчтой загвар нь энэ юм билээ. Герман, Австрали, Канад гээд орнуудад байдаг хамгийн зөв зарчим бол энэ юм билээ.

Ажлын байрны чиг баримжаатай мэргэжлийн боловсролыг л бид хийх зорилгоор хийсэн.

Хамгийн нэгдүгээрт Д.Тогтохсүрэн даргын тэр сургалтын хугацаатай холбоотой асуудал дээр. Өөрөөр хэлбэл дадлагын хугацаа хэр юм, танхимын сургалт хэр юм гэдэг дээр 30, 70-ын харьцаатайгаар бид хууль дээр тусгаж өгсөн.

30 хувь танхим, 70 хувь дадлагын баазтай.

Хоёрдугаарт, таны асуултад хариулахад аж ахуйн нэгжүүдийн эрх үүрэгтэй холбоотой асуудлуудыг зааж өгсөн. Энд захиалгын ангиуд байж болно.

Тэгээд ер нь бид яг энэ ажил олгогчдын оролцоог төлөөлөн удирдах зөвлөл болон мэргэжлийн зэрэг, цол олгох, шалгалт авах. Өөрөөр хэлбэл энэ

процессынхоо эхлэл, төгсгөл хоёрт нь маш сайн тодорхой тавьж өгсөн. Өөрөөр хэлбэл аль мэргэжлээр сургах юм, хэн ажилд авах юм, хэн дадлага хийлгэх юм, ямар цалин төлөх юм гэдгийг таны хэлээд байгаа зарчмаар бид суулгаж өгсөн байгаа.

**Л.Мөнхбаатар:** Хариулт хангалттай юу? Ажлын хэсэг нэмээд хариулчих. Дэд сайд хариулах уу? 82 дугаар микрофоныг өгье.

**Г.Ганбаяр:** Д.Тогтохсүрэн гишүүний асуултад хариулья.

Таны хэлж байгаа шиг түншлэлд суурилсан аж ахуйн нэгжийн оролцоог хангасан захиалгат болоод сургалтын хөтөлбөр агуулгад нь хүртэл тэд нарыг оролцуулсан оролцоог нь хангасан ийм зохицуулалтыг энэ хууль дээр ер нь түлхүү оруулж өгсөн ийм байдалтай хуулийн төсөл орж ирж байгаа.

Мэргэжлийн холбоод байгаа. Түншлэл гэдэг дотор мэргэжлийн холбоод нь ч орж байгаа, аж ахуйн нэгж, байгууллагууд нь ч орж байгаа. Холбоодуудыг бүгдийг нь бид хамруулахаар тооцож байгаа.

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

**М.Оюунчимэг:** Сая Д.Тогтохсүрэн гишүүний асууж байгаа асуулт өөрөө маш чухал асуулт.

Ер нь өнөөдөр манай Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл бараг унтамхай байдалтай явж ирж байна. Бид мэднэ. Жишээлбэл, 2008-2012 онд гээд үзэхэд хөдөлмөрийн зах зээл үнэхээр ингээд ёстой яралзана гэдэг шиг л байж байсан. Өнөөдөр ингээд бүр унтам болчихсон.

Би 2020 онд Нийгмийн бодлогын байнгын хорооны даргын томилогдсоныхоо дараахан бүх МСҮТ-ийн захирлуудыг хөдөө орон нутаг, дээрээс нь аж ахуй эрхлэгчид, ажил олгогчдыг бүгдийг нь уриад том уулзалт зохион байгуулахад хоорондын уялдаа холбоо бараг байхгүй.

Тэгээд 33 мянган ажлын байрны захиалга дараа нь өгч байсан. Яг энэ хөдөлмөрийн зах зээл дээр хэрэгцээтэй ийм ийм гээд. Тэгээд тэр мэдээллүүдийг нь тухайн коллеж нөгөө комууд руу нь явуулсан. Тэгээд тэр нь эргээд яасан нь мэдээллээ өгнө гээд тэгээд л нөгөө Боловсролын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хоорондын уялдаа холбоо байхгүйгээс тэгээд энэ ингээд л мэдээлэлгүй орхигдчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид бүгд мэдэж байгаа. Өнөөдөр Герман, Монголын технологийн дээд сургууль гээд техникийн дээд сургууль ямар мундаг сургууль байна. Тийм ээ. Тэр нь сургалт, дадлага, үйлдвэрлэл зэрэг явчихдаг.

Тэрийг төгссөн гэсэн хүүхэд бүхэн бараг ажлын байртай болж байна. Бараг захиалгаар тэр Герман, Монголын технологийн дээд төгссөн бол манайх ажилд авна гээд булаацалдаж байна л даа.

Яг үүн шиг мэргэжилийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг том том компаниудтай уяж өгөөд шууд үйлдвэрлэл, дадлага руу явуулчихдаг байсан л даа.

Одоо энэ дээр 9 жил байдгийг шууд 12 жил буюу ерөнхий боловсролын сургуулийн хүүхэдтэй яг адилхан 12 дугаар анги төгсөх жил.

Уг нь бид бас өмнө нь МСҮТ-ийн хууль орж ирж байхад маргалдаад, жишээ нь мундаг гагнуурчин болох хүүхдэд 9, 10, 11, 12 дугаар ангидаа хайран хоёр, гурван жил тэр физик, математик ч гэдэг юм уу, эсвэл тийм юм үзээд цаг үрээд яах юм бэ. Яг өөрийнхөө сонирхож байгаа чиглэлээрээ нарийсаад дадлагажаад, энэ чиглэлээрээ явсан нь тэр хүний ч амьдралд хэрэгтэй, улс орны эдийн засагт ч хэрэгтэй, хөдөлмөрийн зах зээлд ч хэрэгтэй гээд бид ярьж байсан.

Одоо тэгээд энэ хуулиар 9 жилийг 12 жил болгоод ороод ирчхэж байгаа юм байна л даа.

Тэгээд яг саяын хэлээд байгаа. Бид энэ мэргэжилийн сургалт, үйлдвэрлэлийн төв буюу ажиллах хүчин бэлтгэх маш том дэд бүтэц, баазыг заавал ингэж ерөнхий боловсролын сургалтын системтэй шиг ингэж ижил явуулаад байх шаардлага байна уу? Л.Энх-Амгалан сайд аа.

Та өөрөө сая Германд очсон. Бид ажлын шугамаар явсан. Ер нь технологийн сургууль, МСҮТ гэдэг нь хамгийн чухал. Тэгээд үүнийг төгсгөчихсөн хүмүүс нь илүү их ажлын байртай болдог, энд илүү их ач холбогдлоо өгдөг байгаад байна шүү дээ.

Харин их дээд сургуульд тэр сургууль төгсөгчдийн бараг 5, 6-хан хувь нь ороод, ихэнх энэ мэргэжилийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд шиг ийм сургалт, үйлдвэрлэл рүү орчхож байна шүү дээ.

Тэр нь өөрөө өндөр цалин авч байна, хөдөлмөрийн зах зээл рүү орж байна.

Манайх эсрэгээрээ одоо өнөөдөр их, дээд сургуулиудыг нөгөө борооны дараах мөөг шиг олширчихсон гээд. Сая

цэгцэлж эхэлсэн тухай Та түрүүний хуулийн хэлэлцүүлгийн үеэр ярьж байна. Энэ бол сайн.

Одоо харин мэргэжилийн сургалт, үйлдвэрлэлийн энэ төвүүдийг жинхэнэ утгаар нь хөгжүүлээд хуулиа яг үүн шиг боловсронгуй болгоод явчихвал зүгээр байна.

Бид энэ дээр маш олон жил ярьж байгаа шүү дээ. Одоо жишээ нь, тэр 8 дугаар ангиа төгссөөд, ТМС, дээр үед Герман, Чех, Оросын Холбооны Улс гээд л явдаг байсан гэсэн.

Тэр хүмүүс маань ирээд жинхэнэ бүтээн байгуулалт хийсэн шүү дээ.

Тэгэхэд тэд балчирдаагүй, нас нь бага байна гээд асуудал үүсгээгүй. Харин ч хөдөлмөрийн зах зээлийг жинхэнэ хөдөлгөж байсан.

Одоо тэгтэл хөдөлмөрлөх хүн байхгүй болчихсон. Ихэнх нь их дээд сургууль төгссөн гэсэн дипломтой. Ажиллах яг тэр захиалгаар хүмүүс бэлтгэгдэх газаргүй болчихоод байна л даа.

Герман, Монголын политехникийн дээд сургууль, Өмнөговийн тэр сувилагчийн сургууль, Хөвсгөл аймагт байгаа МСҮТ тэр аягүй сайн ажиллаж байна шүү дээ. Дарханых. Үнэхээр сонгодог утгаараа ажиллаж байна. Гэхдээ тэнд элсэлт нь бага авдаг. Ийм маягаар л МСҮТ-үүдийг үнэхээр хөхиүлэн дэмжээд. Ёстой нөгөө татаасаар ч дэмжээд, тэнд суралцагчдыг нь ч гэсэн бид өмнө нь 200 мянга гээд л байсан даа.

**Г.Занданшатар:** Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан хариулна.

**Л.Энх-Амгалан:** М.Оюунчимэг гишүүн ээ, таны ярьж гол тогтолцооны шинэчлэл яг энэ хуулиар л хийгдэх гэж байна л даа. Тийм ээ.

Тэгээд цөмөөрөө **“ажиллах боловсон хүчин”** гэдэг хуучинсаг ойлголтоосоо салмаар байгаа юм.

Ерөөсөө мэргэжлийн боловсрол, дээд боловсрол чинь “ажиллах боловсон хүчин” бэлдэхгүй байхгүй юу. Ер нь аль ч улс оронд “ажиллах боловсон хүчин” гэдгийг ярихаа больсон. Энэ их хуучирсан ойлголт шүү дээ.

Өнөөдөр тухайн улс оронд бид мэдлэг, ур чадвар, төлөвшил бүхий бүтээлч иргэдийг л бий болгох тогтолцоо нь өөрөө энэ **“мэргэжлийн боловсролын тогтолцоо”** байх ёстой байхгүй юу.

Тэр тусмаа өнөөдрийн **“Аж үйлдвэрийн IV хувьсгал”**, одоо энэ альфа үеийн хүүхдүүдийг бид аль болохоор тэр 12 жилийнх нь тогтолцоогоор нь, бүтнээр нь авч явах. Энэ чинь бүр тийм том тогтолцооны шинэчлэл байгаа юм. М.Оюунчимэг гишүүн ээ.

Тэгэхээр, бид ерөөсөө шууд 9 дүгээр ангиар нь төгсгөөд л 10 дугаар анги руу нь хөдөлмөрийн зах зээл рүү нийлүүлээд байна гэдэг ойлголт маш хуучирсан ойлголт. Маш хуучирсан тогтолцоо.

Өнөөдөр асуудал юундаа байна вэ гэхээр манай МСҮТ төгссөн хүүхдүүд, дээд боловсрол төгссөн хүүхдүүд ур чадварын хомсдол, ур чадварын эрэлт, нийлүүлэлтээ давж гарч чадахаа больчихсон байгаа байхгүй юу.

Одоо энэ дээр **“Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа”** гээд жил бүхэн гардаг

тойм байгаа. Энэ судалгаан дээр яг ажил олгогч нараас хүсэж байгаа тэр ур чадваруудыг ерөөсөө энэ техникийн боловсрол, дээд боловсрол чинь ерөөсөө олгож чадахгүй байна. Олгож чадахгүй байна.

Манайх чинь их сонин болчихсон шүү дээ. Нэг талдаа 70, 80 мянган хүн ажилгүй гэж байгаа мөртлөө нөгөө талдаа 30, 40 мянган ажлын байрны хомсдол бий болчихсон. Хомсдол бий болчихсон.

Гэтэл тэнд яагаад хүмүүс очиж ажиллахгүй байгаа юм гэхээр ажлын үнэлэмжийн асуудлуудаа бид ер нь монгол хүний нэг цагт ямар бүтээмжтэй, ямар үнэлгээтэй чадварлаг иргэдийг бэлдэх ёстой юм бэ гэдэг дээрээ л бид яримаар юм билээ.

Одоо жишээ нь, Ноос, ноолуурын холбоо юу билээ 3 мянган хүний ажлын байрны захиалга өгч байна гэж байна. Ноос, ноолуурын холбоо.

Тэгэхээр тэр ажлын байрных нь цалин нь өөрөө 600-хан мянган төгрөг, 700-хан мянган төгрөгийн цалинтай ажлын байр санал болгохоор өнөөдөр ямар хүн тэнд очиж ажиллах вэ.

Тэгэхээр одоо бид цаашдаа мэргэжлийн боловсролын тогтолцоон дээр мэргэжлийн хөтөлбөр бүхэн өөрийнхөө өртөгтэй байя.

Гагнуурчныг өөр өртгөөр бэлддэг. Тийм ээ. Одоо юу гэдэг юм, мэргэжлийн тогоочийн хөтөлбөрийнх нь өртөг нь өөр өртөг байдаг. Илүү **“энтрепренёр”** чиглэлээр өөрөө ажлын байраа бий болгох. Тийм ээ. Өөрөө бүтээмж.

Одоо бид нар бүтээмжийн асуудал ярих ёстой байхгүй юу. Тийм ээ. Бүтээмжтэй иргэдийг бэлдэх тогтолцоо



чинь **“хосмог сургалтын тогтолцоо”** гэж бид тайлбарлаад байна шүү дээ. Тийм ээ. Дадлагаараа, онолоороо хосмог явж байдаг.

Тэгээд хүүхэд ирээдүйн ажлын байраа өөрөө бий болгодог. Тэр ажлын байран дээр ажил олгогчтойгоо яг эзэн, боолын харьцаагаар биш эрх тэгш харьцаагаар суралцаж явах нэг ийм тогтолцоо руу л бид хийх гээд байна.

Санхүүжилтээр нь, засаглалаар нь, хөтөлбөрөөр нь.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Л.Энх-Амгалан сайд өөрөө хоцрогдчихсон байна шүү дээ. Боловсролын сайд.

Үг дээр тоглолт хийгээд л. Та хүн болгоны асуулт асуухад л бүгдийг нь хоцрогдсон гээд л. **“Боловсон хүчин”**, **“хүний нөөц”**, **“бүтээлч иргэн”** гурвын ялгааг нь маш сайн бид мэднэ.

“Боловсон хүчин” гэдэг ганц үг хэлснээс болж Та хүмүүс хоцрогдсон гэнэ. Үг дээр тоглож болохгүй шүү дээ. Та ч гэсэн боловсон хүчний нөөцгүй болчихоод байна гээд дөнгөж сая 70 мянга, 80 мянга гээд л ярьж байна. Тэгвэл та өөрөө бас хоцрогдчихсон юм байна шүү дээ.

Би бол мэргэжилийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг хөдөлмөрийн зах зээлд **“бүтээлч иргэд”** болгох. Тэр нь өөрөө үнэлэгддэг байх. Та сая үнэлэмжийн тухай ярьж байна.

Сая Холбооны Бүгд Найрамдах Герман Улс үүгээрээ маш үлгэр жишээ. Хэлж байна шүү дээ. Хөдөлмөрийн зах зээлийг эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр

сургах, тэр хүн нь өөрөө хөдөлмөрийн үнэлэмжтэй байхад энэ МСҮТ буюу мэргэжилийн сургалт, үйлдвэрлэл, техникийн сургуулиуд асар өндөр ач холбогдолтой. Энэ өөрөө танай хүний нөөцийг чинь бэлдэнэ. Хүний нөөц буюу таны яриад байгаа тэр хоцрогдсон боловсон хүчнийг чинь бэлдэнэ гэж ярьж байна л даа.

Тэгэхээр 12 дугаар анги хүртлээ суучихсан байх.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Санал хэллээ. Яах вэ, би гүйцээгээд л өгчихье.

Боловсрол, шинжлэх ухааны сайд боловсролтой, шинжлэх ухаанчаар мэтгэлцэнэ шүү.

Хоцрогдсон, хоцрогдсонгүйгээ яриад байх юм бол энэ хэлэлцүүлэг мөд дуусахгүй. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн.

**Ж.Чинбүрэн:** Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн асуудал үнэхээр тулгамдаж байгаа. Тэр дотроо бакалавр зэргээр төгсдөг сувилахуйн мэргэжлийн улсуудтай сая 5 сард бүтэн 21 аймаг, 9 дүүргээр уулзахад гол ярьж байгаа зүйл ажлын ачаалал.

Хуучин ажил хуваарилалтууд, асрагч энэ тэр гэж байхад бас ажлаа хуваарилаад хийдэг байсан. Тэр тогтолцоо. Одоо бүх ачаалал сувилагч нар дээр ирсэн.

Тэгэхээр хуулийн төсөлд **“сувилагчийн туслагч”** гэдэг мэргэжил дээр хэр ахиц гарах бол оо?

Тэгэхээр энэ тал дээр ажлын албанаас ямар дэвшлүүд гарч болох вэ гэдгийг хэлж өгөөч.

Хоёрт, бид “хөдөлгөөн засалч” гээд 4 жилээр бакалавр мэргэжлээр төгсгөдөг. Тэгтэл бас курсээр төгсөж байгаа “бариач”, “массажист” гэдэг ийм мэргэжлүүд байна. Энэ бас их удаан сурдаг.

Тэгэхээр энэ мэргэжлийг ямар хугацаагаар яаж сурах вэ? Энэ дээр бид дэвшил юу гарсан бэ гэдгийг ажлын хэсэг нэг тайлбарлаад өгөхгүй юу гэж хүсэх гэсэн юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсэг. 83.

**А.Халиунаа:** Ж.Чинбүрэн гишүүний асуултад хариулья.

“Туслах сувилагч”-аар нэг жилийн хугацаанд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудаар бэлдэж байгаа.

“Эмчилгээний бариа засалч”-аар мөн адил нэг жилийн хугацаанд сургалтыг бэлдэж сургалт явуулж байгаа.

Нийт эмчилгээний бариа засалчаар өнөөдрийн байдлаар 105 суралцагч сураад төгсөж байна. Туслах сувилагчаар 193 төгсөгч төгсөж байгаа.

Энэ хуулийн шинэчлэлээр бид тэргүүлэх эрэлттэй мэргэжлийн чиглэлд зарим эрүүл мэндийн чиглэлийн мэргэжлүүдийг оруулах төлөвтэй байгаа.

Ингэснээр цаашид элсэлт нэмэгдэнэ гэсэн төлөвлөлттэй байна.

**Г.Занданшатар:** Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн тодруулж асууна.

**Ж.Чинбүрэн:** Би ингэж бодоод байхгүй юу. Жишээлбэл, “туслах сувилагч” нэг жил сураад, ажиллаж

байгаад дараа нь “сувилагч” болъё гэхэд тодорхой сурсан кредит нь тооцогддог байх. Жишээлбэл, “массажист” нь нэг жил сураад төгссөний дараа ажлаа хийж байгаад жинхэнэ нөхөн сэргээх нарийн мэргэжлийн “хөдөлгөөн засалч” болоход түүний сурсан кредитэд тооцогддог байх ийм нөхцөлүүд бүрдэх үү, үгүй юу гэдгийг л сонирхоод байгаа юм. Энд хариулж өгөхгүй юу?

**Г.Занданшатар:** Л.Энх-Амгалан сайд хариулна.

**Л.Энх-Амгалан:** Ж.Чинбүрэн гишүүн ээ, бидний оруулж ирж байгаа энэ шинэчлэлтээр тэргүүлэх эрэлттэй мэргэжлүүдээ илүү зөв тодорхойлдог болох.

Монгол Улсын хөгжил дэвшилд мэдлэг, ур чадвар шаардсан ямар ажлын байрууд дээр ямар улсуудыг бэлдэх вэ гэдэг асуудал дээр тогтолцооны шинэчлэлтийн асуудал хийж байгаа учраас таны нэг сургуулийн нэг мэргэжлийн гэхээсээ бид зарчмыг нь илүү тодорхой болгож байгаа юм.

Түрүүн би тайлбарлаж байсан. Гагнуурчны хөтөлбөр. Яг түүнтэй адилаар сувилагч гэдэг юм уу, эрүүл мэндийн ажилтнуудын туслах ажилтнууд дээр яг тэр мэргэжилд нь яг ямар хөтөлбөрөөр ямар ур чадварууд суулгах ёстой юм бэ. Тэр нь эргээд ажлын байр дээрээ ямар ур чадвар гарч, тэр ажил олгогчийн хүсэж байгаа ур чадвараар төгсөж чадах юм бэ гэдгийг бид илүү мэргэжил, мэргэжлээр нь нэлээн онцлогтой хөтөлбөрийн өртгүүдийг санхүүжилтийн тогтолцоогоор нь хийж.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 82.

**Г.Ганбаяр:** Ж.Чинбүрэн гишүүний асуултад нэмээд хариулахад, яг таны хэлж байгаа санаа энэ хуулийн төсөл дээр туссан байгаа буюу мэргэжлийн боловсрол дээр нэг жилийн бариа засалчаар сурч байгаад, хэрвээ үргэлжлүүлээд сувилагчаар бакалавр авъя гэх юм бол энэ нэг жилийн хугацаанд сурсан кредит оноог нь тооцоод, үргэлжлүүлээд сурах буюу 3 жилээр дүйцүүлээд, 3 жилээр бакалавраа авах тэр бололцоог нь бид МСҮТ-ийн болоод дээдийн хууль дээр хоёулан дээр нь оруулаад дүйцүүлэхээр бид зөвшөөрчхөж байгаа.

Тэгэхээр энэ бол нэлээн тийм шинэлэг ахиц дэвшил авчирна буюу салбар дээр мэргэжилтэй ажилтан очиход энэ нь тоо нэмэгдүүлэхэд нэлээн чухал үүрэгтэй ийм хуулийн заалтууд орж ирж байгаа.

Тэгээд гол нь багц хууль гэдгийн гол давуу тал нь энэ байгаа юм. Бусад салбаруудаа дэмжсэн, уялдуулсан.

**Г.Занданшатар:** Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна.

**Ц.Туваан:** Энэ чухал хууль.

Тэгээд биднийг 10 жил, 8 жилд сурч байхад зарим багш нар тэгж загнаж байдаг байсан. Та нар олигтойхон сурахгүй бол ТМС<sub>[техник мэргэжлийн сургууль]</sub>-Д явуулна шүү гээд.

Тэгээд тэр нь юу гэдэг юм, муу газар муу хүүхэд очдог газар шиг л ийм хандлага байсан.

Тэгээд энэ хандлага одоо ер нь мэдэхгүй. Дээрдсэн юм уу, үгүй юу. Би мэдэхгүй байна.

Манай Төв аймаг дээр гэхэд жишээлбэл Төв аймгийн төв дээр, Эрдэнэ сум дээр, Баянчандмань дээр, Заамар сум дээр 4 МСҮТ, коллеж, политехникийн коллежууд ажиллаж байгаа.

Тэгээд энэ коллежуудаар ороод явахаар яг энэ бодол надад өөрийн эрхгүй бодогддог юм. Бүр нэг хаягдчихсан айлын шоовдор хүүхдүүд шиг. Яам нь ч тоодоггүй. Яам яам дамжуулаад л явж байдаг нэг ийм газар байдаг.

Боловсролын сайд, тэгээд энэ удирдлагууд ер нь хамгийн сүүлд хэзээ Төв аймгийн 4 сургуулиар орсон бэ гэж би асууя.

**Ш.Отгонхүү,** **Д.Болормаа,** **Б.Жаргалмаа,** тэгээд **Э.Амартүвшин** гээд 4 захирал буюу менежер байна л даа. Би эд нарыг ёстой маш сайн ажиллаж байгаа гэж бодож байна.

Өөрсдийнхөө бүх ажлаа мартаад хуруу хумсаа хуйхлаад ингээд ажиллаж байдаг. Дээрээс нь төсөв, санхүү гэж ерөөсөө олигтой юм ярьдаггүй. Техник, тоног төхөөрөмжийг нь 2015 оноос хойш сольж өгсөн юм байхгүй.

Багш нарынх нь нийгмийн асуудал, цалин цавуу нь бас л тэр нэг шоовдорлогдсон байдалтай орхигдоод байдаг энэ асуудлууд байгаа юм.

Тэгээд тэр МСҮТ, политехник, коллежуудаар ороод явж байхад хэдэн асуудлууд ингээд тавиад байгаа юм.

Энэ бие даасан байдалтай үйл ажиллагаа явуулна гэж яриад байгаа. Энэ яг ямар учиртай юм бэ? Ямар ямар боломж олгох юм.

Тэгээд сургалт нь энэ “**төв сургалт**” гээд л нэг сургалт байгаа.

Явуулдаг. Үүнийг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын авна гээд л тэгж байдаг. Эсвэл Боловсролын яамандаа үлдэнэ гээд л.

Ийм асуудлууд яригдаад байх юм. Энэ ямар учиртай юм?

Дээрээс нь дахиад л нөгөө алагчлал. Багш нарын нөгөө тэдэн жил тутамд гээд. Одоо би бас жилийг нь хэлээд яах вэ? Хүмүүс барьцаад унаж магадгүй нэг нэмэгдлүүд байгаа. Хөдөө орон нутгийн ажилласан.

Үүнийг авдаггүй улсууд байгаа. Үүнийг авдаггүй. Тэр өөр мэргэжил эзэмшсэнээрээ энэ асуудал ингээд орхигдоод байгаа хүмүүсийг яг яаж шийдэж байгаа вэ?

Тэгээд мэргэжлийн сургуулиуд чинь бас ажиллах гээд. Шилдэг менежерүүд байгаа учраас гүйгээд байна. Манай Эрдэнийнхэн бол.

Тэгээд эд нарт энэ хуулийн боломжуудыг нь нээж өгөөч. Ялангуяа бүтээгдэхүүн үйлдвэрлээд янз бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээ санаачилж хийгээд үнийгээ борлуулах боломжуудыг нь нээгээд өгчхөөч ээ. Бид нарыг ер нь жоохон ийм хувийн маягийндуу ийм асуудлуудыг шийдээд өгчхөөч гэж байна. Энэ яг ямар байдалтай байгаа юм?

Цалин цавуу, тэр багш нарын нийгмийн байр савтай асуудал дээр нэг асуудал тавиад өгөөч.

Хоёрдугаарт, энэ дээр ерөөсөө л энэ чинь барьж тогтоож байгаа юм чинь тэр тэтгэлгийн л асуудал шүү дээ.

9 дүгээр анги төгссөн хүүхдүүд 2.5 жил төгсөөд сураад явж байгаа. 5 сая төгрөг авдаг. Насанд хүрсэн хүмүүс 5

сарын нэг сая төгрөгийн тэтгэлэг аваад явдаг.

Энэ дээр ер нь ямар бодлого явж байгаа юм. Үүнийг би цаашаа үргэлжлэх үү, яах вэ гэдэг ийм асуултыг нь асууя.

Санхүүгийн хувьд бол эд нар хөөрхий маш тодорхойгүй орж ирдэг. Тэгээд л нэг тийм дутуу гуцуу, одоо нэг өлөн зэлмүүн гэдэг шиг л амьдарч байдаг. Энэ дээр бас энэ хууль дээр ямар бодлого тавьж өгсөн бэ?

Баруунд чинь бол энэ Сингапур энэ тэр чинь, энэ сургуулийг төгссөн хүмүүс чинь хамгийн түрүүнд ажлын байраар хангагддаг. Том компаниуд нь өөрсөд дээрээ ирээд дадлага хийлгэж байгаад үргэлжлүүлээд ажилтан болгоод аваад явчихдаг юм байна лээ шүү дээ. Ийм бодлого ер нь энэ хууль дотор чинь орсон байгаа юу, үгүй юү гэдгийг асууя.

### **Г.Занданшатар:**

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулъя.

### **Л.Энх-Амгалан:**

Ц.Туваан гишүүн ээ, сурлага муутай хүүхдүүд нь ТМС рүү очдог, эсвэл аав, ээж нь орлого багатай гэдэг юм уу, энэ иргэдийн хүүхдүүд нь энэ ТМС-д ордог гэсэн нэг ийм хуучин ойлголтыг л цөмөөрөө нэг энэ тархи толгойноосоо ер нь нэг авч хаях л ёстой гэж ойлгоод байгаа юм. Тийм ээ.

Одоо явж явж ер нь энэ мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол гэдэг чинь хамгийн нэр хүндтэй боловсрол, хамгийн нэр хүндтэй мэргэжил.

Тэгэхээр би тантай санал нэг байна. Бидний өнөөдрийн эрх зүйн шинэчлэлээр мэргэжлийн боловсролын

байгууллагууд хоорондоо яаж төрөлжих юм. Хажуу талдаа дадлагын баазуудаа яаж байгуулах юм. Орлого олох юм бол тэрийгээ яаж захиран зарцуулах юм гэсэн энэ эдийн засаг, санхүүгийн бие даасан байдлуудыг нь бид одоогийнхоос нээж өгөх. Өөрөө өөрөө хөгжөөд явах ийм бололцоонууд маш их байгаа юм байна лээ шүү дээ. Тийм ээ. МСҮТ-д санхүүгийнх нь эрх чөлөөг нь өгөх юм бол өөрөө өөрсдөө хөгжөөд явчих боломжуудыг бид олгоё гэж байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаар асуудал бол угаасаа энэ бүх юм чинь санхүүжилттэй л холбоотой. Зөв санхүүжилтийн тогтолцоотой л холбоотой.

Тийм учраас нэг хүүхдийг сургаж байгаа МСҮТ-д сургадаг хувьсах зардал нь бараг 2012 оноос хойш хувьсах зардлаа ерөөсөө шинэчлээгүй юм билээ. Ерөөсөө шинэчлэгдээгүй.

Ер нь шинэчлэгдээгүй үлдсэн салбар бол манай энэ мэргэжлийн болон техникийн боловсролын салбар мөнөөсөө мөн. Мөнөөсөө мөн.

Тэгэхээр одоо яг энэ чиглэл рүү бид ерөнхийдөө үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоон дээрээ суурилж илүү их. Би түрүүн тайлбарласан. Энэ хөтөлбөрүүдэд илүү их өртгийг нь зөв тооцсон хөтөлбөрүүдээр хүүхэд сургаж өндөр цалинтай, өөрсдөө маш их бүтээмжтэй ажилладаг ийм сургалтын тогтолцоо руу л бид нэг алхах ёстой. Ганцхан нэг алхаад орхих биш хоёр алхах ёстой л гэж бодоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр би таны яриад байгаа Төв аймгийн. Бид чинь төрийн өмчийн 33 МСҮТ байгаа шүү дээ. Мэргэжлийн

сургалт, үйлдвэрлэлийн сургуулиуд гэсэн үг.

Тэгэхээр эд нарыгаа илүү одоо яг энэ зах зээл, хөдөлмөрийн зах зээлтэй нь уясан, түншлэл дээр нь суурилсан, ажил олгогчидтой нь нэлээн уясан, мэргэжлийн холбоодуудтай нь уясан ийм л тогтолцоо руу л бид явъя л гэж харж л өнөөдрийн энэ эрх зүйн шинэчлэлтийг оруулж ирээд байгаа юм.

**Г.Занданшатар:** Ажлын хэсэг. 82.

**Г.Ганбаяр:** Ц.Туваан гишүүний асуултад тодруулаад нэмэлт өгье.

Тодорхой нийгмийн баталгаатай холбоотой үлдээд байдаг байсан хүмүүсийг энэ хуулиар, одоо энэ зарчмын зөрүүтэй санал дээр уншигдаж, хэрвээ дэмжигдэх юм бол багшаас бусад хүмүүс дээр энэ орон нутгийн нэмэгдлүүд нь олгогдохоор бид энэ хуулийн төсөл дээр оруулж ирсэн байгаа.

Дээрээс нь МСҮТ-ийн томилгоотой холбоотойгоор бид санхүүгийн хагас бие даасан байдлыг нь энэ хуулиар бид олгох эрхийг нь өгөх гэж байгаа.

Хэрвээ гишүүд өнөөдөр Та бүхэн дэмжээд явах юм бол.

Тэгэхээр үндсэндээ МСҮТ бол тэгж юу гэдэг юм муу сурлагатай, сайн муу гэхээсээ илүүтэйгээр илүү баялаг бүтээдэг, баялаг бүтээхэд суралцдаг тийм хүүхдүүдийг төлөвшүүлэх рүү илүү чиглэж байгаа ийм тогтолцооны өөрчлөлтийг хийх гэж байгаа юм. Гишүүн ээ.

**Г.Занданшатар:** Цэвэгдоржийн Туваан гишүүн тодруулья.

**Ц.Туваан:** Би түрүүн өмнөх юун дээр хэлж байсан. Дээд боловсрол дээр ярьж байсан.

Хөдөө аж ахуйн салбарын ачааллыг дунд мэргэжилтнүүд үүрч явж байсан юм билээ гээд.

Тэгэхээр энэ дунд мэргэжилтэй хүмүүсийн талаар цаашаа бодлого нь яаж явах юм бэ? Одоо малын бага эмчийн сургалт улс орон даяар хэдэн хүн сурч байна. Тийм. Зоотехникчээр хэдэн хүн сурч байна? Агротехникчээр хэдэн хүн сурч байна? Хаана хаана сураад байна. Энэ хүмүүс дээр ер нь сураад төгссөн хүмүүс чинь ажлын байраар хангагдаж байгаа юу? Одоо хангагдахад ямар асуудал байна?

Тэгэхээр энэ хүмүүсийг илүү сургаж цааш нь ажлын байраар хангаж энэ мэргэжлийн боловсон хүчинг. Ялангуяа хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин бэлтгэх дээр ямар ахиц гарахаар заалт энэ хуульд орсон бэ? Тэрийг нэг тодруулж хэлж өгөөч.

#### **Г.Занданшатар:**

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Одоо таны тодруулаад байгаа яг энэ улс оронд хэрэгцээтэй байгаа энэ мэргэжилтнүүдийг бид яаж бэлдэх вэ, энэ хүний нөөцөө яаж бэлдэх вэ гэдэг дээр л энэ хууль маань бүтнээрээ ажлын хэсэг ажилласан, Засгийн газраас өргөн барьсан. Энэ дээр бүтнээрээ гарах юм бол энэ рүү л нэлээн тогтолцооны томоохон өөрчлөлтүүд гарч ирнэ.

Тэр тусмаа хөдөө аж ахуйн салбарт өнөөдөр эрэлттэй байгаа энэ мэргэжлүүдээр яг яаж сургах юм. Энэ хөтөлбөрөө бид яаж шинэчлэх юм.

Шинэчилсэн хөтөлбөр нь өртөгт яаж суурилах юм. Яг тэр өртөгт тооцсон хөтөлбөрөөрөө сурч гарч байгаа хүн маань ажлын байран дээрээ очиж ямар ур чадвартай хүн очих вэ гэдэг дээр л бид энэ өөрчлөлтүүдийг хийгээд байгаа шүү дээ. Ц.Туваан гишүүн ээ. Тийм ээ.

Тэгэхээр одоо яг юу гэдэг юм. Бид энэ сургуулиудаа ч гэсэн нэг жаахан эргэж харахгүй бол нэг аймаг дээр байгаа 2 МСҮТ яг адилхан мэргэжлүүдээр сургаад байдаг.

Одоо жишээ нь, Булган аймаг дээр байгаа 2 МСҮТ яг адилхан. Тэгээд цаана нь 60-хан километр яваад очихоор Эрдэнэт дээр бас нэг хөдөө аж ахуйн МСҮТ гээд. Хоорондоо.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ажлын хэсэг нэг тодорхой тоотой юм хариул. 82.

**Г.Ганбаяр:** Одоогийн байдлаар 168 суралцагч энэ чиглэлээр суралцаж байгаа. Ц.Туваан гишүүн ээ.

Тэгээд ер нь тэргүүлэх мэргэжил дээр газар тариалан, мал аж ахуй, малын гаралтай амьтны түүхий эд судлал, мал эмнэл зүй, ойн аж ахуй, тэжээл, бэлчээр судлал, селекц, үрийн аж ахуй зэрэг гээд энэ хөдөө аж ахуйн чиглэлийн нэлээн нарийвчилсан мэргэжлүүд тэргүүлэх мэргэжлийн жагсаалтад Засгийн газрын тогтоолд ороод ингээд албажчихсан явж байгаа учраас энэ дээр тэтгэлэг болон энэ бусад санхүүгийн харилцааг үүсэхэд нээлттэй болоод эхэлчихэж байгаа.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 5 санал байгаа.

Санал хураалтад бэлдье.  
Гишүүдийг дуудъя. Чуулганы  
танхимуудаа цуглуулаарай.

Мэргэжлийн болон техникийн  
боловсролын сургалтын тухай хуулийн  
ажлын хэсгээс гаргасан зарчмын  
зөрүүтэй саналын томъёоллоор санал  
хураалт явуулна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан,  
спортын байнгын хороо дэмжсэн санал  
байгаа.

Энэ их чухал өөрчлөлтүүд орсон  
юм билээ.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.4  
дэх заалтын “ахисан түвшний  
чадамжийг” гэснийг “чадамжийг” гэж,  
3.1.9 дэх заалтын “богино хугацааны  
сургалтыг” гэснийг “сургалтыг” гэж,  
3.1.11 дэх заалтын “өмнө эзэмшсэн  
мэдлэг” гэснийг “эзэмшсэн мэдлэг, ур  
чадвар” гэж, “мэдлэг, ур чадварыг”  
гэснийг “чадамжийг” гэж өөрчилж, 3.1.12  
дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн  
найруулах:

“3.1.12.“дадлагажуулагч”  
гэж суралцагчийг үйлдвэрлэлийн орчинд  
дагалдуулан сургах, ур чадвар  
эзэмшүүлэх үүрэг бүхий арга зүйн  
сургалтад хамрагдсан ажилтныг.”

Санал гаргасан Улсын Их Хурлын  
гишүүн Г.Дамдинням, Г.Амартүвшин,  
Ё.Баатарбилэг, Э.Батшугар,  
Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Х.Ганхуяг,  
Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил,  
Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг,  
Б.Пүрэвдорж, Ч.Ундрам, С.Чинзориг,  
Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг”  
гэх/

Санал хураалт. /алх цохив/

24 гишүүн дэмжиж, 63.2 хувийн  
саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1  
дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн  
найруулах:

“4.1.Мэргэжлийн болон техникийн  
боловсрол, сургалтын зорилго нь  
нийгмийн хөгжил, эдийн засгийн  
бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах  
зээл, ур чадварын эрэлт, шаардлагад  
нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий  
иргэн бэлтгэж, мэргэшлийн түвшин  
ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг  
хангахад оршино.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

63.2 хувийн саналаар санал  
дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2,  
5.1.3 дахь заалт, 5.1.4 дэх заалтын  
“нийгмийн” гэснийг тус тус төслөөс  
хасаж, доор дурдсан агуулгатай 5.1.5,  
5.1.6 дахь заалт нэмэх:

“5.1.5.хөгжлийн бодлогод  
нийцсэн байх;

5.1.6.хөдөлмөр эрхлэлт, ур  
чадварын хөгжлийг дэмжсэн байх.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

65.8 хувийн саналаар санал  
дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.7  
дахь хэсгийн “6.3,” гэснийг төслөөс  
хасаж, 6.2 дахь хэсгийн “бие даан ажил”  
гэснийг “хувиараа” гэж /цаашид  
тохиолдол бүрд/, 6.5 дахь хэсгийн  
“хэмжих ба багц цагийг дараагийн  
түвшний боловсролд тооцож дүйцүүлнэ”

гэснийг “тооцох бөгөөд дараагийн боловсролын түвшинд дүйцүүлнэ” гэж, 6.6 дахь хэсгийн “багц цаг” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсролын багц цаг” гэж, 6.8 дахь хэсгийн “ажил олгогчийн” гэснийг “түншлэлийн” гэж өөрчилж, 6.14 дэх хэсгийн “тусгай” гэснийг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг.

Байнгын хорооны дарга нь өөрөө үг хэлэх хэрэг байгаа юм уу? Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн үг хэлье.

**Г.Мөнхцэцэг:** Дарга аа, 4 дүгээр зүйл, хэд хэдэн зүйл дээр гүйцээн боловсруулж чиглэл авах гэж байгаа юм.

Хоёр жилийн өмнө өргөн баригдахдаа, ер нь 7 хууль өргөн баригдсан. Нийлээд 4 хууль болсон учраас хоорондын уялдаа холбоос гээд. Дээр нь нэр томъёолол дээр хүртэл нэлээн их өөрчлөлтүүд ороод байгаа учраас зарчмын зөрүүтэй саналууд их олон хураагдаад байгаа юм.

Тэгэхээр зарим нэг яам хоорондын хүртэл эрхлэх асуудлын хүрээнд хүртэл зөрчил үүсчихсэн байгаа. Жишээлбэл, тухайн үед МСҮТ маань өөрөө Нийгмийн хамгааллын яаманд харьяалагдаж байсан. Боловсролын яам руу шилжиж ирснээрээ хууль өргөн баригдахад энэ хооронд сургалтын нэр томъёоноосоо хүртэл ингээд өөрчлөлт орсон юм.

Тэгэхээр түр сургалтын асуудлыг эрхэлж байгаа асуудал нь Нийгмийн хамгааллын яаманд байгаад байдаг. Гэтэл энэ хууль гарснаараа Боловсролын яам руу шилжиж байгаа юм шиг яам хоорондын эрхлэх асуудлын хооронд уялдаа, бас зөрчил үүсээд байгаа учраас

зарим нэг заалтууд дээр гүйцээн боловсруулах чиглэл авмаар байгаа юм.

Жишээлбэл, 4 дээр байгаа, 6 дээр байгаа, 9 дээр байгаа, 17 дээр байгаа, 20 дээр байгаа юм.

Тэгээд энэ зүйл, заалтууд дээр гүйцээн боловсруулах чиглэл өгөөч ээ гэж ийм хүсэлт гаргаж байгаа юм.

**Г.Занданшатар:** Ер нь МСҮТ-ийн хууль, мэргэжлийн боловсрол, техникийн хуулийн боловсруулалт харин ч ажлын хэсэг дээр харьцангуй бас энэ шигтгэсэн хувилбарыг харахад гайгүй л хийгдсэн юм билээ.

Зүгээр яах вэ, энэ ур чадвар, чадамж энэ тэрийг давхцуулаад хоёр өөрөөр бичээд байгаа нь л.

Тэгээд үүнийг тэгээд гүйцээн боловсруулах чиглэл өгье. /алх цохив/

5.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “тавигдах” гэснийг “тавих нийтлэг” гэж өөрчлөх.

Санал гарсан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6-г гүйцээн боловсруулах уу? 6-г гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “түвшинтэй” гэснийг “ангилалтай” гэж, 9.14 дэх хэсгийн “дадлагын баазад” гэснийг “чадамжийн төв, дадлагын баазад” гэж, 9.15 дахь хэсгийн “төв, бааз, аж ахуй” гэснийг “чадамжийн төв, дадлагын бааз, туслах аж ахуй” гэж өөрчилж, 9.12, 9.13 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсан агуулгатай



9.12 дахь хэсэг болгон өөрчлөн найруулж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 9.17 дахь хэсэг нэмэх:

“9.1.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага харьяалалтай чадамжийн төв, салбар дундын дадлагын бааз, гарааны компани, бизнес инкубатор төв, туслах аж ахуйтай байж болно.

9.17.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага дотуур байртай байж болно. Дотуур байранд тавих шаардлагыг стандарт, техникийн зохицуулалтаар тогтооно.

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “чанартай” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 30.1.31-д заасан журмын дагуу гэж, 10.1.3 дахь заалтын “байгууллагаар дамжуулан” гэснийг “энэ хуулийн 9.12-т заасан байгууллагаар дамжуулан” гэж, 10.1.8 дахь заалтын “гэрээ хэлэлцээр байгуулах” гэснийг “хамтран ажиллах” гэж, 10.1.9 дэх заалтын “туслах /дэмжлэг үзүүлэх/” гэснийг “дэмжлэг үзүүлэх” гэж өөрчилж, 10.1.3 дахь заалтын “судалгаа хийх” гэсний дараа “зөвлөн туслах” гэж, 10.1.10 дахь заалтын “хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн” гэсний дараа “байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй” гэж /цаашид тохиолдол бүрд/ нэмж, 10.1.4 дэх заалтыг төслөөс хасаж, 10.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 10.1.12 дахь заалтыг нэмэх:

“10.1.5.эзэмшсэн мэдлэг, ур чадварын үнэлгээг түншлэгч талтай хамтран зохион байгуулах;

10.1.12.түншлэлийг хэрэгжүүлэх.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6, 9 хорийг гүйцээн боловсруулна гэсэн. Тийм ээ. 9 дүгээр заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

10.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3, 12.5, 12.6 дахь хэсгийг төслөөс хасаж доор дурдсан агуулгатай 12.9 дэх хэсэг нэмэх:

“12.9.Дээд боловсролын тухай хуулийн 5.8-д заасан шаталсан сургалттай хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллагын элсэгчид энэ хуулийн 12.1, 12.2 дахь хэсэг хамаарахгүй.

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хөтөлбөрийг эзэмшсэн иргэнд гэснийг “байгууллагыг төгсөгчид” гэж, 13.2 дахь хэсгийн “Иргэний албан бус боловсрол, амьдралын орчинд суралцаж эзэмшсэн чадамжийг” гэснийг “эзэмшсэн мэдлэг, ур чадварыг” гэж, мөн хэсгийн “13.1.1, 13.1.2” гэснийг “13.1” гэж өөрчлөх.

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “5” гэсний “3” гэж, 14.3 дахь хэсгийн “дээд түвшний чадамжтай” гэснийг “өндөр ур чадвартай” гэж, 14.2, 14.3 дахь хэсгийн “багшлах эрхтэй” гэснийг “багшлах эрхийн гэрчилгээтэй” гэж өөрчилж, төсөлд доор дурдсан агуулгатай 14.4 дэх хэсэг нэмэх:

“14.4.Багшийн мэдлэг, ур чадварын үнэлгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, сургалтын байгууллагатай хамтран дөрвөн жил тутам зохион байгуулна.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.1.3 дахь заалт нэмэх:

“16.1.3.мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрын багш, арга зүйч, номын санч, эмч, хоол зүйч, тогооч, сэтгэл зүйч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэнд эхний тав дахь жил болон дараагийн гурав дахь жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа боловсролын сургалтын байгууллагаас олгох.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын “хангагдсан” гэсний дараа “байгаль орчинд ээлтэй, жендерийн мэдрэмжтэй, хүртээмжтэй” гэж, 17.2.1 дэх заалтын “сургалтын байгууллагын” гэсний өмнө “үйлдвэрлэлийн болон” гэж нэмж, 17.1.6 дахь заалтын “11.4” гэснийг “11.3” гэж, 17.2.5 дахь заалтын “явцад” гэснийг “үед” гэж өөрчилж, 17.2.1 дэх заалтын “байгууллагын” гэснийг, 17.2.3 дахь заалтыг төслөөс тус тус хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.3, 17.4 дэх хэсэг нэмэх:

“17.3.Суралцагч элссэн хөтөлбөрөөр суралцах хугацаандаа тухайн чиглэлийн мэргэжлийн бусад хөтөлбөрт суралцаж, хос мэргэжил эзэмшиж болно.

17.4.Суралцагч энэ хуулийн 17.3-т заасан ижил чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрт хамрагдах тохиолдолд сургалтын төлбөр төлөх бөгөөд тэтгэлгийг давхардуулан олгохгүй.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт явуулъя.

Одоо жендерийн мэдрэмжтэй орчинд ажиллана гэж байгаа юм. Тэгээд жендерийн мэдрэмжтэй орчин гэдгээ яаж тодорхойлох юм. Хууль дээр сүүлд нь. Яаж тэрийг нь мэдрэмжтэй байна уу, мэдрэмжгүй байна уу гэдгийг хэн шалгаж.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2.1 дэх заалтын “боловсруулахад оролцох” гэсний дараа “санал болгох” гэж, 19.3.6 дахь заалтын “дадлага

сургалтыг” гэсний дараа “байгаль орчинд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй” гэж нэмж, 19.3.7 дахь заалтын “дадлагажуулагч багшаар” гэснийг “дадлагажуулагчаар” гэж өөрчилж, 19.3.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 19.4, 19.5, 19.6 дахь хэсэг нэмэх:

“19.3.13.дагалдан суралцагчид Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлд заасны дагуу цалин хөлс олгох.

19.4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15.1.4, 15.1.5, 15.1.6, 15.1.9-д заасан зардал, дэмжлэг, хандивыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцуулж болно.

19.5.Аж ахуйн нэгж, байгууллага нь эдийн засгийн үйл ажиллагааны салбар, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогоос хамааран мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих санд энэ хуулийн 22.1-д заасан Зөвлөлийн тогтоосон хувь хэмжээгээр санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

19.6.Хосмог сургалт зохион байгуулсан тохиолдолд ажил олгогчоос болон ажилтнаас төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг Хөдөлмөрийн тухай хуулийн 63.3-т заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төлнө.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 20.2.1 дэх заалтыг доор

дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 20.2.4 дэх заалт нэмэх:

“20.1.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын мэдээллийн санг Боловсролын ерөнхий хуулийн 48.9-д заасан журмын дагуу бүрдүүлж ажиллуулна.

20.2.1.хөдөлмөрийн зах зээл дэх ур чадварын эрэлт, нийлүүлэлт, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлт, мөшгөх судалгаа, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны мэдээлэл;

20.2.4.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын, чадамжийн болон үнэлгээний мэдээлэл.”

Санал гаргасан Ажлын хэсэг.  
Санал хураалт. /алх цохив/

17 дугаар саналыг гүйцээн босгуулах чиглэл өгч байна. /алх цохив/

18.Төслийн 22 дугаар зүйлийн “Үндэсний зөвлөл” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл” гэж, 22.1 дэх хэсгийн “Үндэсний зөвлөл” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл /цаашид “зөвлөх” гэх/” гэж, 22.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн хэсгийн “бүрдэнэ” гэснийг “бүрдсэн нийт 15 гишүүнтэй байна” гэж, 22.3, 22.5 дахь хэсгийн “Засгийн газар” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 27.4-д заасан Үндэсний зөвлөл” гэж, 22.6 дахь хэсгийн “Засгийн газарт” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан Үндэсний зөвлөлд” гэж өөрчилж, төслийн 22.9.5 дахь заалтын “засгийн” гэсний дараа “эрэлттэй болон” гэж нэмж,

22.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Зөвлөлийн даргыг гишүүдийн олонхын саналаар томилогдсон этгээд хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан Ажлын хэсэг, Цэвэгдоржийн Туваан гишүүнээр тасаллаа.

**Ц.Туваан:** Энэ дээр би яах вэ, тэр юутай.

Түрүүн ажлын хэсгээс асуугаад хариулт авч чадаагүй. Энэ “түр сургалт” гээд асуудал байгаа юм.

Тэгээд энэ дээр гүйцээн боловсруулах гээд харж байсан чинь энэ чинь нөгөө юм салаалдаг, яам салаалдаг асуудал чинь энд дахих гэж байна.

Юу гэхээр одоо би энэ дээр тэр боловсролын хөдөө аж ахуйн институтийг тэр хөдөө аж ахуйн чиглэлийн сургалтын байгууллагуудыг Боловсролын яаманд байдгийг эсэргүүцдэг юм.

Ер нь салбар салбартаа баймаар байгаа юм. Тэгээд даанч дийлддэггүй юм. Хоёр удаа яваад, Байнгын хороогоор ороод дийлддэггүй юм.

Тэгээд ер нь яг салбартаа байсан нь зөв өө. Салбартаа байгаагүй тэр судалгааны байгууллага гэж юу ч хийдэггүй. Тэгээд л нэг тийм параличтай хүүхэд шиг ингээд хийж ч чадахгүй. Нөгөөдүүл нь яахгүй.

Тэгтэл яг үүнтэй адилхан дахиад энэ боловсролын хуулиар орж ирж байгаа юман дээр дахиад “түр сургалт” энэ тэрийг нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам руу аваад ингээд

салаалаад. Дахиад л хоёр эзэнтэй болоод эзэнгүй болно.

Тэгэхээр үүнийг хэдүүлээ нэг талдаа байж, арай гэж Хөдөлмөрийн яаманд байж байгаад Боловсролын яаманд ирээд нэг зүг чигээ олж байгаа юмыг салгамааргүй байна. Тийм. Энэ чинь ингээд салгаад ямар ч үр дүнгүй болдог юм шүү.

Х.Булгантуяа сайд аа. Энэ танайд авлаа гээд ч нэг их айхтар гоц гойд юм байхгүй. Нөгөө салаад тасраад ингээд алга болчихдог юм.

Тэгэхээр гүйцээн боловсруулах чиглэл дээр ажлын хэсэг, Байнгын хороон дарга Г.Мөнхцэцэг дарга та бас нэг анхаараад яг миний хэлж байгаа чиглэлээр үүнийг хам, нэг байлгах, салгахгүй байх. Овоо чигээ олоод явж байгаа юмыг ингээд дахиж салгаад л, дахиад л юу ч үгүй болгоно.

Тэгэхээр үүнийг цул байх гэдэг дээр нь, нэг харьяа байх гэдэг дээр нь анхаарч гүйцээн боловсруулалтуудаа энэ олон заалт дээр хийгээрэй.

Л.Энх-Амгалан сайд аа, Г.Дамдинням ажлын хэсгийн дарга аа. Ийм тодорхой санал гаргаж байна шүү.

### **Г.Занданшатар:**

Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Ц.Туваан байж бай даа. Өөрийн чинь хэлдэг юман дээр зүгээр би танин мэдэхүйн юм хэлж өгье.

Давхар ингээд хоёр эзэнтэй болно гэдэг чинь бас буруу ойлголт шүү. Давхар захирагдахаас буюу “субординацийн зарчим” гэж захиргааны юман дээр зарчим байдаг юм.

Шугаман хэвтээ удирдлага гэдгээс гадна ерөнхий удирдлагыг хэрэгжүүлдэг газар, цаад мэргэжлийн удирдлагын хослон хэрэгжих зарчим гэж байгаа юм. Хэвтээ шугаман огтлолцол дээр явдаг гэж.

Тэгэхээр манайхан ганц энэ хууль дээр биш. Ерөөсөө энэ удирдлагын юм бүгдээрээ л нэг эзэнтэй болгоно. Тэр лүү оруулна. Тэр яамаар хариуцна.

Боловсролын яам тэр стандартынхаа удирдлагаар орж ирэх байхгүй юу. Тэр удирдлага чинь. Нөгөө тэр хөдөө аж ахуй, эд нар аваад байхаар чинь тэр үйлдвэрлэл, салбарынхаа чиглэлээр ороод ирэхээр тэр дээр огтлолцох байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр ерөөсөө ийм байгаа юм. Журам, хүний нөөц, төсөв хөрөнгө, мэргэжил, арга зүйн сургалт, зөвлөгөөн гээд явахаар хэн хэнийг томилоод байгаа юм, хэн тэр төсөв, мөнгийг нь өгөөд байгаа юм, хэн мэргэжил, арга зүйн сургалт, зөвлөгөө, удирдамжаар хангаад байгаа юм, бодлогыг нь хэн гаргаад байгаа гэдгээрээ тэр хоёр удирдлага чинь дотроо салдаг байхгүй юу. Тэрийг “давхар захирагдах ёс” гэдэг юм.

Тэгэхээр “давхар захирагддаг хэлбэр” байдаг гэдгийг ойлгохгүй бол манай олон удаагийн хуралдаан дээр ярьж байгаа юман дээр нэг талд нь гаргана гээд давхиад байдаг байхгүй юу. Тийм юм байхгүй.

Тэр чинь бусад улс оронд ч тийм.

Жишээлбэл, Засаг дарга гэдэг бол улсын засаг төрийн ерөнхий удирдлагыг хэрэгжүүлж байхад тэнд хажууд нь боловсрол болон бусад салбарын удирдлагууд зэрэгцэн оршиж байдаг байхгүй юу. Тэр чинь хэвтээ шугаман

удирдлага огтлолцож байж тэндээ явж байгааг “давхар захирагдах ёс” гээд байгаа юм.

Тэгэхгүй “давхар захирагдах ёс”-ны энэ ойлголтыг уншиж судлаад тэгээд юмаа огтлолцуулахгүй бол. Түүнээс нэг талд нь гаргаж байна гээд шийдэх гээд оролдоод өөрсдөө өөрсдийнхөө салбарын ойлголтоор ойлгох юм бол энэ төрийн удирдлага чинь зөв болохгүй шүү. Энэ их олон юман дээр давтагдаж харагдаад байгаа шүү.

Түүрүүн тэр Төрийн албаны зөвлөл чинь юунаасаа орж ирдэг юм гэхээр төрийн албаны стандартын удирдлага талаасаа. Тэр журам гэдэг талаасаа орж ирдэг юм байдаг.

Тэр Төрийн албаны зөвлөлтэй хамтарч журмаа баталж болно, эсвэл Төрийн албаны зөвлөл өөрөө журмаа гаргаж болно.

Гэхдээ энэ дээр хамтын ажиллагаа манай Монгол Улсад чинь байхгүй болчихоод байгаа юм. Одоо энэ түгжрэл гээд байна шүү дээ. Одоо энэ түгжрэлийг чинь би энэ дээр хараад байна шүү дээ. Төрийн байгууллага болгон салангид удирдлагатай байгаад байгаа байхгүй юу. Гацаж байгаа. Гацаа чинь түгжрэл гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ гацчихсан байдлаа засах гээд л нэг даргад, эсвэл Л.Энх-Амгаланд өгнө, эсвэл Засаг даргад өгнө, эсвэл тэр яаманд өгнө гээд.

Үгүй шүү дээ. Энэ чинь хамтын ажиллагааных нь огтлолцол дээр явдаг эд байхгүй юу даа. Хамгийн гол нь журмаа хэн нь батлах юм, бодлогоо хэн нь гаргах юм, төсвөө хэн нь барих юм, хэн нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хурал зөвлөгөөнөө хийж байх юм, хэн нь

бодлогын удирдамж өгч байх юм гэдгээр энэ чинь өөр өөрсдөө ялгаатай байхгүй юу.

Тэгэхээр үүнийгээ бодолцохгүй бол олон юман дээрээс сая өнгөрсөн хуулиуд дээр ч тэр, одоо ч гэсэн энэ дээр ингээд л нэг яригдахад дандаа тийм юм байгаад байгаа шүү.

**Г.Занданшатар:** Үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

18-ыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө. /алх цохив/

Энэ байна шүү дээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эдийн засаг, хөгжлийн яам гурав энэ дээр саналаа нэгтгээд яг шигтгэсэн хувилбараа үзэж байж тохирохгүй бол энэ сүүлд нь маш маргаантай сэдэв болохоор байна.

Яагаад гэхээр хуучин Эдийн засаг, хөгжлийн сайд Үндэсний зөвлөлийг даргалах гэж байсан. Тэр байхгүй болж байна. Олонхын саналаар томилдог болж байна. Зөвлөлийн дарга.

Тэгээд энэ маань бас Засгийн газарт тайлагнахаа больж байна.

Тэгэхээр мэдээж “олон талт удирдлагын зарчим”, “субординац” энэ тэр хэрэгжүүлэх боловч энэ дээр бас нэг тийм төрийн өмчийн компаниудыг уг нь боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд санаачилж байгаа юм.

Тэгэхдээ **“төрийн захиргааны байгууллага”** байсныг **“төв байгууллага”** болгочхож байгаа юм. Бүгдийг нь яаман дээр аваад ирж. Энэ дээр чинь нэлээн тийм зөрчилтэй юмнууд үүсэхээр харагдаад байна.

Тийм учраас үүнийг бүхлээр нь яг энэ нөгөө удирдлагын асуудал байгаа учраас үүнийгээ Засгийн газрын түвшиндээ бараг тохирох ёстой асуудал байна шүү.

Дараагийн асуудалдаа.

19.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалтын “их сургууль, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, 23.1.4, 24.1.7 дахь заалтын “тусгай” гэснийг 23.1.8 дахь заалтын “энгийн” гэснийг, мөн зүйлийн 23.1.9 дэх заалтыг хасаж, доор дурдсан агуулгатай 23.1.10 дахь заалт нэмэх:

“23.1.10.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах.”

Санал гаргасан Ажлын хэсэг.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

**Д.Тогтохсүрэн:** Би энэ боловсролын салбарын томилгоотой холбоотой асуудал дээр л ер нь байнга үг хэлээд байгаа юм.

Тэгээд ажлын хэсэг авахгүй л байгаа юм л даа. Бид нарын ерөөсөө энэ шинэчлэлийн нэг нь боловсролын салбарт хамгийн их дампуураад байгаа юм юу байна вэ гэхээр энэ томилгооны асуудал байгаа юм.

Томилгоо нь улс төрөөс хамааралтай болчихоод тэгээд үүнээсээ болоод ойр ойрхон холигдож солигддог. Тэгээд энэ нь сургалтынхаа үйл

ажиллагаанд нөлөөлөл үзүүлээд байгаа юм.

Тийм учраас бид боловсролын салбарын томилгоог мэргэжлийн томилгоо руу оруулна гэдэг ийм л зарчим байгаа.

Тэгэхээр мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн байгууллага “**мэргэжлийн томилгоотой**” байх ёстой. Дээр нь “**төрийн захиргааны томилгоотой**” байх ёстой юм.

Тэгээд одоо энэ 23.1.10-аар нөгөө “**улс төрөөс хамааралтай**” болчихоод байгаа юм.

Тэгээд бид ийм л юм хийх ёстой байхгүй юу. Гурван юмыг манайхан энэ томилгоотой холбоотой асуудлаар бодох ёстой.

Нэгдүгээрт, хуулиар юу тавих вэ гэхээр тавигдах шаардлага л нарийн тавих ёстой. МСҮТ-ийн захирал ийм хүн байна гэдгээ. Тэр салбартаа ажилласан, ийм мэргэжлийн гэж. Сүүлийн үед энэ МСҮТ-ийн захирлууд мэргэжлийн бус болсон гээд л хүмүүс яриад байгаа юм.

Тэгэхээр бид энэ дээр нэгдүгээрт хуулиар тэр тавигдах шаардлагыг нь маш нарийн тавьж өгөх ёстой.

Хоёрдугаарт, сонгон шалгаруулалтыг Боловсролын яам өөрөө огт хийж болохгүй. Сонгон шалгаруулалтыг хийдэг байгууллага тэр Төрийн албаны зөвлөл гэж байна. Тэр л хийнэ.

Боловсролын салбар өөрөө юу өгөх вэ гэхээр Боловсролын сайд зөвхөн ажлын байрны тодорхойлолтоо л өгнө. Хуульд ийм шаардлага хангасан хүнийг томилно гэж байгаа. Хийх гэж байгаа

ажлынх нь чиг үүрэг энэ байна. Энд тохирсон хүнийг танайд сонгон шалгаруулж өгөөч ээ гээд л өгөх ёстой.

Ингэж байж наад томилгоо өөрөө мэргэжлийн томилгоо болох ёстой.

Дээр нь МСҮТ-ийнхээ томилж байгаа хүмүүсийг бодвол энэ хуульд байгаа байх даа. Хэн нь томилох юм? МСҮТ-ийн захирлуудыг. Аан...? ТУЗ бол ер нь тэгээд дампуурдсан томилгоо шүү дээ. Ер нь энэ ТУЗ-ийн томилгоо чинь. ТУЗ юм уу?

ТУЗ гэдэг байгууллага ер нь дампуурлын байгууллага шүү дээ. Би тэгж л боддог юм. Үүнийг юу гэдэг юм энэ төрийн захиргааны байгууллага л томилох ёстой.

Танай энэ мэргэжлийн боловсролын агентлаг гэж байна уу, үгүй юу? Энэ л томилох ёстой байхгүй юу. Тийм.

Түүнээс биш та нар үүнийг тэр ТУЗ-д аваачиж өгдөг бол тэгээд л буцаад л нөгөө дампуурал чинь хэвээрээ байхгүй юу.

Би томилгоон дээр ерөөсөө дахин дахин хэлээд байгаа нь тэр шүү дээ. Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлөөр хийлгэ. Ажлын байрны тодорхойлолтыг ажил олгогч буюу тэр сайд нь баталж өгдөг юм байгаа биз ээ.

Томилгоог нь дандаа ТЗ-гийн томилгоо буюу мэргэжлийн томилгоо хийлгэе л гээд байгаа юм шүү дээ. Тэр нь сургууль, цэцэрлэгүүдийг аймгийн боловсрол томил. Аймгийнхаа боловсролыг тэр боловсролын агентлаг нь томил.

Яг үүнтэй адилхан МСҮТ-ийг ялгаагүй тэр агентлаг нь томил. Ингэж байж энэ өөрөө мэргэжлийн чиглэл рүүгээ орно уу гэхээс биш мэргэжлийн биш хүн томилдог болоод л эхлэх юм бол тэгээд наад салбар чинь өөрөө дампуурчих байхгүй юу.

**Г.Занданшатар:** Тийм. Үүнийг Байнгын хороон дарга Г.Мөнхцэцэг гишүүн ээ, энэ чинь ерөөсөө зарчим нь мэргэжлийн болон техникийн сургалтын сангаас санхүүждэг болж байгаа шүү дээ. Тийм ээ.

Тэгээд төсвийн захирагч нь хэн мөнгөө төлж байна, хэн санхүүг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Х.Булгантуяа сайд үүнийгээ сайн үзэхгүй бол.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан чинь техникийн боловсролын сангийн нэг эх үүсвэр нь болж байгаа. Тэгээд томилгоо нь нэг ийм тусдаа, санхүүжилт нэг тусдаа, тэгээд төсвийг нь Улсын Их Хурал батална гэж байгаа юм. Энэ чинь төсвөөс гадуур батлах юм уу, төсөв дотроо батлах юм уу. Яах вэ, ямар ч байсан ингээд нэг батлагдах байх.

Тэгэхээр санхүүжилтийн зарчим, төсвийн удирдлага, санхүүжилтийн зарчим, захирагчийн зарчимтайгаа томилгооны зарчим уялдахгүй бол болохгүй л дээ.

Тэгэхээр сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дангаараа баталж болохгүй л дээ.

Үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. /алх цохив/

20.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “хүрээнд” гэсний дараа

“Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 24.1.7, 24.1.8 дахь заалт, 24.2 дахь хэсгийг нэмэх:

“24.1.7.багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг түншлэгч талуудтай хамтран зохион байгуулах;

24.1.8.багш, ажилтны мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, сунгах;

24.2.Энэ хуулийн 24.1.7-д заасан чиг үүргийг Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.

Х.Булгантуяа гишүүн үг хэлье.

Тэгээд энэ маань нөгөө үндэсний зөвлөл. Бас энэ санг. Зөвлөлөө ахиад хоёр хуваачихсан. Сургалт, техникийн боловсролын сан гээд.

**Х.Булгантуяа:** Дарга аа, энэ дээр таны хэлсэн яг зөв өө.

Засгийн газраас Боловсролын яам өргөн барихдаа “**мэргэжлийн боловсрол**” гэдэг утгаар нь энэ хуулийг өргөн барьсан юм билээ.

Ажлын хэсэг дээр “**мэргэжлийн сургалт**” гээд. Энэ хоёр чинь асар том ялгаатай шүү дээ. Мэргэжлийн боловсрол бол ахлах ангийн сүүлийн 3 жил дээр боловсрол олгоод, хажуугаар нь мэргэжил, дадлага олгох сургалт.

Мэргэжлийн сургалт гэхээрээ богино хугацааны жолооны курс, 30 хоногийн, 3 сарын сургалтууд.



Энэ хоёрыг нийлүүлээд бүгдийг нь Боловсролын яам одоо жишээлбэл жолооны курсийн асуудлыг хүртэл шийдэх болчихоод байгаа байхгүй юу. Уг нь энэ чинь аль аль нь хийх ажил ихтэй л баймаар юм.

Тэгэхээр энэ хоёрыг нийлүүлээд авч яваад. Энэ 20 дугаар дээр ч гэсэн танаас дахин боловсруулах.

Ажлын хэсэг, Байнгын хорооны дарга дэмжих байх. Санал авмаар байна.

Ер нь яах вэ, хэрвээ үнэнийг хэлэхэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дээр бид хийх ёстой гол нэг ажил нь шаардлагатай тохиолдолд иргэдийг дахин сургалтад хамруулж, чадавхжуулах ажлуудыг бид хийх ёстой юм билээ.

Тэр насны хүн МСҮТ-д дахиж сурна гэдэг хэцүү байж магадгүй. Тэр битгий хэл 40, 50 настай хүмүүс ч гэсэн дахин сургалтад хамрагдах эрхтэй шүү дээ.

Тэгэхэд заавал 3 жилийн МСҮТ-д сурч чадахгүй байхгүй юу. Амжихгүй байж магадгүй. Энэ чинь амь амьдралаа авч явж байгаа хүмүүс.

Харин 1 сарын, 3 сарын курст суугаад хөдөлмөр эрхлээд явах бид боломж, бололцоогоор нь чадавхыг нь дэмжих ажлыг өнөөдрийг болтол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр хийгээд явж байсан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан ч гэсэн үүнд оролцоод явж байсан. Тэгээд Тусгай сангийн тухай хуулийн 3.2 лүү сая Их Хурлын даргын хэлсэнчлэн ажлын хэсэг дээр шууд орохоор хуулийн зохицуулалтууд, зарчмын зөрүүтэй саналууд хийчихсэн байна л даа.

Тэгэхээр энэ дээр дахин боловсруулах чиглэл өгөөч ээ гэж хүсэж байна.

**Г.Занданшатар:** Ер нь яг ингээд цогцоор нь харахгүй бол мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын удирдлагын тогтолцоог гүйцээн боловсруулах чиглэл өгчихсөн юм шүү дээ.

Тэгээд энэ удирдлагын тогтолцооноосоо энэ бүхэн чинь уялдахгүй бол тэр “**Үндэсний зөвлөл**” маань орон тооны бус байгууллага. “**Үндэсний зөвлөл**”-ийг мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл, Үндэсний зөвлөл гээд бас хоёр салгачихлаа.

Эдгээрийгээ нэг цогцоор нь л харахгүй бол. Тэгээд Үндэсний зөвлөл маань эцсийн эцэст хариуцлага хүлээх үү? Энэ нөгөө төсөв, санхүүжилт, ажлын үр дүн, гүйцэтгэл, туслах аж ахуй гээд олон юмнуудын асуудал зохицуулагдаж байгаа учраас үүнийгээ нэг цогцоор нь сайн харах. Яамд хоорондын координац их сайн хэрэгтэй л юм байна.

Салбар дундын зохицуулалт болчихоод байгаа шүү. Гүйцээн боловсруулах чиглэл өглөө. /алх цохив/

Ер нь салбар дундын зохицуулалттай салбар шүү. Энэ. Одоо бүр шинжлэх ухаанууд хүртэл салбар дундынх болж байгаа шүү дээ.

21.Төслийн 25 дугаар зүйлийн “25.2.1-25.2.10” дахь заалтын дугаарлалтыг “25.1.1-25.1.10” гэж өөрчилж, мөн зүйлийн 25.2.9 дэх заалтыг хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

65.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчилж, төсөлд 26.5.3, 26.5.4, 26.5.5, 26.5.6 дахь заалт, 26.7 дахь хэсгийг нэмэх:

“26.4.Удирдах зөвлөл нь нийт арван нэгэн гишүүнтэй байх бөгөөд төрийн захиргааны төв байгууллагаас гурав, нутгийн захиргааны байгууллагаас гурав, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх нэг, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх гурав, суралцагчийн нэг төлөөллөөс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

26.5.3.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хуваарилалтыг батлах, үр дүн, чанар, гүйцэтгэлд хяналт тавих;

26.5.4.төсвийн хязгаарт нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, цалингийн санг тогтоох;

26.5.5.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг энэ хуулийн 23.1.10-т заасан журмын дагуу сонгон шалгаруулж, томилох, хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөх;

26.5.6.боловсролын сургалтын байгууллагын захиралтай байгуулсан гэрээг дүгнэх;

26.7.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын

сургууль, политехник коллежийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.”

Санал гаргасан Ажлын хэсэг.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлнэ.

**С.Ганбаатар:** Энэ мэргэжил сургалтын боловсрол уг нь 2012-2016 онд Боловсролын яаманд байхад нь бөөн юм болж байж л Хөдөлмөрийн яаманд аваачсан. Тодорхой үр дүн гарсан.

Боловсролын яаманд бүр ерөөсөө явахаа больчихлоо гээд л буцаад авч байсан.

Одоо яах вэ, энэ жил ингээд цогцоор нь реформ хийнэ гээд ингээд явж байгаа. Тэрийг нь дэмжилгүй яах вэ. Сайхан юм бодох ч ер нь хэнд ч гэсэн эрхтэй шүү дээ.

Тэгээд хамгийн гол миний хэлэх гээд байгаа юм гэвэл МСҮТ гэдэг чинь хөдөлмөрийн харилцаа болдог. МСҮТ гэдэг ажил олгогч эзэд, бизнесменүүдэд боловсон хүчнийг нь бэлдэж өгөх л ганцхан зорилготой. Хөдөлмөрийн яаманд байдгийн учир нь тэр.

Тэнд улсын гурван талт хэлэлцээр буюу ажил олгогч бизнес эрхлэгчдийн төлөөллийн байгууллага, тэр үйлдвэрчний, тэгээд захиргааны гэсэн, яамдын гэсэн ийм гурван талаасаа үүнийг удирддаг.

Тэгээд 26.4-д би хэд хэдэн санал хэлэх гээд байна. Энд бүр тэгээд шууд төрийн болгоод улс төржүүлсэн тийм захиргааны болгочихжээ.

11 хүний 6 нь захиргааных, 3 төрийн байгууллага, 3 нь орон нутгийн дарга нар. 6 дарга.

Цаана нь 5 хүн байгаа нь нэг нь нэг төгсөгчдийнх гээд байгаа. Нөгөө бизнес эрхлэгчдийн төлөөллийн байгууллагаас гэж байдаг болохоос биш энэ дотор чинь зүгээр компанийн. Таньдаг компаниасаа 3 хүн оруулаад л болоо.

Ингээд л гурилдвал МСҮТ шууд хувийн компани болно гэсэн үг. Энэ ямар ч.

Тэгэхээр энэ бол харин тухайн салбарын. Тэр оёмол, сүлжмэл байна уу, трактор, комбайны байна уу тухайн салбарын мэргэшсэн тэр ажил олгогч эздийн төлөөллийн байгууллагаас 3 хүн гэвэл энэ илүү мэргэшсэн, илүү хариуцлагатай болж эхэлнэ гэсэн олон улсын практикийг энд оруулах шаардлагатай байна.

Хоёрдугаар зүйл. Үгүй ээ, энэ Хөдөлмөрийн яамыг бүр үсгүй хусах нь ээ. Сүүлдээ бүр тэр богинын сургалтуудыг нь ч аваад хаячих юм.

Тэгэхээр энэ чинь эздийн холбоондоо юу хэлэх юм бэ? Тэр эзэддээ боловсон хүчин бэлдэж өгөх гээд байгаа шүү дээ. Бизнес эрхлэгчид энэ удирдах зөвлөл дээр ахиу орж байж сургалтын хөтөлбөрт нь ахиу ордог. Сургалтын хөтөлбөрт нь ахиу ороод чанар чансаанд нь ахиу орохоор тэр хүмүүс дараа нь энэ төгсөгчдийг чинь ажиллуулдаг, цалинжуулдаг тэр хүмүүсийг авдаг.

Тэгэхээр энэ асуудал жаргах замд нь садаа болчих болов уу, гай болчих болов уу гээд жоохон эмээж байгаа ч гэсэндээ үүнийг чинь буцаагаад гүйцээн боловсруулахад нь өгөх боломж байгаа

юу? Байвал их сайн байна. Өгөөгүй шүү. 22-ыг өгөөгүй байх. 22-ыг өгөөд тэгээд энэ ажлын хэсэг дээрээ нэг ярилцвал яасан юм.

Эцэст нь академик боловсрол, ЕБС<sub>[срөнхий боловсролын сургууль]</sub>, СӨБ<sub>[сургуулийн өмнөх боловсрол]</sub>. Энэ бол сургалтын ажил.

Харин МСҮТ<sub>[мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв]</sub> болон энэ богино зайн сургалтуудыг чинь “behavioral” гэж яриад байгаа шүү дээ. Бүр сүүлдээ.

Зүгээр тэр ажилчин хүнийг бэлдэх явдал шүү дээ. Мэргэшсэн, чадавхтай ажилчин хүнийг бэлдэх явдал гэдгийг битгий холиосой гэж бодож байна.

**Г.Занданшатар:** Энэ ингээд жаргах замд саад болсугай. Энэ “аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл” гэдгийг хэн сонгох юм. Энэ чинь мэргэжлийн холбоод нийт компанийн олонлогоо төлөөлөх хүмүүс байх ёстой болохоос биш тэгээд нэг компанийн төлөөлөл гээд найз хүн оруулчихлаа гэдэг. Тэгээд сүүлд нь энэ яг Хөгжлийн банк шиг асуудал болно.

Баахан хүн шоронгийн хаалга татах юм болно. Эрх мэдлийн хуваарилалтын онол гэж байна шүү дээ. Энд чинь.

Тэгээд ер нь олон талт оролцоонууд сонгон шалгаруулалт нь л буруу болбол асуудалтай болдгийг гашуун түүх нотолж байна.

Гүйцээн боловсруулах чиглэл өгнө. /алх цохив/

Ер нь олон нийтийн радио, телевиз, энэ гурван талт болон олон талтаар хийж байгаа юмнуудын сонгон шалгаруулалт нь зөв хийхгүй бол

нийгмийн даатгалын, эрүүл мэндийн даатгалын гурван талт зөвлөлүүд, бодит үр дүнгүүд ямар байгаа вэ гэж үзэж байгаа.

Тэгээд үүнийг сонгон шалгаруулалтын зарчим энэ тэрийг их зөв болгохгүй л бол, битүүлэг хийх юм бол энэ маш их эрсдэлтэй болно.

Эрх мэдэл, орон тоо, бүтэц, цалингийн сан тогтоохоос авхуулаад тодорхой эрх мэдэл өгчихнө шүү дээ.

23.Төслийн 27 дугаар зүйлийн 27.2.1 дэх заалтын “бакалавр” гэснийг “магистр” гэж, 27.2.2 дахь заалтын “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага” гэснийг “боловсролын сургалтын байгууллага” гэж, “10-аас” гэснийг “таваас” гэж, “сургалтын менежер, арга зүйч, тэнхимийн эрхлэгчээр 4-өөс” гэснийг “удирдах албан тушаалд гурваас” гэж өөрчилж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 27.5.12, 27.5.13, 27.5.14 дэх заалт нэмэх:

“27.5.12.гүйцэтгэлд суурилсан санхүүжилт, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос багш, ажилтныг урамшуулах, нийгмийн баталгааг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

27.5.13.Боловсролын ерөнхий хуулийн 12.9-д заасны дагуу багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах;

27.5.14.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т заасны дагуу батлагдсан төсвийн 0.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан

өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах.”

Санал гаргасан Ажлын хэсэг.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

**Д.Тогтохсүрэн:** Энэ боловсролын байгууллагын, сургалтын байгууллагын удирдах бүрэлдэхүүнд ажиллах хүн дээрээ тавигдах шаардлагаа бууруулаад тавьчихаж байгаа юм.

Орж ирэхдээ уг нь гайгүй ороод ирчихсэн юм байна шүү дээ. 10 жил байна. Тэр салбарт 10 жил ажилласан байна гэдгийг 5 болгочихлоо.

Сургалтын менежер, арга зүйч, тэнхимийн эрхлэгч гээд аягүй чухал мөст дээр карьерын зарчмаар дамжиж явна гэдгийг заагаад өгчихсөн байхад нь үүнийг нь бүгдийг нь байхгүй болгоод л ерөнхий нэг удирдах албан тушаал гээд л.

Тэгээд нийгмийн ажилтан ч юм уу, юу ч юм нэг юмаар жаахан байж байсан нөхөр л захирал болчих гээд байна шүү дээ. Наана чинь.

Уг нь орж ирэхдээ аягүй зөв ороод ирчихсэн байна шүү дээ. Сургалтын менежер, арга зүйч, тэнхимийн эрхлэгч гээд нөгөө шатлан дэвшихээр яваад ирчихсэн хүнийг шууд өөр юмаар солиод хаячхаж байгаа байхгүй юу.

Уг нь энэ хууль чинь анх орж ирэхдээ их зөв орж ирсэн байна шүү дээ.

Тэгээд бид үүнээсээ болоод л энэ салбарыг дампууруулаад байгаа байхгүй юу. Хуулиар тавих юм бол ерөөсөө удирдах ажилтан дээр энэ шалгуурыг л нарийн тавьж өгөх ёстой. Энэ шалгуураа үндэслэж ажлын байрны тодорхойлолтыг

нь зөв гаргах ёстой. Тэгээд сонгон шалгаруулалтыг нь тэр салбар нь биш Төрийн албаны зөвлөл зохион байгуулах ёстой.

Ингэж байж л томилгоо буюу энэ салбар өөрөө мэргэжлийн болох ёстой байхгүй юу. Тэгээд бид ингээд нэг аятайхан юм оруулж ирээд л тэгээд л явцын дунд нь дампууруулаад явчихлаа.

Тийм учраас би энэ заалтыг дэмжмээргүй байна. Бодвол энэ орж ирж байгаа хууль дээрээ их аятайхан заалт байсан байна. 10-аас доошгүй гээд. 10 жил сургалтын менежер, арга зүйч, тэнхимийн эрхлэгч гээд чухал заалтуудыг нь байхгүй болгоод тавьчихаж байгаа байхгүй юу.

**Г.Занданшатар:** Санал хураалт явуулья. Олонхын бүлгийн даргаас унагаах чиглэл өгч байна. Санал хураалт. /алх цохив/

Энэ санал дэмжигдсэнгүй.

Тэгэхдээ чиг үүрэг дээр байна шүү дээ 0.5 хувийг зарцуулна гэсэн тийм тодорхой эрх хэмжээ өгөх чинь болохгүй л дээ. Энэ сангийн хүрээнд.

24.Төслийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийг төслөөс хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Тийм. Энэ ч гэсэн бас унагаах ёстой л байсан юм байна. Сангийн яамны хяналтаас л гаргаж байгаа л юм байна.

Орлого, зарлагын журмыг Сангийн яам, Боловсролын яам хоёр хамтарч батална гэсэн юмыг хасаж байгаа юм.

25.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэснийг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө” гэж, 29.4.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 29.3.3, 29.3.4 дэх заалт нэмэх:

“29.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогын тодорхой хувь;

29.3.4.энэ хуулийн 19.4-т заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө.”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг хүчингүйд тооцъё. /алх цохив/

Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн үг хэлнэ.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсэг чинь бараг л хоёр жил хуралдлаа шүү дээ. Яг үнэнийг хэлэхэд.

Тэгээд хэчнээн ч удаа хуралдав. Сүүлдээ бүр юу ч болов. Зүгээр бие биедээ хүндэтгэлтэй хандаад, хэн нэгнийх нь эрх асуудлын хүрээ рүү хэрвээ өнгийж орсон зүйл, заалтууд оруулж байгаа бол тухайн яамнаас нь, эсвэл тухайн сайдад нь нэг мэдэгдчихвэл зүгээр л баярлах байна.

Би үүнийг бүгдийг нь авах гээд байгаадаа ч биш. Зүгээр бусад

хуулиудаараа, тусгай сангийн хууль гээд хуулиудаараа зохицуулагдсан зүйл, заалтууд байдаг юм

Тэгэхээр түрүүн Г.Занданшатар дарга түрүүн өмнөх заалт зүйл, заалт дээр дахин боловсруулах гэдэг чиглэл өгсөн. Үүнтэй адилхан дахин боловсруулах чиглэл авъя.

**Г.Занданшатар:** Сайд нар ер нь тэгээд. Сайдын ажил бол төр юм. Сан, мөнгөний асуудал бол мөнх юм гэдгийг л санаж байх хэрэгтэй.

Сангийг шууд хөрөнгө хуваарилахаар заачихаж байна шүү дээ. Хуваарилсан хөрөнгө гээд. Тэгээд яаж хуваарилах юм энэ тэр чинь дараа нь бөөн асуудал үүснэ. Хууль чинь хэрэгждэг байх ёстой.

Хуваарилсан хөрөнгө гэж байх юм уу? Нөгөөдөх нь сүүлдээ хэрэгжихгүй бол яах вэ? Тэр нь.

Энэ төсөл дээрээ сан гэж байгаа байхгүй юу. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зааснаас гадна эх үүсвэрээс бүрдэнэ гээд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гэж байгаа юм. Энэ чинь эх үүсвэрийг нь зааж байгаа шүү дээ. Тэгтэл ахиад нэг эх үүсвэр бий болгоод хуваарилсан хөрөнгө гэж эх үүсвэр болгодог чинь зөв юм уу л гэж.

Хоёр яам суугаад үүнийгээ гүйцээн боловсруул. /алх цохив/

Одоо хоёрхон санал үлдсэн байна. Тэгээд ер нь энэ олон хуулийг уялдуулна. Энэ бол ингээд олон энэ хуулийг хооронд нь уялдуулна. Ерөнхий хууль нь

гараагүй. Эд нартайгаа уялдуулна гэдэг бол хэцүү ажил гэдгийг ойлгож байна.

Тэгэхдээ энэ салбар дундын зохицуулалтын асуудал гэдгийг бид анхаарахгүй бол дараа нь хууль хэрэгжихгүй байхгүй юу. Бас хэрэгждэг хууль гаргах хэрэгтэй шүү дээ. Бид нар.

25.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих. Энэ сая хойшлуулчихсан.

26.Төслийн 33 дугаар зүйлийг төслөөс хасах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

33 дугаар зүйлийг хасчихаар чинь тэгээд хууль хүчин төгөлдөр болохгүй болчих юм.

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах.

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Энэ бол зөв санал байна.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүллээ.

Би энэ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооныхныг

боловсролтой, соёлтой, шинжлэх ухаанч, спортлог улсууд л гэж ойлгож байгаа шүү дээ.

Тэгж л ойлгож байна. Тэгээд л ойлгоцгоо.

---

**Найм.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн  
Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн  
шинэчилсэн найруулгын төсөл**

*/Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/*

---

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн эцсийн хэлэлцүүлгийг бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамд танилцуулна.

**Ч.Ундрам:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан цэцэрлэгийн багш, ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн болон биеийн тамирын багшийн өндөр насны тэтгэвэрт гарах насыг сонголттой болгох, цэцэрлэгүүдэд хөгжмийн багш дутагдалтай байгаа асуудлыг энэ хуулиар хэрхэн шийдвэрлэхээр зохион байгуулсан талаар, цэцэрлэгийн хүүхдүүдийн хоолны зардлын нормативт өөрчлөлт орох эсэх, уг асуудлыг хуулиар хэрхэн зохицуулж байгаа, хөдөө аж ахуйн салбарт ажилладаг өрхийн хүүхдийг 7 настай сургуульд элсүүлж болох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам ерөнхий боловсролын сургуульд судлах үндсэн гадаад хэл нь англи хэл байна гэсэн хуулийн төслийн заалтыг хэвээр үлдээх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн

тухай хуулийн 42 дугаар дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан хуулийн төслийн зарим зүйл, заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь үзсэн тул ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэн тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүд өмнөх хуулийн ажлын хэсэгтэй овог, нэр, ажил албан тушаал нэгэн адил.

Төрийн захиргааны байгууллага нь уг нь төр, хувийн хэвшлийн түншлэл, мэргэжлийн холбоотой хамтран ажиллах асуудлаа хариуцах юм билээ.

Тэгээд төрийн захиргааны байгууллага нь “төрийн захиргааны төв байгууллага” болчихоор илүү улс төрийн шинж чанартай болчихоод байна гэж гишүүд шүүмжлээд байна л даа.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 5 санал байгаа.

Энэ хатгагч, хамжигч гэдэг чинь ингээд бие биенийгээ. Г.Дамдинням гишүүн С.Одонтуяа гишүүнээр үг хэлүүлбэ гээд байхаар чинь хүний өмнөөс үг хэлэхгүй шүү дээ.

Та хоёрын үг ингэж. 6 цаг болчихлоо больчих юм уу.

Боловсролын ерөнхий хуультай хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтын “нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэснийг, мөн зүйлийн 17.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 17.1.5 дахь заалтын “сургуулийн” гэснийг “сургууль, дотуур байрын” гэж өөрчилж, 17.1.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих” гэсний өмнө “хамран сургах тойргийн хүүхэд бүрийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах, бүртгэх ажлыг зохион байгуулах” гэж, “сургалтын” гэсний дараа “үйл ажиллагааны” гэж, 17.1.5 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа



“эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.1.10, 17.1.11 дэх заалт, 17.7, 17.8 дахь хэсгийг нэмж, 17.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

17.1.8.боловсролын чанар, үр дүнг суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, нутгийн удирдах болон захиргааны байгууллагад тухайн хичээлийн жилд тайлагнах;

17.1.10.энэ хуулийн 18.8-д заасан байгууллагад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

17.1.11.Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар мэдээлэх;

17.7.Боловсролын ерөнхий хуулийн 10.2 дахь хэсэг, энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан үүргээ биелүүлээгүй суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны болон сэтгэл зүйчийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж болно. Шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд заасан үйлчилгээнд холбон зуучилж болно.

17.8.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээнд сургалтын төлбөр төлөх, хураамж авах харилцаанд багш, суралцагчийг оролцуулахыг хориглоно.”

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Боловсролын тэгш, хүртээмжтэй байдлыг алдагдуулж байгаа юм.

2.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “сургалтыг” гэснийг “сургалтыг бага, дунд, ахлах” гэж, 22.6 дахь хэсгийн “суралцах, хөдөлмөрийн зах зээлд шилжихэд” гэснийг “суралцахад” гэж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг хасаж, 22.3, 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 22.7, 22.8, 22.9 дэх хэсэг нэмэх:

“22.3.Ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч холимог бүлгээр хичээллэж болно.

22.5.Суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн орчинд дасан зохицох дэмжлэг үзүүлэх, сургалтын агуулгыг нөхөх зорилгоор энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт үйл ажиллагаа, нэмэлт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

22.7.Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 30.1.15-д заасан журмыг баримтлан зайн болон цахим сургалтыг зохион байгуулна.

22.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлтээр бага боловсролыг гэрийн сургалтаар эзэмшүүлж болох бөгөөд гэрийн сургалт зохион байгуулах, түүнд хяналт тавих журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийг “Цэцэрлэг” гэж, 19.1 дэх хэсгийн “хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/” гэснийг “Цэцэрлэг” гэж, 19.2 дахь хэсгийг 21.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.Сургалт, үйл ажиллагааг бага, дунд, ахлах болон бэлтгэл, холимог бүлгээр зохион байгуулна.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.Ерөнхий боловсролын сургуульд судлах үндсэн гадаад хэл нь энэ хуулийн 10.1-д заасан сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд туссан хэл байна.”

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

С.Одонтуяа гишүүн бид хоёрын санал эсрэг гарсан байна. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтыг хүчингүйд тооцъё. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

**Ц.Идэрбат:** Дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй.

**Г.Занданшатар:** Ц.Идэрбат гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

55.3 хувийн саналаар Ц.Идэрбат гишүүний гаргасан горимын санал дэмжигдэж, санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулъя.

55.3 хувийн саналаар санал дэмжигдлээ. 4 дүгээр санал дэмжигдлээ.

5.Төслийн 30 дугаар зүйлийг төслөөс хасах.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. /алх цохив/

63.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сургалтын өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлж байна.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын

бусад шийдвэрийн төслийн талаар чуулганы нэгдсэн хуралдаанд зарлан мэдээлье.

Монгол Улс Азийн хөгжлийн банк хоорондын аймаг, сум, бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл 6 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хуваарилсан.

Энэ ирэх долоо хоногт хэлэлцэх ёсгүй юу? Яаралтай биш үү?

Хоёр. Монгол Улсын 2022 оны төсвийн нэгдсэн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Төсвийн байнгын хороонд хуваарилсан.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас 6 сарын 23-ны

өдөр өргөн мэдүүлсэн. Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан.

Дөрөв. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас 6 сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн. Нийгмийн бодлогын байнгын хороонд хуваалсан.

Тав. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газраас 6 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн. Төсвийн байнгын хороонд хуваарилсан.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Засгийн газраас 6 дугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн. Нийгмийн бодлогын байнгын хороонд хуваарилсан байна.

Байнгын хороодын хуваарилалтыг мэдээллээ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

*Хуралдаан 5 цаг 59 минут үргэлжилж, 18 цаг 01 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**